

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООНЫ ЗУРАГЛАЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН
ТӨСӨЛ

Төсөл хэрэгжүүлэгч:

“Дэлхийн Зөн Монгол” олон улсын байгууллага



Гүйцэтгэгч:

“Тогтвортой хөгжлийн санаачилга” ТББ



Судлаачид:

Балжиннямын **Жавзанхүү**

Бүрнээбаатарын **Болорцэцэг**

Хүрэлбаатарын **Баасанжаргал**

Зандангийн **Баярхүү**

Санжаагийн **Гантуяа**

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ХУРААНГУЙ	6
1. Судалгааны аргачлал.....	11
2. Ерөнхий мэдээлэл	14
Монгол Улсын нийгэм эдийн засгийн нөхцөл байдал	14
Хүүхдийн нөхцөл байдал.....	17
Хүүхэд хамгааллын тулгамдаж буй асуудлууд	21
Хамгийн эмзэг бүлгийн хүүхдүүд	27
3. Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцооны бүтэц	31
Хүүхэд хамгааллын бодлого, эрх зүйн орчин.....	31
Хүүхэд хамгааллын үйлчилгээний бүтэц	37
4. Хүүхэд хамгааллын өнөөгийн нөхцөл байдал.....	44
Хүүхэд хамгаалалтай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилт	44
Хүүхэд хамгааллын үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэх механизм	48
Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч талуудын чадавх, нөөцийн хуваарилалт	60
Хүүхэд хамгааллын тогтолцооны хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалт ..	69
Хүүхдийн талаарх нийгмийн үзэл бодол, хандлага	74
Хүүхэд хамгааллын тогтолцоон дахь хүүхдийн оролцоо.....	76
Хүүхэд ба хууль	77
Хүүхдийн эсрэг хүн худалдаалах гэмт хэрэг	89
5. Дүгнэлт, санал зөвлөмж	94
5.1 Судалгааны үр дүн, дүгнэлт	94
5.2 Санал зөвлөмж	97
6. Хавсралт	103
6.1 Хавсралт-1 ГБХЗХГ-ын хуулиар хүлээсэн үүрэг.....	103
6.2 Хавсралт-2 Эрүүгийн хариуцлага хүлээх насны хязгаар гэмт хэргийн төрөл, ангилал, ялын хэмжээ, хохирол шаардсан байдлын харьцуулалт	105
6.3 Хавсралт-3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу гэмт хэргийн мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаагааны явц.....	107

График жагсаалт

График 1: Асуудлын мод, үл хайхрах хүчирхийлэл	22
График 2: Асуудлын мод, зодож шийтгэх	22
График 3: Асуудлын мод, үе тэнгийн дээрэлхэлт	23
График 4: Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын бүтэц, зохион байгуулалт	41
График 5: Хүүхэд хамгааллын үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэх механизм	48
График 6: Мөлжлөгийн хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд хохирогчийн талаар хандах, мэдээлэл хүргэх	49
График 7: Хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхэлдэг хүүхдэд үзүүлэх үйлчилгээ	49
График 8: Хүүхдийн тусламжийн 108 утасны төвийн дуудлагын тоо	52
График 9: Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага, төрлөөр	52
График 10: Нийт төсөвт эзлэх хувь	61
График 11: Хандив тусламжийн хэмжээ, сая төгрөг	61
График 12: ГБХЗХГ-ын 2019 оны 12 дугаар сарын санхүүжилтийн зарцуулалтын шилэн дансны мэдээлэл	62
График 13: ГБХЗХГ-ын 2020 оны 12 дугаар сарын санхүүжилтийн зарцуулалтын шилэн дансны мэдээлэл	63
График 14: 1-р үе шат, Гэмт хэргийн гомдол мэдээлэл шалгах ажиллагаа	79
График 15: 2-р үе шат, Хэрэг бүртгэлийн ажиллагаа	80
График 16: 3-р үе шат, мөрдөн байцаах ажиллагаа	81
График 17: 4-р үе шат, Прокурорын хяналт	82
График 18: 5-р үе шат, Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх	83
График 19: 6-р үе шат, Давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэх	84

Хүснэгт жагсаалт

Хүснэгт 1: Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд	15
Хүснэгт 2: Монгол улсын нэгдэн орсон гэрээний талаар	31
Хүснэгт 3: Үндэсний хуулиуд дахь хамгааллын зарим зохицуулалт	34
Хүснэгт 4: Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг хуулийн хэрэгжилтийг хангах хуульчилсан актууд	46
Хүснэгт 5: Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа 2020 онд	50
Хүснэгт 6: Хүүхэд хамгааллын төсөв (сая төгрөгөөр)	60
Хүснэгт 7: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсөв (сая төгрөгөөр)	63
Хүснэгт 8: Аймгийн ГБХЗХХ-ийн төсвийн зарцуулалт (төгрөгөөр)	64
Хүснэгт 9: Санхүүгийн эх үүсвэр	65
Хүснэгт 10: Хүүхэд хамгаалал болон хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр (мянган ам.доллар)	66
Хүснэгт 11: Шүүхээс өсвөр насны хүнд оногдуулсан ял, хариуцлага	87
Хүснэгт 12: Хүн худалдаалах гэмт хэргийн тоо баримт	89

Зургийн жагсаалт

Зураг 1: Монгол Улсын газрын зураг	14
--	----

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АХХД	Асран хамгаалагч, харгалзан дэмжигч
БСШУС	Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ГБХЗХБ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн байгууллага
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГБХЗХХ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс
ГХЗУСАЗЗ	Гэмт хэр, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГХЗУСАЗЗАА	Гэмт хэр, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба
ГХЗУСАЗЗСЗ	Гэмт хэр, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн салбар зөвлөл
ГХЯ	Гадаад хэргийн яам
ДЗМОУБ	Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГХА	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МУБИС	Монгол Улсын Боловсролын их сургууль
МУЗГ	Монгол Улсын засгийн газар
НГБХЗХГ	Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НҮБХЭХ	Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн эрхийн хороо
НХХ	Насанд хүрээгүй хүн
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
ОУБ	Олон улсын байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТХБ	Түр хамгаалах байр
УИХ	Улсын их хурал
УЕП	Улсын ерөнхий прокурор
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайд
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХТЗ	Хүүхдийн төлөө зөвлөл
ХТУ	Хүүхдийн тусламжийн утас
ХХША	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ХЭК	Хүүхдийн эрхийн конвенци
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭХЗХ	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ХУРААНГУЙ

Дэлхийн Зөн Монгол ОУБ (ДЗМОУБ), Азийн Сангаас хамтран хэрэгжүүлж байгаа Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн захиалгаар “Тогтвортой хөгжлийн санаачилга” ТББ-ын судлаачдын баг Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцооны өнөөгийн байдлыг эрх зүйн орчин, үйлчилгээ, чадавх, хариуцлагатай байдал, хамтын ажиллагаа, хүүхдийн оролцоо зэрэг дэд сэдвийн хүрээнд судлан нөхцөл байдлын үнэлгээг хийсэн болно.

Хүүхэд хамгааллын хууль, тогтоомжийн хэрэгжилт

- Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн болон Зөрчлийн тухай шинэ хууль болон шинэчилсэн найруулгууд нь хүүхэд хамгааллын өнөөгийн тогтолцоог бэхжүүлэх эрх зүйн орчины шинэ нөхцөл бий болсон. Тиймээс 2016 оноос хойш хүүхэд хамгааллын тогтолцоонд Хүүхдийн тусламжийн утас, Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хүүхдийн эрхийн улсын байцаагч зэрэг олон үйлчилгээ үзүүлэгч талууд нэмэгдсэн нь сайшаалтай.
- Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болсон бөгөөд хүүхэд хамгааллын тогтолцоонд Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь голлох байр суурьтай байна. Хэдийгээр хүүхэд хамгааллын тогтолцоонд олон талын оролцоо чухал үүрэгтэй боловч өнөөгийн хүүхэд хамгааллын тогтолцоонд эдгээр талуудын хамтын ажиллагаа, нэгдмэл алсын хараа дутагдаж байна.
- Хүүхэд хамгааллын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад хүүхэд хамгааллын мэргэшсэн хүний нөөц дутмаг, чадавх сул, хамтын ажиллагаа болон салбарын хоорондын зохицуулалт хангалтгүй байгаа нь хүүхдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, оновчтой болгох, стандартчилах шаардлагатайг харуулж байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний механизм, чанар, хүртээмж

- Хүүхэд хамгааллын өнөөгийн тогтолцоонд анхан шатны нэгжид хүүхэд хамгааллын ажилтан байдаггүй. Хамтарсан баг болон Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд, Хүүхдийн эрхийн улсын байцаагч нар нь өөрийн үндсэн ажил дээр нэмэлтээр хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үүргийг хүлээж байна. Эдгээр талуудын ажил үүргийн хуваарьт хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх талаар шинээр үүрэг нэмж оруулаагүй, нэмэлт цалин урамшуулалгүй, үйл ажиллагааны зардалгүй, чадавх бэхжүүлэх болон мэргэжлийн дэмжлэг тусалцаа хязгаарлагдмал байдлаар сүүлийн дөрвөн жил ажилласан байна.
- Өнгөрсөн 5 жилийн хугацаанд ГБХЗХБ, орон нутгийн цагдаагийн байгууллагын дэргэд зарим олон улсын байгууллагын дэмжлэгээр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны тоо нэмэгдсэн нь сайшаалтай. Гэвч үйлчилгээ нарийвчлан тодорхойлж, хүртээмжийг нэмэгдүүлэн, хүний нөөцийг чадавхжуулан, хохирогч төвтэй үйлчилгээг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

- Хүүхэд хамгааллын тогтолцоонд мэдээллийн удирдлагын нэгдсэн систем байхгүйгээс хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдээллийг цаг тухай бүрд нь үйлчилгээ үзүүлэгч бусад талтай хуваалцах, кэйсийн үр дүнг үнэлэх, дараагийн үйлчилгээг оновчтой төлөвлөх, үйлчилгээний үр дүнг үнэлэхэд бэрхшээлтэй байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч талуудын чадавх, нөөц

- 2017 оноос хойш хүүхэд хамгааллын үйлчилгээний зориулалттай улсын төсөв тасралтгүй нэмэгдэж, 2020 болон 2021 оны байдлаар 8 тэрбум төгрөг байна. Хүүхэд хамгааллын төсвийн мэдээлэл, төсвийн зориулалт, санхүүжилтийн үр дүнгийн талаарх мэдээлэл ил тод биш байна. Цаашид хүүхэд хамгааллын санхүүжилтийн нарийн төлөвлөлт, зарцуулалтын зориулалт, ангилал болон ил тод байдал зэргийг нарийвчилсан эрх зүйн баримт бичиг гарах шаардлагатай байна.
- ГБХЗХГ-ын харьяа Сургалт, судалгаа, мэдээллийн төв нь хүүхэд хамгааллын талаарх судалгаа, үнэлгээгээр үр дүнд суурилсан бодлого төлөвлөлтийн үндэслэлийг тодруулах, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хүний нөөцийг чадавхийг бэхжүүлэх үүргийг Хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомжоор хүлээж байгаа хэдий ч үйл ажиллагааг нь сайжруулах хэрэгцээтэй байна.
- Хүүхэд хамгааллын тогтолцооны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд нийгмийн ажилтныг хүүхэд хамгааллын тухайлсан асуудлаар нарийвчлан мэргэших, мэргэжил дээшлүүлэх, карьер төлөвлөлтийг тодорхой болгох, мэргэжлийн зэрэг олгох, лицензжүүлэх, цалин, урамшуулалыг шатлалтайгаар нэмэгдүүлэх хүний нөөцийн цогц тогтолцоог бий болгох хэрэгтэй байна.

Хүүхэд хамгааллын тогтолцооны хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалт

- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл болон, аймаг нийслэл, сум дүүргийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын тогтолцооны салбар дундын зохицуулалтыг ханган ажиллах үүргийг хуулиар хүлээсэн. Уг зөвлөлүүд жилд дунджаар хоёроос дөрвөн удаа хуралдах байдлаар салбар дундын хамтын ажиллагааг хангаж ажиллаж чадахгүй юм.
- Хүүхэд хамгааллын тогтолцоонд боловсрол, эрүүл мэндийн салбарын оролцоо хамтын ажиллагаа чухал үүрэгтэй бөгөөд эдгээр салбаруудын хүүхэд хамгааллын бодлогыг боловсронгуй болгох, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, хүүхэд хамгаалалд зориулсан төсөвтэй болгох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.
- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүүхэд хамгааллын үйлчилгээ, судалгаа, үнэлгээний чиглэлээр ТББ, мэргэжлийн байгууллага, их дээд сургуулиудтай ажиллах хамтын ажиллагааг өргөжүүлэх зайлшгүй хэрэгтэй юм. Цаашлаад хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ОУБ, донор байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг үр дүнтэй зарцуулахад тус байгууллагын манлайлал чухал үүрэгтэй юм.

Хүүхдийн хамгааллын тулгамдсан асуудлууд

- Тус судалгаанд оролцсон хүүхдүүд, үйлчилгээ үзүүлэгч, үүрэг хүлээгчдийн зүгээс хүүхдийг үл хайхрах хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт, хүүхдийг зодож шийтгэх явдал хүүхэд хамгааллын зонхилох асуудал хэмээн тодорхойлсон нь өмнөх жилүүдэд хийгдсэн бусад судалгааны үр дүнтэй ижил байна. Мөн хүүхдийн эрхийн зөрчилд орон нутгийн онцлог, хүйс, нийгмийн байдлаар ялгаварлан гадуурхах асуудал амь бөх байсаар байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнхийн, хөдөлмөр эрхэлдэг, бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдүүдэд хэрэгцээнд нийцсэн хариу үйлчилгээ өнөөгийн хүүхэд хамгааллын тогтолцоонд үгүйлэгдсэн хэвээр байна. Хөгжлийн бэрхшээлтэй болон үндэсний цөөнхийн хүүхдүүдэд хүртээмжтэй байдлаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж чадахгүй байна.
- Ковид-19 цар тахлын нөлөө хүүхдийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, улмаар хүүхдийн эрхийн зөрчил, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэгч хүүхдийн тоо нэмэгдсэн байна. Засгийн газраас цар тахлын хямралыг даван туулахад дэмжлэг болгон улсаас хүүхдэд олгодог халамжийн мөнгийг нэмэгдүүлсэн байна.
- Хүүхэд хамгааллын тогтолцоонд хүүхдийн оролцоог бодитой хангах механизм, мэдлэг, хандлага, чадвар, дадал үгүйлэгдэж хүүхэдтэй холбоотой шийдвэрийг насанд хүрэгчид, үйлчилгээ үзүүлэгчид хүүхдийн өмнөөс нь гарган хүүхдийн дээд эрх ашгийг ханган ажиллаж чадахгүй байна. Цаашид хүүхдийн оролцоог бодитой болгох, хүүхдийн амьдрах ур ухаан, зөөлөн чадвар, даван туулах чадавхийг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тэгш, хүртээмжтэй байдлаар зохион байгуулах хэрэгцээ нэмэгдсээр байна.

Хүүхэд ба хууль

- Хууль зөрчсөн хүүхэдтэй холбоотой эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх зарим ажиллагаанд хүүхдийн эрхийг хамгаалах талаар зохицуулалт байхгүйн улмаас хүүхдийн эрх ноцтой зөрчигдөж байна. Тухайлбал гэмт хэргийн талаар гомдол мэдээллийг хүлээн авч шалгах ажиллагаанд хүүхдээс “гэрч”-ийн мэдүүлэг авдаг тул уг нотлох баримт нь цаашид хэргийг шийдвэрлэхэд хүүхдийн эсрэг нотлох баримт болж байна. Тиймээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тус бүрд хүүхэд оролцох тохиолдолд хэрхэн хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.
- Насанд хүрэгчид болон хүүхдэд ял оногдуулахдаа ялгамжтай хандах, тэр дундаа хүүхэд гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсон тохиолдолд аль болох хорих ял оногдуулахгүй байх, бусад төрлийн хариуцлагын арга хэмжээг шүүхээс сонгож хэрэглэдэг байх шаардлагатай байна. Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс ирүүлсэн мэдээлэлд Эрүүгийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэрэгт үйлдсэн насанд хүрэгчдэд “тэнсэн харгалзах ял” оногдуулдаг атлаа яг ижил төрлийн гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн бүх хүүхдэд “хорих” ял оногдуулж байгаа нь харамсалтай.
- Иргэний хэрэг маргаан, тэр дундаа гэр бүл цуцалтыг шийдвэрлэхдээ хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн хөндөгддөг, шүүхээс хэрхэн шийдвэрлэсэн талаар тоон мэдээлэл байхгүй, эцэг эсвэл эхийн хэн нэгний асрамжид хүүхэд шилжсэн үед тухайн хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах талаар хяналтын тогтолцоо огт байхгүй байна. Мөн долоо ба түүнээс дээш насны хүүхдийн саналыг авна гэж байгаа боловч хуулиар уг саналыг хэрхэн авах, ямар этгээдийг байлцуулах, энэ ажиллагаанд хүүхдийн эрхийг хэрхэн хангах талаар зохицуулалтгүй хэвээр байна. Тиймээс иргэний хэрэг маргаан дахь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын талаар мэдээллийг гаргадаг байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийг хамгаалах зохицуулалтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нарийвчлан оруулах шаардлагатай.
- Улсын хэмжээнд 2019 оны 1,068 хүүхэд, 2020 онд 811 хүүхэд гэмт хэрэгт холбогдсоноос Улаанбаатар хотод 2019 онд 649 хүүхэд, 2020 онд 558 хүүхэд гэмт хэрэгт холбогдож байгаа тул нийслэл хотын хэмжээнд энэ төрлийн хэргийг мөрдөн

шалгадаг, хянан шийдвэрлэх дагнасан шүүхийг бий болгох зайлшгүй шаардлагатай байна. Зөвхөн хүүхэд холбогдсон төдийгүй хохирогч хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдний хохирлыг барагдуулах үндэсний тогтолцоо бий болгоход дагнасан субъектийн үүрэг онцгой хувь нэмэр оруулна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед зөвхөн “хорих ял шийтгүүлсэн” өсвөр насны ялтантай холбоотой зохицуулалт үйлчилж байгаа ба бусад төрлийн ял шийтгэл эдэлж байгаа хүүхэдтэй холбоотой ямар ч нарийвчилсан зохицуулалт байхгүй, насанд хүрэгч нартай адил хяналтын тогтолцоо ажиллаж байна. Тиймээс хүүхэд хууль зөрчсөнөөс эхлээд тохирох хариуцлага хүлээлгэх, түүнд хяналт тавих хүртэл бүхий л шатанд хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцоог бий болгох, хууль хяналтын байгууллагын шатанд хүүхдийн эрхийн зөрчил гардаг нөхцөлийг таслан зогсоох сорилттой нүүр тулж байна.

1. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ



1. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

1. ДЗМОУБ, Азийн Сангаас хамтран хэрэгжүүлж байгаа Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн хүрээнд Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоонд зураглал, үнэлгээ хийхээр төлөвлөсөн билээ. Энэ удаагийн зураглалаар хүүхэд хамгааллын тогтолцоог эрх зүйн орчин, үйлчилгээ, чадавх, хамтын ажиллагаа, хариуцлагатай байдал, хүүхэд хамгааллын үйлчилгээний механизм, хүүхдийн амьдрах ухаан, даван туулан чадвар, оролцоо зэрэг дэд сэдвийн хүрээнд үндэсний болон орон нутгийн нөхцөл байдлыг судалсан болно. Судалгааг ГБХЗХГ, төслийн баг, ДЗМОУБ, зөвлөх багийн бүрэлдэхүүнтэй ажлыг хэсэг чиглүүлж ажилласан юм. Зөвлөх баг болох “Тогтвортой хөгжлийн санаачилга” ТББ нь судалгааны мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ, тайлан боловсруулах ажлыг гүйцэтгэсэн болно.

2. Судалгаанд хүүхэд хамгааллын тулгамдаж буй асуудлыг илрүүлж, эрэмбэлэн, урьдач нөхцөлийг нь шинжлэх зорилготой ДЗОУБ-ын АДАПТ (Analyse Design and Action Planning) аргачлалыг ашигласан бөгөөд тус аргачлалын дагуу Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоог шинжлэхэд дараах зорилтыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдал, хууль эрх зүйн тогтолцоо, засаглал, хүүхэд хамгааллын тогтолцооны давуу болон сул талыг тодорхойлох;
- Хүүхэд хамгааллын тулгамдсан асуудлууд, түүний шалтгаан нөхцөл, хамгийн эмзэг бүлгийн хүүхдүүдийг тодорхойлох, хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл, үр нөлөөг шинжлэх;
- Гэмт хэргийн гэрч, хохирогч болон хэрэгт холбогдсон, хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох, ялангуяа хүүхдэд ээлтэй шударга ёсны тогтолцоог судлах;
- Хүүхэд хамгааллын тогтолцооны албан болон албан бус хэлбэрийн уялдаа, оролцогч талуудын чадавх, нөөц, хамтын ажиллагаа, үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үзүүлж буй үйлчилгээг тодорхойлох зэрэг болно.

3. Судалгаанд хүн амын нягтрал, газар зүйн байршил, хилийн боомт, эрсдэлийн хүчин зүйлсийг харгалзан Улаанбаатар хотын гурван дүүрэг (Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар), дөрвөн аймгийг (Баян-Өлгий, Хэнтий, Өмнөговь, Сэлэнгэ) сонгон хамрууллаа. Судалгааны аргачлалын дагуу баримт бичгийн судалгааг хууль, тогтоомж, бодлого, журам, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө, судалгаа, үнэлгээний тайлан, статистикийн мэдээлэл дээр явуулж тоон судалгааны үр дүнг чанарын судалгааны үр дүнгээр баталгаажуулах зарчмаар дараах оролцогч талуудаас ярилцлага авсан. Үүнд:

- Яам, агентлаг, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, үйлчилгээ үзүүлэгч 30 байгууллагын төлөөлөлтэй хагас бүтэцчилсэн ярилцлага;
- Аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Хүүхдийн зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Цагдаагийн хэлтэс, шүүх, прокурор, өмгөөлөх байгууллага, сургууль гэх мэт 23 төлөөлөлтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага;
- Сонгосон орон нутгийн өсвөр насны охид, хөвгүүд, эцэг эх, асрах хамгаалагч, Хамтарсан багийн гишүүдтэй (нийт 128 оролцогчтой) 17 удаагийн бүлгийн ярилцлага тус тус хийсэн.

4. Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор судалгааны баг хөдөө орон нутагт ажиллах боломжгүй байсан тул чанарын судалгааны мэдээллийг хөдөө орон нутгийн оролцогчдоос цахимаар авсан болно. Цахим уулзалтаар ярилцагчдын нэр, царайг нууцлан авсан учир судалгаанд оролцогч хүүхэд, эцэг эх/ асран хамгаалагч, Хамтарсан багуудын гишүүд ярилцлагын үеэр мэдээллийг нээлттэй өгч байсан нь давуу талтай байлаа. Ганцаарчилсан ярилцлага болон бүлгийн ярилцлагын мэдээллийг чанарын судалгааны шинжилгээний Nvivo програм дээр нэгтгэж хөрвүүлсэн бөгөөд тоон судалгааны зарим үр дүнг SPSS нэгтгэн тус аргачлалаар өгөгдсөн зааврын дагуу дүн шинжилгээ хийн үр дүнг тус тайландаа ашигласан болно.

5. Тус судалгааны дүгнэлт, зөвлөмж нь судлаачид, судалгааны баг, захиалагч байгууллагын байр суурь, үзэл бодлыг илэрхийлээгүй бөгөөд зөвхөн чанарын болон тоон судалгааны үр дүн суурилсан болно.

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ




2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

6. Монгол Улс Ази тивийн төвд, хойд талаараа Оросын Холбооны улстай, өмнөд талаараа Бүгд Найрамдах Хятад Ард улстай хиллэн оршдог. Монгол орон нь цаг уур, эх газрын эрс тэс, хатуу ширүүн цаг уурын нөхцөлтэй бөгөөд өвөл нь урт, -40 хэм хүртэл хүйтэрдэг бол зун нь богино, +30 хэм хүртэл халах нь энгийн үзэгдэл. Монгол Улс засаг захиргааны хувьд 21 аймагт, аймагууд нь 330 сумдад; сум нь 1639 багт; нийслэл нь 9 дүүрэгт, дүүрэг нь 169 хороодод хуваагддаг. Монгол улс парламентын засаглалтай бөгөөд төрийн тэргүүн нь ерөнхийлөгч, засгийн газрын танхимын зарчмаар ажилладаг, тэргүүн нь Ерөнхий сайд.

7. Монгол Улсын хүн амын тоо 2020 оны эцэст 3,357,542 болж өмнөх оноос 1.8 пунктээр өссөн. Монгол Улсын нийт хүн амын 49.1 хувь нь эрэгтэй, 50.9 хувь нь эмэгтэй. Хүн амын 38.2 хувийг 0-18 хүртэл насны хүүхэд (0-4 хүртэлх насны хүн ам 11.3 хувь, 5-9 насны хүн ам 11.5 хувь, 10-14 насны хүн ам 8.9 хувь, 15-19 хүртэлх насны хүн ам 6.5 хувь) эзэлж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад оршин суугаа нийт хүн амын 47.5 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 52.4 хувь нь хөдөө, орон нутагт амьдарч байна. Тус судалгааны зорилтот нэгж Баян-Өлгий аймагт нийт хүн амын 3.2 хувь, Өмнөговь аймагт 2.1 хувь, Сэлэнгэ аймагт 3.2 хувь, Хэнтий аймагт 2.3 хувь хүн ам байна.¹

Зураг 1: Монгол Улсын газрын зураг



8. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг олон зууны туршид эрхэлж ирсэн малчид нь Монгол орны нүүдлийн соёл иргэншил, түүх, өв соёлыг тээгч, бүтээгчийн хувьд нийгэм, эдийн засгийн томоохон давхарга юм. Монгол Улсын нийт хүн амын 19.4 хувь нь буюу 617.3 мянган хүн малчин өрхөд амьдарч, ажиллах хүчний 26.7 хувийг малчид бүрдүүлж, нийт өрхийн 25.8хувийг малтай өрх, үүний 73.5 хувийг малчин өрх эзэлж байна. 1990 оноос эхэлсэн чөлөөт эдийн засгийн хурдацтай шилжилтээс хойш хот суурин руу чиглэх шилжин суурьших хөдөлгөөн тасралтгүй үргэлжлэх болсон. Монгол Улсын дотоодын шилжих хөдөлгөөн 2000 оноос хойш эрчимжиж, хүн амын 46 хувь нь Улаанбаатар хотод

¹ YCX. 2020. Монгол улсын хүн амын тоо, насны бүлгээр, аймаг нийслэлээр

амьдарч байна. Хөдөө орон нутаг эзгүйрч, сумын хөгжил удаашрах, хот хөдөөгийн ялгаа нэмэгдэх хандлага хэвээр байна.²

9. Монгол Улс нь бага-дунд орлоготой, далайд гарцгүй, байгалийн баялаг ихтэй, шилжилтийн шатанд яваа нээлттэй эдийн засаг бүхий улс. Олон арван жил үргэлжилсэн төвлөрсөн төлөвлөгөөт социалист эдийн засгийн системийн дараа, 1990 оноос чөлөөт зах зээлийн системд шилжих маш хүнд давааг үнийн огцом чөлөөлөлт, өмч хувьчлал, мөнгөний ханш уналт зэргийг давсан билээ. Уул уурхай (алт, зэс, нүүрс г.м) сүүлийн жилүүдэд улсын эдийн засгийн гол салбар болов. Эдгээр байгалийн баялаг эдүгээ нийт экспортын 69.4 орчим хувийг бүрдүүлж байна.³ Гэсэн хэдий ч газар тариалан, мал аж ахуй (тэр дундаа уламжлалт мал аж ахуй)- Монгол Улсын эдийн засаг, нийгмийн чухал хэсэг хэвээр байгаа. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1: Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2018	2019	2020
Инфляци	6.8	7.3	3.7
Нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн	11,916	12,310	11,459.5
Ажилгүйдэл	6.3	6.0	
Хүний хөгжлийн индекс	0.735	0.737	*
Жендэрийн тэгш бус байдлын индекс	0.322	0.322	*
Дундаж наслалт эрэгтэй эмэгтэй	65.6	65.8	66.7
	74.0	74.1	76.2

Эх сурвалж: Human Development Report-2020 / <http://hdr.undp.org/en/2020-report/>, YCX. www.1212.mn

*Мэдээлэл хараахан гараагүй

10. **Хүүхэд хамгаалал ба ковид-19 цар тахал:** 2021 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн байдлаар нийт короновируст халдвар батлагдсан тохиолдол 166,215 байгаагийн 21.8 хувь нь хүүхэд, нийт баралт 823 байна.⁴ Мөн өдрийн байдлаар улсын хэмжээнд вакцинжуулалтын эхний тунд хамрагдсан иргэдийн тоо 2,178,913 (67 хувь) давтан тунд хамрагдсан 1,983,005 (61 хувь) иргэн байна.⁵ Цар тахлын нөхцөлд Засгийн газраас хүүхэд хамгааллыг сайжруулах чиглэлээр бодлогын шийдвэрүүдийг гарган ажилласан байна. Тухайлбал Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам” баталж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/257 дугаар тушаалаар Хүүхэд хамгааллын салбар дундын бүлэг байгуулсан байна. Түүнчлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны

² Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага. 2018. *Монгол Улс: хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа*. Улаанбаатар

³ YCX.2020. *Экспортын бараа бүтээгдэхүүн бараа бүлэг, жилээр*
https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1400_005V1

⁴ Эрүүл мэндийн яам. 2021. Монгол улс дахь короновируст халдварын нөхцөл байдлын мэдээ. <https://covid19.mohs.mn/p/cat/post/57/> (2021 оны 5 сарын 22-нд мэдээллийг авав)

⁵ IKON.mn мэдээн вэбсайт. <https://visual.ikon.mn/covid-19> (2021 оны 5 сарын 30-нд мэдээллийг авав)

“Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай” 01, 02 дугаар албан даалгавар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайд хамтран “Гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний удирдамж, төлөвлөгөө”-г тус тус баталж, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын салбар дундын бүлгийн бэлэн байдал, арга хэмжээний төлөвлөлтийг боловсруулж ажиллажээ.⁶

11. Ковид-19 цар тахлаас үүдсэн нийгэм эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн Газар 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс сар бүр олгодог хүүхдийн тэтгэмж болох 20,000 төгрөгийг 100,000 төгрөг болгон мөн хүнсний талон, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгодог тэтгэмжийг хоёр дахин нэмэгдүүлсэн байна. 2020 оны 4-р сард Монгол Улсын иргэн бүрд 300,000 төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосон юм. Ярилцлагын үеэр хүүхдэд олгох тэтгэмжийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор ХТУ-108 болон ГБХЗХХ-үүдэд хүүхдийн мөнгөний зарцуулалт, асран хамгаалагчийн хайхрамжгүй байдалтай холбоотой дуудлага өсчээ.

12. Ковид-19 цар тахлын үед аймаг, дүүрэг дэх ГБХЗХХ, сургууль, эрүүл мэндийн байгууллага, ОУБ-ууд хамтран эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн гэрээр нь хүнсний тусламж хүргэх замаар хүүхдийн нөхцөл байдалд давхар хяналт хийх, эцэг эх, асран хамгаалагч нь ковид-19 өвчний улмаас эмнэлэгт эмчлүүлж байгаа өрхийн хүүхдэд түр асран хамгаалагч тогтоон хяналт тавих зэргээр ажилласныг ОУБ-ын төлөөлөл, сургууль, ГБХЗХХ, аймаг, дүүргийн хүүхдийн зөвлөлүүдтэй уулзсан ярилцлагаар дурдаж байв.

8 хүүхэдтэй айлд өдөр нэг цагийн үед очиход эцэг эх нь дөнгөж босож байв. Гэрт гал түлэх түлээгүй тул хүйтэн, хүүхдүүд нимгэн хөнжилд хэвтэж байгаа нь өрөвдмөөр. Би хүүхдүүдээс онлайн хичээлдээ хамрагдаж байгааг асуухад чаддаггүй гэж байв. Харин эцэг эхээс нь яаж амьдарч байна гэж асуухад 8 хүүхдийн (сард нэг хүүхдэд нэг зуун мянган төгрөг) 800 мянгаар амьдардаг гэв. Хүүхдийн хэрэгцээнд зориулах 100 мянган төгрөгөөр утас, интернеттэй болгоод хичээлд нь оруулах бодол санаагүй өдий хүрчээ.

Эцэг эхийн ярилцлагаас

13. Цар тахлын үед ХТУ-108, Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагын 107 утас, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Итгэлтэй утас зэрэгт хандсан хүчирхийллийн дуудлагын тоо, ТХБ, НЦҮТ-өөр үйлчлүүлэгчдийн тоо өссөн нь гэр бүлийн орчинд хүүхдийн эрх хамгийн их зөрчигдөж байгааг харуулж байна.⁷ Мөн түүнчлэн, 2021 оны Үндэсний Статистикийн хороо (ҮСХ), НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтран гүйцэтгэсэн Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд оролцогч өрхийн 61 хувь нь цар тахлын үед ажиллах боломжгүй болсон тул сарын дундаж орлого буурсан бөгөөд эдгээр өрхүүдийн 81 хувь нь өрхийн зардлаа, 62 хувь нь хүнсний хэрэглээгээ танасан байна.⁸ Цар тахлын үед сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, их, дээд сургуулийн хичээл сургалтын

⁶ Хүний эрхийн үндэсний комисс. 2021. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл. Улаанбаатар

⁷ Тоон судалгаан үр дүнгээс

⁸ Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны тайлан 2021, ҮСГ

үйл ажиллагаа теле болон цахим хэлбэрээр явуулсантай холбоотойгоор эмзэг бүлгийн, малчин өрхийн хүүхдүүд боловсролын үйлчилгээг авч чадахгүй байна.⁹

ХҮҮХДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

14. 2020 онд Монгол Улсад нийт 77,716 хүүхэд шинээр мэндэлсэн нь 2019 онтой харьцуулахад 0.9 пунктээр буурсан байна. Мөн онд 908,712 өрх бүртгэгдэж өнгөрсөн оноос 1,24 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Нэг өрхөд ногдох дундаж хүн амын тоо 3.7 хүн ам байна.¹⁰ 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын хэмжээнд бүтэн өнчин 3,036 хүүхэд, хагас өнчин 35,000 хүүхэд бүртгэгдсэн байна. 0-18 хүртэлх нийт хүүхдийн 0.2 хувь нь бүтэн өнчин, 2.9 хувь нь хагас өнчин хүүхэд байна. Бүтэн өнчин хүүхдийн тоо сүүлийн 3 жилийн байдлаар 2.7 пунктээр буурсан бол хагас өнчин хүүхдийн тоо мөн хугацаанд 5.03 пунктээр өссөн байна. Өрх толгойлсон 86,535 эцэг эх ганцаараа хүүхэдтэйгээ амьдардгаас 81.3 хувь нь эх, 18.7 хувь нь эцэг байна.¹¹ 2019 онд Шүүхийн шийдвэрээр нийт 2,167 хүүхэд тэтгэлэг тогтоолгосон бол тэтгэлэг тогтоолгосон нийт хүүхдийн ердөө 49.1 хувь нь тэтгэлгээ тогтмол авч чадахгүй байна.¹²

15. НҮБ-ын Хүүхдийн сан Монгол Улсын Засгийн газартай хамтран хийсэн “Хүүхдийн олон хэмжээст, давхацсан гачигдлын шинжилгээ”-ний судалгаанаас 0-23 сартай дөрвөн хүүхэд тутмын нэг нь (25.9 хувь) нэгэн зэрэг гурван төрлийн гачигдалд өртөж байна. Энэ насны хүүхдийн 13.7 хувь нь хоол тэжээл, усан хангамж, ариун цэврийн байгууламжийн гачигдалд нэгэн зэрэг, харин 24 хувь нь хоол тэжээл, ариун цэврийн байгууламжийн гачигдалд тус тус өртөж байна.¹³ Тус тайлангаар нийт хүүхдийн 28.9 хувь нь ядуу өрхөд амьдарч байгаа бөгөөд эдгээр хүүхэд нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа хүмүүсийн 46 хувийг бүрдүүлж байна. Үүнээс үзэхэд нийгмийн хамгааллын тогтолцоог гэр бүл, хүүхдэд үр нөлөөтэй, тогтвортой бий болгох шаардлага нэн тэргүүний асуудал болж байна.

16. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүний тэтгэмж, боловсрол (хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт), эрүүл мэнд (эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүрэн болон хэсэгчлэн төлөх)-ийг дэмжих үйлчилгээ, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх (хүнсний бүтээгдэхүүн эсвэл хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг олгох, халуун хоол, цайгаар үйлчлэх) үйлчилгээ тус бүрд хамруулахдаа өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээний босго оноонд үндэслэн олгодог байна.¹⁴ Энэ үзүүлэлт нь тухайн жилд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд амьдарч байгаа хүүхдийн тоогоор илэрхийлэгддэг бөгөөд 2018 онд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрхөд амьдарч байгаа хүүхдийн тоо 2016 оноос 38 хувь, өнгөрсөн оноос 25.5 хувиар тус тус өссөн байна.

⁹ Чанарын судалгааны үр дүнгээс

¹⁰ YCX.2021. Хүн ам- Өрхийн мэдээлэл https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L03

¹¹ YCX.2021. Хүн ам- Хагас, бүтэн өнчин хүүхдийн тоо
http://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_007V1

¹² YCX.2021. Нийгмийн зарим үзүүлэлт бүлэг, Өрх толгойлсон ганц бие эцэг, эх
https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_3300_044V1

¹³ Neugbourgh, C; Karpatti, J; Boon, L & Yang, M. 2016. Child Monetary-and Multidimensional Poverty in Mongolia: Summary Report. Economic Policy Research Institute

¹⁴ Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт. Хүнсний эрхийн бичиг олгох журам

17. Гэр бүлдээ амьдрах боломж хязгаарлагдмал, орон гэрээсээ дайжсан 1,034 хүүхэд нийслэлд төвлөрсөн асрамж, халамжийн үйлчилгээнд ихэвчлэн хамрагддаг.¹⁵ халамж, асрамжийн газарт байгаа хүүхдийн тоо буурсан ч тэднийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, гэр бүлдээ амьдрахад нь дэмжлэг үзүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах явдлыг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, хүний болон санхүүгийн нөөц бүхий хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна.

18. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ нийтлэг шаардлага MNS 6517:2017 стандартыг Стандарт, хэмжилзүйн газраас 2017 онд баталсан бөгөөд 2020 оны байдлаар улсын хэмжээнд 21 байгууллагын 31 асрамж, халамжийн төв үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууллагуудад нийт 1,057 хүүхэд хамрагдаж байгаа ба түүний 527 нь эрэгтэй, 530 нь эмэгтэй хүүхэд амьдарч байна. Насны байдлыг авч үзэхэд 0-5 насны хүүхэд 16.0 хувь, 6-10 насны хүүхэд 28.5 хувь, 11-14 насны хүүхэд 26.0 хувь, 15-18 насны хүүхэд 23.7 хувь 18-аас дээш насны хүүхэд 5.5 хувийг тус тус эзэлж байна. Дээрх төвд хагас, бүтэн өнчин, асран хамгаалагчгүй хөгжлийн бэрхшээлтэй 79 хүүхэд амьдардаг. 14 асрамж, халамжийн төв 50-100 хувийн камержуулалт хийгдсэн.¹⁶

19. Тус судалгаанд зориулан илгээсэн цагдаагийн байгууллагын мэдээнээс үзвэл 2017, 2019 онд тус бүр нэг, 2018 онд 4 хүүхэд сураггүй алга болж түүний 3 хүүхдийн цогцсыг олсон байна. 2020 оны эхний 4 сард бүртгэгдсэн 3 хүүхдийг хайж байна. Гэхдээ хүүхдийг улсын хилээр гаргасан мэдээлэл бүртгэгдээгүй тул энэ асуудлыг хүний наймаа, хил давуулан худалдах асуудалтай холбож үзэхгүй байна. Цар тахлын улмаас гэрийн хөл хорионы үед хүүхэд алга болох дуудлага эрс багассан байна.

20. **Хүүхдийн боловсрол, хөгжил.** Бага насны хүүхдэд үзүүлэх хөгжлийн үйлчилгээний хүртээмж бага байна. 2020-2021 оны хичээлийн жилд улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 3-5 хүртэл насны 247,040 хүүхэд хамрагдсаны 45.2 хувь нь нийслэлд, 54.8 хувь нь хөдөө орон нутагт хамрагдаж байна. Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин жендэрийн ялгаагүйгээр бараг 100 хувьд хүрсэн.¹⁷ Харин хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнхийн хүүхдийн сургуульд хамрагдалт бага, тэгш хамруулан сургах арга зүй, хандлага сул байна.

21. 2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 839 сургуульд 555,471 хүүхэд сурч, 493 сургуулийн дотуур байранд гол төлөв малчин өрхийн 42,968 хүүхэд амьдарч байна. Тус хичээлийн жилд 5,628 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ЕБС-д сурсны 43.3 хувь нь эмэгтэй байна.¹⁸ Сургууль, цэцэрлэг, хүүхэд хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, төвийн материаллаг бааз, сургалтын хэрэглэгдэхүүн дутагдалтай, орчин хангалтгүй хэвээр байсаар байна. Сургуулийн эмч, нийгмийн ажилтны орон тоо суралцагчийн тооноос шалтгаалан нэмэгдэх боломжтой хэдий ч эдгээр мэргэжилтний одоо байгаа тоо тун хангалтгүй байна.¹⁹

22. ЕБС-ийн үлгэрчилсэн дүрмээр сургууль Хүүхэд хамгааллын багтай, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй байна гэж заасан байдаг. Мөн сургуулийн удирдлага, багш, бусад

¹⁵ ГБХЗХГ.2020. *Монголын хүүхдийн байдал-2019: Статистик эмхэтгэл*. Улаанбаатар

¹⁶ ГБХЗХГ-аас тус тайланд зориулан илгээсэн мэдээллээс

¹⁷ БСШУЯ.2021. *Сургуулийн өмнөх боловсролын салбарын 2020-2021 оны хичээлийн жилийн статистик мэдээл*. Улаанбаатар

¹⁸ БСШУЯ.2021. *Ерөнхий боловсролын салбарын 2020-2021 оны хичээлийн жилийн статистик мэдээл*. Улаанбаатар

¹⁹ Ярилцлагын үр дүнгээс

ажилтан, суралцагч нь өөр хоорондоо сэтгэл санаа, эд материал, бие махбодын аливаа дарамт шахалт үзүүлэх, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, суралцагчийг өөр сургуульд шилжин суралцахыг шаардах зэргээр сургалтын үйл ажиллагаанаас завсардуулах, сургууль, багшийн зүгээс албан ёсны зөвшөөрөлгүй ном, гарын авлага, цахим болон бичмэл материал, бусад зүйлийг зохион байгуулалттайгаар худалдан авахыг, шаардахыг хориглодог. Харин сургуулийн нийгмийн ажилтныг 1997 оноос бий болгож эхэлсэн эдүгээ мянга орчим нийгмийн ажилтан энэ салбарт ажиллаж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж байна. 2019 оноос сургуулиудад сэтгэл зүйчийг ажиллуулах шаардлага тавьж эхэлсэн бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн “Сэтгэл зүйч ажиллуулах бэлтгэл ажлыг хангах тухай” А/22 тушаалаар нийслэл, хөдөө орон нутгийн 42 сургуульд сэтгэл зүйч сонгон шалгаруулан ажиллуулахаар БШУЯ шийдвэрлэсэн нь сайшаалтай.²⁰

23. Төрийн болон төрийн бус өмчийн 1,439 цэцэрлэгийн гадаад дотоод орчны камержуулалт 91 хувь, нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгийн камержуулалт 97.4 хувь байна. Ерөнхий боловсролын сургуулийн 50 орчим хувь нь гадаад орчинд, 80 орчим нь дотоод орчинд камер байршуулсан. 2019 оны байдлаар 2,412 хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагад 54,304 хамрагдаж байна. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагад хамрагддаг хүүхдийн 19.9 хувь нь баруун бүсэд, 27.1 хувь нь хангайн бүсэд, 30.9 хувь нь төвийн бүсэд, 11.8 хувь нь зүүн бүсэд, 10.3 хувь нь нийслэл хотод байна.²¹

24. **Хүүхдийн эрүүл мэндийн талаар.** Монгол Улсын төрөөс хүүхдийн эрхийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр дүнд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 оноос хойшхи 30 жилийн хугацаанд тууштай буурч байгаа ба 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2019 онд 1990 оны түвшинтэй харьцуулахад 1000 амьд төрөлтөд 71.4, нялхсын эндэгдэл 50.1-оор тус тус буурсан байна. Улаанбаатар хотын хувьд 2019 оны байдлаар хүн амын амьсгалын тогтолцооны өвчлөлд хамгийн их буюу 17.9 хувийг хатгалгаа өвчин, үүний дотор 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаа 68.7 хувийг эзэлж байна. Үүний дараагаар цочмог бронхит өвчин орж байна. Энэ өвчин 2019 оны байдлаар амьсгалын тогтолцооны өвчлөлийн 14.4 хувь, үүний дотор 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл 69.4 хувийг эзэлж байна. Хүүхдүүдийн дунд хоол боловсруулах тогтолцооны өвчнөөс халдварт бус суулгалт, шүдний цоорол, шүдний дайврын эмгэгүүд тэргүүлж байна.²²

25. Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2020 оны тоон мэдээгээр осол гэмтлийн шалтгаант шинэ тохиолдлын тоо 2018-2020 онд 5 хүртэлх насанд хамгийн их байсан бөгөөд 2020 оны хувьд осол гэмтэлд өртсөн 3 хүн тутмын нэг нь 0-15 насны хүүхэд байна. 0-19 насны хүүхдийн осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан нь уналт, зам тээврийн осол, түлэгдэлт, амьд болон амьгүй механик хүчинд өртөх (юманд дарагдах, мориноос унах гэх мэт), хүчирхийлэл зэрэг байна.²³

26. Өсвөр насны хүүхдийн дунд амиа хорлох, хүсээгүй жирэмслэлт, БЗХӨ–т өртөх эрсдэл ихсэж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 77,716 эх хүүхэд төрүүлсэн бөгөөд эдгээр эхчүүдийн 2,928 буюу 3.7 хувь нь 15-19 насны охид эзэлж байна. Шүүх эмнэлгийн амбулаторийн үзлэг оношилгоо болон лабораторийн шинжилгээ нь насанд хүрээгүй хүнд үнэ төлбөргүй үзүүлэхээр 2017 оноос журмаа өөрчилсөн байна.²⁴

²⁰ БШУЯ.2021. Тус байгууллагын албан ёсны цахим хаягаас <https://www.meds.gov.mn/post/70801>

²¹ ГБХЗХГ.2020. *Монголын хүүхдийн байдал-2019: Статистик эмхтгэл*. Улаанбаатар

²² Эрүүл мэндийн хөгжлийн төв & ДЭМБ. *Эрүүл мэндийн үзүүлэлт-2019*. Улаанбаатар

²³ Гэмтэл согог судлалын үндэсний хүрээлэн.2021. *Осол гэмтлийн тандалтын тайлан*. Улаанбаатар

²⁴ ХЗДХС, ЭМС, СС-ын 2017 оны А/115, А/176,142 тушаалын 3.5 дахь заалт)

27. **Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхэд, гэрч хохирогч хүүхэд.** Улсын хэмжээнд 2020 онд насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг 990 бүртгэгдэж, өмнөх оноос 27 хувиар буурч, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 5.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.0 нэгж буурсан. Эдгээр насанд хүрээгүй гэмт хэрэгт холбогдогчдын 10.6 хувь нь эмэгтэй байна. Мөн оны байдлаар 14-17 насны 228 хүн шүүхээр ял шийтгүүлсэн нь нийт шүүхээр ял шийтгүүлэгчдийн 1.7 хувийг эзэлж байна.²⁵

28. Гэмт хэргийн улмаас 1,181 хүүхэд хохирч, 99 хүүхэд нас барж, 516 хүүхэд гэмтсэн нь өмнөх оныхтой харьцуулбал, хохирсон хүүхэд 26.1 хувь, нас барсан нь 10.8 хувь, гэмтсэн нь 17.3 хувиар тус тус буурчээ. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчоор 2019 онд 359 хүүхэд, 2020 онд 333 хүүхэд тус төрлийн гэмт хэргийн нийт хохирогчийн 66.3 хувийг хүүхэд эзэлж байна. Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирсон 406 хүний 248 буюу 61.1 хувийг 18 хүртэлх насны хүүхэд эзэлж байна.²⁶

29. **Цахим орчин дахь хүүхэд хамгаалал.** Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаалах үүрэг хүлээдэг билээ. Монгол Улсад нийт 4.42 сая гаруй гар утас ашиглагддаг бөгөөд 2.2 сая интернет болон социал медиа хэрэглэгчтэй. Монгол Улсад фэйсбүүк 2.1 сая идэвхтэй хэрэглэгчтэй. 13 дээш насны хүн амын 90 хувь нь фэйсбүүк хэрэглэдэг ба үүнээс 52.6 хувь нь эмэгтэйчүүд, 47.4 хувь нь эрэгтэйчүүд эзэлдэг.²⁷

30. Интернет, цахим технологи ашиглах боломж нэмэгдэхийн хэрээр хүүхдийн эрх ашиг зөрчигдөх, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэл нэмэгдэж байна. Учир нь эцэг эх, асран хамгаалагчдын дунд цахим бичиг үсэг тайлагдалт хангалтгүй байгаа нь цахим орчны зохистой хэрэглээний талаар хүүхдэд сургах, хяналт тавих боломжгүйд хүргэж байна. 2017 онд ерөнхий боловсролын 50 гаруй сургуулийн 11-18 насны 586 хүүхдийн дунд хийсэн судалгааны дүнгээр 5.1 хувь нь хамаарлын түвшинд 51.4 хувь нь хамааралд орох эрсдэлтэй гэсэн дүн гарчээ. 2018 онд “Цахим тоглоомын хамаарлыг үнэлэх асуумж”-аар 7-8 дугаар ангийн 69 хүүхдийн 51 хувь нь цахим тоглоомд хамааралтай тэдний 71.4 хувь нь эрэгтэй байжээ. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хүүхэд өсвөр үеийн клиникт 2015-2019 онд цахим тоглоомд донтох эмгэгийн улмаас эмчлүүлсэн 9-19 насны 192 хүүхдийн 96.4 хувь эрэгтэй, 165 нь анх удаа, 27 нь давтан эмчлүүлсэн хүүхэд байна. 2015-2019 онд цахим орчинд үйлдэгдсэн 1,749 гэмт хэрэг бүртгэгдсэний 43 буюу 2.5 хувь нь хүүхэд хохирсон гэмт хэрэг байна.²⁸

31. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг 2019 онд 737 гарч байсан бол 2020 онд 1795, 2021 оны эхний хагас жилийн байдлаар 1850 хэрэг тус, тус бүртгэгдсэн байна. Ийнхүү цахим гэмт хэрэг жил бүхэн 40-50 хувь нэмэгдэж байна. Ковид-19 халдвартай холбоотойгоор дэлхий нийтэд цахим гэмт хэрэг нэмэгдэж байна. Цахим хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотойгоор хулгайлах, залилах, дээрэмдэх зэрэг уламжлалт гэмт хэргүүд цахим орчинд үйлдэгдэх болсон бөгөөд цахим залилангийн гэмт хэрэг, насанд хүрээгүй

²⁵ YCX.2021. *Гэмт хэргийн статистик- 2020*.

https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Crime_2020.pdf&ln=Mn

²⁶ ibid

²⁷ Simon Kemp. 2021. Digital 2021: Global overview report. Available at: <https://datareportal.com/reports/digital-2021-global-overview-report>

²⁸ НҮБХС болон ЦЕГ. 2020. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” судалгаа. Улаанбаатар

хүүхдэд садар самуун сурталчлах гэмт хэрэг, цахим тоглоомын гэмт хэрэг түгээмэл үйлдэгдэж байна.²⁹

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

33. Судалгааны оролцогч талуудаас хүүхэд хамгааллын тулгамдсан асуудлын талаар тодруулахад хүүхдийг үл хайхрах, үе тэнгийн дээрэлхэлт, хүүхдийг зодож шийтгэх асуудал хамгийн түгээмэл байлаа. Бүлгийн ярилцлагад оролцсон хүүхдүүд сургуулийн орчинд багш хүүхдийг мөн хүүхдүүд нэгнийгээ ялгаварлан гадуурхах үзэгдэл түгээмэл байгаа гэж үзсэн байна. Мөн түүнчлэн судалгаанд оролцсон эцэг эх, асран хамгаалагч, хүүхдүүдийн зүгээс хүүхдэд нэн тулгамдаж байгаа хамгааллын асуудлыг хүүхдийн аюулгүй байдал, үл хайхрах хүчирхийлэл, зодож шийтгэх хэмээн тодорхойлсон байна. Харин судалгаанд оролцогч үйлчилгээ үзүүлэгч, үүрэг хүлээгч талуудын зүгээс үл хайхрах болон бие махбодын шийтгэл нийгмийн аль ч давхаргад түгээмэл, мөн бага насны охид, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл сүүлийн үед нэмэгдэж байгааг онцолж байлаа.

34. 2017 онд ХЭҮК, Гүүд нэйборс ОУБ-ын хамтран гүйцэтгэсэн “Хүүхдийн эрх ба хамгаалал” судалгааны тайланд Монгол Улс дахь хүүхдийн эрхийн хамгийн нийтлэг зөрчил нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах явдал байсан. Мөн 2018 оны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд оролцсон 1-14 насны хүүхдийн 40.4 хувь нь сэтгэл санааны, 32.8 хувийг бие махбодын шийтгэл хүлээлгэн (судалгаа авахаас өмнөх нэг сарын хугацаанд) хүмүүжүүлсэн байна. Уг хоёр судалгааны үр дүн, тус судалгааны үр дүнтэй ойролцоо байгаа нь хүүхдийг үл хайхрах, хүчирхийллийн шинжтэй аргаар хүмүүжүүлэх хандлага амь бөх байгаа нь хүүхэд хүүхдээ дарамтлах, хүүхдийг хүчирхийлэх нийгмийн үндсэн шалтгаан болсоор байна.

35. **Үл хайхрах хүчирхийлэл** гэдэг нь хүүхдийн суурь хэрэгцээг хангахгүй байгаа явдал юм. Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхэд сэтгэлээр унах, сэтгэл хөдлөлөө барьж, хянаж чадахгүй байх, анхаарал халамж байнга хүсэх, шаардах, зүй бус үйлдэл гаргах, бие, сэтгэц, оюуны хөгжлөөрөө хоцрох, өөртөө итгэл муутай болох зэрэг шинж илэрдэг. Энэ хэлбэрийн хүчирхийлэлд байнга өртөж өссөн хүүхэд гэмт хэрэгт холбогдох магадлал өндөр байдаг. Сүүлийн жилүүдэд манай улсад цахим орчны хэрэглээнээс үүдэлтэй үл хайхрах хүчирхийлэл өсөх хандлагатай байна.

36. Мөн өсвөр насны охидын жирэмслэлт, төрөлт өссөн гэдгийг хэд хэдэн аймаг, дүүргийн үйлчилгээ үзүүлэгчид судалгааны үеэр дурдсан. Хүүхэд хамгааллын тулгамдсан асуудлын учир шалтгаан, шийдлийг ярилцлагын оролцогчдоор ярилцлагын үеэр хэлэлцүүлэн гарсан үр дүнг дараах байдлаар тоймлон харууллаа.

²⁹ ЦЕГ.2021.Статистик мэдээ. <https://police.gov.mn/as/article/3>

График 1: Асуудлын мод, үл хайхрах хүчирхийлэл





График 2: Асуудлын мод, зодож шийтгэх




37. **Үе тэнгийн дээрэлхэлт.** Сургуулийн багш, ажилтнуудтай хийсэн ярилцлагаар сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрэлхэлт эрс нэмэгдэж цахим орчин руу илүү шилжсэн байна. Үе тэнгийн дээрэлхэлт нь бага ангийн сурагчдын дунд бага байгаа болон 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд хамгийн их байдаг байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны хийсэн судалгаанд хамрагдсан 10 хүүхэд тутмын 8 нь нэгээс олон фэйсбүүк хаягтай бөгөөд дунджаар нэг хүүхэд 3-4 хаягтай байна.³⁰ Тус судалгаанд оролцогч хүүхдүүд нийгмийн

³⁰ Харилцаа холбооны зохицуулах хороо.2021. Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаарх судалгааны тайлан. Улаанбаатар

сүлжээний хэд хэдэн хаяг нээж ээж аавтайгаа, найзуудтайгаа гэх мэтээр өөр өөр зорилгоор олон хаяг ашиглаж байгааг дурдсан. Цахим орчны зөв зохистой хэрэглээний талаарх хүүхдүүдийн ойлголт дутмаг, болзошгүй эрсдэлээс өөрийгөө хамгаалах талаар ойлголт сул байгааг судалгаан оролцогч талууд онцолж байлаа. Хүүхдүүд нийгмийн сүлжээгээр бие биеэ гутаан доромжлох, худал мэдээлэл тараах, өмссөн хувцас, ар гэрийн нөхцөл байдлаар нь ялгаварлан, гадуурхах явдал түгээмэл байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны дээрх судалгаанд оролцсон хүүхдийн 50 хувь нь цахим дарамтад өртөж байсан бөгөөд тэдний ердөө 15 хувь нь энэ талаар эцэг эхдээ хэлсэн байна.

График 3: Асуудлын мод, үе тэнгийн дээрэлхэлт



38. Цахим технологийн сөрөг нөлөө, энэ орчин дахь хүүхэд хамгааллын зөрчлүүд нь асуудлыг үндэсний хэмжээнд бүрэн шийдвэрлэх боломжийг хумьж, үндэстэн дамнасан хэлбэрт хүргэж байна. НҮБ-ын Хүүхдийн Сангаас Харилцаа холбооны зохицуулах газартай хамтран www.ekids.mn вэбсайтыг хүүхдийн эсрэг онлайн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээх бааз болгон хөгжүүлж байна. Үүний зэрэгцээ хүүхдийн эрхийг зөрчсөн мэдээ, мэдээлэлтэй вэбсайтыг мэдээлэх цахим талбар, эцэг эхийн хяналтын аппликэйшн зэргийг хөгжүүлж байгаа нь сайшаалтай.

39. Судалгаанд оролцогч хүүхдүүдийн зүгээс ЕБС-ын багш нар хүүхдийг ар гэрийн нөхцөл байдал, гадаад байдлаар нь ялгаварлан гадуурхаж, бусад сурагчдын өмнө загнах, үг хэлээр доромжлох явдал түгээмэл гардаг. Сурагчид багш нар хүүхдийг ялгаварлан гадуурхдаг талаар хаана, хэнд мэдээлж, хэрхэн шийдвэрлэхээ мэдэхгүй гэжээ. Мөн багш хүүхдийг ялгаварлан гадуурхсанаас болж ангийн хүүхдүүд багшийг даган тухайн хүүхдийг нэмж дээрэлхэх үзэгдэл байдаг байна. Сургуулийн орчин дахь ялгаварлан гадуурхалт, үе тэнгийн дарамтаас болж сургуулиас гарч, насан туршийн боловсролын төвд суралцах хүсэлтэй хүүхдүүд ирж байгааг хэд хэдэн ярилцлагад оролцогчид дурдаж байсан.

6-р ангийн охиныг чатаар харилцагч хүү нь “царайгаа харуулбал ... төгрөг, цээжээ харуулбал ...төгрөг өгье гэхэд охин зөвшөөрч цээжний зургаа явуулахад удалгүй ангийн фэйсбүүк группэд зургийг оруулжээ. Охин багшдаа үнэн учрыг хэлж судлахад ээж аав салсан тул охин эмээтэйгээ амьдарч байсныг тодруулан хойшид сэрэмжлэх талаар хамтран сайтар зөвлөлджээ.

Ганцаарчилсан ярилцлагаас

Би өөрийн үзэл бодлыг хэлэхэд ялангуяа багш нар хүүхдийг шоолдог тэгээд хичээл тарсны дараа ангийн хүүхдүүд сонин сонин хараад шоолдогч юм уу тийм зүйл тулгардаг тэгэхээр багш нар дээр арга хэмжээ авмаар байна. Бас дүн тавихад ч боломжтой айлын хүүхдийн дүнг нь сайжруулж тавина. Боломжгүй айлын хүүхэд байх юм бол ар гэрийнхнийг нь олны өмнө яриад хүүхдийн сэтгэл зүйгээр нь тоглодог, муугаар хэлдэг.

Охидын ярилцлагаас

40. Хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, дарамт, мөлжлөг нь бие махбод гэмтэх, сэтгэлийн түгшүүртэй, сэтгэц хямралд орох, жирэмслэх амиа хорлохыг оролдох, цаашлаад үхэлд хүрэх хор уршигтай төдийгүй ирээдүйн амьдралын чанарт нь шууд нөлөөлдөг. Бага насны хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой хортой стресс нь тархины хөгжлийг бүр мөсөн доройтуулж, мэдрэлийн системийг гэмтээж буйг тархи судлалын олон судалгаа нотолж, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нөхөн сэргээх тусламж үйлчилгээг хурдан, үр дүнтэй үзүүлэхийг чухал гэж үзэж байна. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүд цаашид хүн худалдаалах гэмт хэрэг тэр дундаа бэлгийн мөлжлөгийн хохирогч болох эрсдэл өндөр байдаг тул бэлгийн мөлжлөгийн хохирогчдод үзүүлж байгаа үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, стандартчилах хэрэгцээ тулгамдаж байна.

41. **Жендэрийн ялгаа.** Охидтой хийсэн ярилцлагаар охид гэрийн ажлаа хийж, дүүгээ харах ёстой гэсэн эцэг эхийн шаардлага нь тэдний сурч хөгжих цагаас хороож саад болдог гэж шүүмжилж байлаа. Охид урин дулаан цагт богино хувцас өмсөж явахад бэлгийн дарамттай их тулгардаг гэдгийг мөн онцолж байсан. Баян-Өлгий аймагт эмэгтэйчүүд олон хүүхэд гаргадаг учир, охид дүүгээ харах ёстой гэсэн хэвшмэл ойлголт түгээмэл байдаг байна. НҮБ-ын Хүн амын сангийн хийсэн судалгаагаар ковид-19 цар тахлын үед охид, эмэгтэйчүүдийн гэрийн ажил нэмэгдсэн нь охидын боловсролд тэгш хамрагдах боломжийг багасгаж байна. Мөн гэр хороолол, алслагдсан бүс нутагт амьдардаг охид гэртээ асран халамжлах ажлыг түлхүү хийж байгаагаас тэдний суралцах цаг хугацааг хязгаарлаж, цаашдын сайн сайхан байдалд нь сөргөөр нөлөөлж байна.³¹ Уг судалгааны үр дүн чанарын судалгаанд оролцогч охидын дээрх хандлагатай нийцэж байна.

³¹ НҮБ-ын Хүн амын сан, Жендэрийн Үндэсний Хороо, АХБ. 2021. Монгол Улсад КОВИД-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа. <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/-covid-19-impact-on-women-and-girls-in-mongolia--study.html>

Ар гэрийн ажлыг эмэгтэй хүн л хийх ёстой гээд сургачих юм бол том болоод ч хөвгүүд чинь юу ч болсон эмэгтэй хүн л гэрийн ажлыг хийх ёстой гээд толгойд нь суучихдаг. Тэр зүйлээс болоод жендэрийн тэгш бус байдал багаасаа үүсдэг юм шиг санагдсан. Хөвгүүдтэй харьцуулах юм бол бид нар хувцас өмсөх болсон ч асуудал тулгардаг. Хүссэн хувцсаа өмсөж болохгүй аль болох боож багласан битүү хувцас өмсөх ёстой байдаг.

Охидын ярилцлагаас

Миний бодлоор охидоос ялгаатай бэрхшээл юу байна гэхээр эмэгтэй хүүхдүүдийг бодвол эрэгтэй хүүхдүүд арай илүү сэтгэлийн хаттай бай гэж шахдаг. Өсвөр наснаас эхлээд “эр хүн байж иймэрхүү асуудлыг даваад гарч чадахгүй юм чинь цаашдаа яаж айлыг авч явах юм” гэдэг ч юм уу ер нь биднийг хүн биш зүгээр робот шиг байлгах гээд байдаг нь үнэхээр дарамттай.

Хөвгүүдийн ярилцлагаас

42. Мөн багш нар охид хөвгүүд адилхан зүйл хийсэн байхад хөвгүүдийг илүүд үзэж илүү дүн тавих, магтах зэргээр хүйсээр ялгаварлан гадуурхдаг гэдгийг ч охид дурдаж байлаа. Харин хөвгүүдийг охидтой харьцуулахад насанд хүрэгчдийн зүгээс ирэх жендэрийн хэвшмэл ойлголт, хөнөөлт эршүүд (toxic masculinity) чанартай холбоотой ирэх сэтгэл зүйн дарамт их байдаг байна.

43. **Орон нутгийн онцлог.** Казак зэрэг хэлтэй цөөнхийн хүүхдүүд ХТУ 108-аас мэдээлэл авч, эрхийн зөрчлөө мэдээлж чаддаггүй байна. Энэ нь хүүхэд хамгааллын талаарх олон нийтэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажил, үйлчилгээг хос хэл дээр гаргах хэрэгцээг харуулж байна. Мөн Баян-Өлгий дотроо цөөнхийн цөөнх болсон тува, урианхай, халх хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар судалгаа, мэдээлэл орон нутаг болон үндэсний түвшинд байхгүй байна.

Дэлхийн Зөнгөөс гаргасан хүүхдийн нас, насны онцлогт тохируулсан хүмүүжлийн аргуудын ном их сайн ном байсан. Хүмүүст хүртээмжтэй бас казак хэл дээр гаргаасай тэгвэл их зүгээр. Монгол хэл сайн мэдэхгүй ойлгодоггүй хүмүүс өөрийнхөө ёс заншлаар л хүмүүжүүлнэ шүү дээ.

Бүлгийн ярилцлагаас

44. Ярилцлагаар өсвөр насны охидын төрөлт сүүлийн жилүүдэд ихсэж байгаад үйлчилгээ үзүүлэгчид сэтгэл зовниж байгаагаа илэрхийлсэн бөгөөд 2020 оны байдлаар 15-19 насны 1,000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин Улаанбаатарт 32.7; Сэлэнгэ аймагт 32.2; Хэнтий аймагт 30.8 байгаа нь улсын дунджаас (27.6) өндөр байна.³² Харин Баян-Өлгий аймагт 19.5; Өмнөговь аймагт 19.9 байлаа. Өсвөр насны охидын дунд төрөлт өндөр байгаа нь бэлгийн боловсрол дутмаг, өсвөр насныханд зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмжгүй, бэлгийн хүчирхийлэл далд хэлбэрт байгаа зэрэг олон шалтгаантай төдийгүй өсвөр насны охидын жирэмслэлт, төрөлт нь тэдний эрүүл мэнд, ирээдүйн амьдралын чанарт сөрөг нөлөөтэй юм.³³

³² YCSX.2021. Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин (10-14, 15-19 насны 1000 эмэгтэйд ногдох) бүс, аймаг, нийслэлээр. https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2100_047V1

³³ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. 2020. Өсвөр насны охидын жирэмслэлт. <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/adolescent-pregnancy>

45. Судалгааны явцад хүүхдүүдээс өөрт нь тохиолдсон асуудлыг хэнд хэлдэг талаар асуухад найздаа гэсэн хариулт хамгийн түгээмэл байсан бөгөөд асуудлаасаа хамаараад аав ээж эсвэл багшдаа хэлэх эсэхээ шийддэг гэдэг хариулт удаалж байлаа. Хүүхдүүд сургууль дээр болсон үе тэнгийн дээрэлхэлтийн талаар аль болох эцэг эх, асран хамгаалагчдаа хэлдэггүй мөн асуудал том л биш бол багш, нийгмийн ажилтанд ч хэлдэггүй гэж байлаа. Учир нь эцэг эх, асран хамгаалагч, багшид асуудлын талаар хэлэхэд хүүхдийн нууцыг хүндэтгэж үр дүнтэй шийдвэрлэхийн оронд асуудлыг хурцатган маргалдаж хүүхдийн хувийн мэдээллийн нууцыг сургууль, хамт олон, орон нутагт задруулдаг гэлээ.

46. Хүүхдэд тулгарч байгаа эдгээр бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаар асуухад сургуульд сэтгэл зүйч хэрэгтэй гэдгийг оролцогч хүүхэд бүр дуу нэгтэй хэлж байсан нь ЕБС болон орон нутгийн ГБХЗХБ зохих түншлэгчийн дэмжлэгээр сэтгэл зүйч ажиллуулж хүүхдүүдэд хүрч эхэлж байгаагийн илрэл гэж ажиглагдлаа. Судалгаанд оролцсон хүүхдүүд насанд хүрэгчид хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэн сонсож хүүхдэдээ цаг гарган ярилцах зэрэг цагийг хамт өнгөрөөж байхыг хүсэж байлаа. Хүүхдүүд насанд хүрэгчид хүүхдээ үл хайхран орхисноор тэдэнд ямар асуудал тулгараад байгааг мэдэхгүй өнгөрөөдөг гэдгийг тайландаа онцолж оруулахыг хүссэн юм. Хүүхдүүд ярилцлагын төгсгөлд эцэг эх, асран хамгаалагч, сургууль, хүүхэд гурав хамтарч ажилладаггүйгээс сургуулийн орчин хүүхдэд ээлтэй байж чадахгүй байгаа гэж үзэж буйгаа хуваалцсан юм.

47. **Гэр бүл салалт ба хүүхэд хамгаалал.** 2020 онд 2,726 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан нь 2010 оныхтой харьцуулахад 3.1 дахин (1130-аар) буурсан хэдий ч хүүхдийн тэтгэлэг тогтоосон хэргийн тоо 2020 онд 1,333 болж 2010 оныхоос 3.7 дахин өсчээ. 2020 онд шүүхийн шийдвэрээр тэтгэлэг авагч нийт 13,436 хүүхдийн ердөө 36.3 хувь нь (4,877) тэтгэлгээ тогтмол авч байна.³⁴ Гэр бүл цуцлахтай холбоотойгоор хүүхдийг асран хамгаалагч тал салсан эцэг/эхээс нь хүүхдийг хөндийрүүлэх (parental alienation syndrom) үзэгдэл нэмэгдэж байна. ДЭМБ-аас 2019 оны 5 сард салсан эцэг/эхээс нь хөндийрүүлэх үзэгдэл - синдромыг өвчний жагсаалтад бүртгэсэн бөгөөд олон оронд уг синдромоор өвчилсөн эцэг эх, асран хамгаалагчид авах арга хэмжээг хуулиар тодорхой болгон сэтгэл зүйн болон бусад үйлчилгээнд хамруулж байна. Салсан эцэг/эхээс нь хөндийрүүлэх синдромын үед дараах шинж тэмдэг илэрнэ. Үүнд:

- Салсан эцэг/эхийнх нь талаар муу хэлэх,
- Салсан эцэг/эхийнх нь аав ээж, хамаатан саданы талаар муулах,
- Салсан эцэг/эхийг хүүхэдтэй уулзахыг нь хориглох,
- Утасны дуудлага, мессэж, имэйл гэх зэрэг захидал харилцаанд нь хөндлөнгөөс оролцох,
- Салсан эцэг/эхийн зураг, эд хэрэгсэл зэргийг нуух, хаях,
- Хүүхдээ үл хайхрах,
- Хүүхдэд салж явсан эцэг/эх нь хайрлахаа больсон гэж хэлэх,
- Эцэг эхийнхээ аль нэгийг сонгохыг шаардах,
- Салсан эцэг/эхтэйгээ хамт байх нь аюултай гэж хүүхдэд ойлгуулах,
- Хүүхдэдээ бусдад хэлээгүй нууцаа хэлэх. Жишээ нь: Салсан эхнэр эсвэл нөхөр нь дарамталдаг, зоддог байсан гэх мэт,
- Салсан эцэг/эхээсээ татгалзахыг хүчээр шаардах,
- Салсан эцэг/эхийнхээ талаар тагнахыг хүсэх,
- Салсан эцэг/эхээсээ болсон явдал эсвэл байгаа нөхцөл байдлаа нуухыг хүсэх,
- Салсан эцэг/эхийг нь бүтэн нэрээр нь дуудаж ярих,

³⁴ YCX. Хууль зүй, гэмт хэргийн статистик. https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L23&type=tables

- Хойд эцэг/эхийн талаар ярихдаа “аав”, “ээж” нь гэж ярих мөн хүүхдийг тэгж дуудахыг хүсэх,
- Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол зэрэг чухал мэдээллийг салсан эцэг/эхэд өгөхгүй байх мөн эрүүл мэнд, боловсрол болон бусад шаардлагатай баримт бичгээс салсан эцэг эхийг нэр, холбоо барих мэдээллийг хасуулах,
- Хүүхэдтэй холбоотой баримт бичгээс салсан эцэг/эхийн нэрийг хасуулах,
- Хүүхдийг өөрөөсөө бүрэн хамааралтай болгох зэрэг орно.³⁵

48. Салсан эцэг/эхээс нь хөндийрүүлэх синдром нь хүүхдийн зан харилцаа, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжилд сөрөг нөлөөтэй. Мөн шүүхийн практикт салсан эцэг/эхээс нь хөндийрүүлэх синдромын хохирогч хүүхэд салсан эцэг/эх нь сэтгэл санааны болон бие махбодийн дарамт үзүүлдэг байсан талаар худал мэдүүлэг өгөх нь цөөнгүй байдаг байна.³⁶

49. Гэр бүл цуцлалтын улмаас хүүхдийн асран хамгааллыг тогтоох шүүхийн шийдвэр, уг шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг нэг удаа явуулж байна. Гэтэл тухайн хүүхдийн эцэг эх болох талууд хүүхдээ үл хайхрах, булаалдах, хүүхдийн эрхийг дур мэдэн хязгаарлаж маргах зэргээр хүүхдийн эрхийг зөрчих нь түгээмэл байна. Хүүхэд хамгааллын өнөөгийн тогтолцоонд эдгээр хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх, үйлчилгээ үзүүлэх, үр дүнтэй шийдвэрлэх, эцэг эх хүүхдийн харилцааг зохицуулсан удирдамж, зөвлөмж тухайлбал шүүхийн шийдвэрт гэр бүл цуцалсаны дараах хүүхэд асран хүмүүжүүлэх эцэг, эхийн үүргээ үргэлжлүүлэх хэрэгжүүлэх зэрэг төрийн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Ингэхдээ эцэг эх нь гэрлэлтээ цуцлуулсан хүүхдийн хамгаалагдах эрхийг хангах асуудлыг тусгайлан анхаарч, түүнд нэн шаардлагатай үйлчилгээг олон улсын туршлагыг судалж бий болгох, хөгжүүлэх хэрэгтэй.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэр бүл салсан. Шүүхээс намайг охины асран хамгаалагчаар томилсон гэвч эцэг нь охинтойгоо уулзах гэж ирээд аваад явчихсан. Би охинтойгоо уулзаж чадахгүй хэдэн жил болж байна. Охиныг надаас зугтаалгаж хэд хэдэн сургууль шилжүүлсэн. Миний талаар охинд муугаар хэлж сэтгэл зүйд нь нөлөөлж байна. Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, прокурорт хандан охиноо авах хүсэлт, гомдол гаргасан ч шүүхийн шийдвэрээр охиныг чинь танд өгсөн байхад яагаад аавтай нь уулзуулсан юм гэж намайг буруутгаж өдий хүртэл ямар нэг арга хэмжээ аваагүй. Тэрээр согтуу ирж охиндоо агсан тавьдаг бас түүнийг ах дүүгийнхээ хэдэн сараар үлдээж явдаг зэргийг мэдээлж дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст гомдол гарган охиноо авсан байгаа ч салсан нөхөр маань өмгөөлөгчтэйгөө ирж тус хэлтсийн ажилтнуудыг дарамтлах, охиныг аавтай нь утсаар яриул, уулзуул гэж намайг шахаж байна. Би хуулийн дагуу бүх газраар явж үзлээ. Хэрэв аав нь дахиад охиныг аваад явбал би хэнд хандаж, яаж охиноо буцааж авахаа үнэхээр мэдэхгүй байна.

Ганцаарчилсан ярилцлагаас

ХАМГИЙН ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮҮХДҮҮД

50. Дэлхийн Зөн ОУБ-ын зүгээс гачигдал, ялгаварлан гадуурхал, хүчирхийллийн харилцаанд болон гамшгийн нөхцөл байдалд байгаа хүүхдийг хамгийн эмзэг бүлгийн хүүхэд хэмээн үзэж эдгээр дөрвөн нөхцөл давхацсан тохиолдолд хүүхдийн эмзэг байдал нэмэгддэг байна. Судалгаанд оролцогчдоос хамгийн эмзэг бүлгийн хүүхэд гэж хэнийг тодорхойлж болох талаар асуухад үл хайхрах хүчирхийлэлд байгаа, хөдөлмөр эрхэлж

³⁵ O’ Sullivan. B. 2018. *Parental alienation, a systemic perspective and context*. Journal of Systemic and Family Practice, 157, June pp. 3 – 7.

³⁶ Parental Alienation Europe. <https://parentalalienation.eu/>

байгаа, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, хууль зөрчсөн хүүхдийг хэмээн тодорхойлсон байна. Үүнээс үзэхэд хүүхдийн эмзэг болгож байгаа хүчин зүйл өрхийн амьжиргаа; эцэг эхийн хүүхдэдээ тавих анхаарал, халамж; орчин нөхцөл зэрэгтэй шууд хамааралтай байна.

51. **Ядуурал ба хүүхэд.** ҮСХ-ны тайлангаар Монгол Улсад ядуу таван хүн тутмын хоёр нь 15-аас доош насны хүүхэд байна. Ядуурал нь тухайн өрх дэх хүүхдийн тоо, тэжээгчдийн хувьтай нягт хамааралтай байгаа нь үр хүүхдүүдээ тэтгэх хангалттай тооны хөдөлмөрийн насны хүмүүс дутагдалтай байгааг харуулж байна.³⁷ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас мэдээлсний дагуу Монгол Улсын нийт хүн амын 8 хувьд буюу 240 мянга орчим хүн хүнсний эрхийн бичиг авдгийн 50 хувь нь хүүхэд байна.³⁸ Тэгвэл ядууралд өссөн хүүхдүүдийн хувьд боловсрол эзэмших боломж бага, үүнийг дагаад хүрэлцээтэй цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх боломж буурах, улмаар амьжиргааны түвшин доройтсоноос үүдэн гэр бүлийн зөрчил маргаан нэмэгдэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг байна.³⁹

52. **Ковид-19 ба хүүхдийн эмзэг байдал.** Ковид-19 цар тахлын нөхцөлд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдал нэмэгдсэн байна. 2020 онд цар тахлын үед гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн тоо өмнөх онтой харьцуулахад 15.5 хувь (1,138) өссөн⁴⁰, НЦҮТ болон ТХБ үйлчлүүлэгчийн тоо 2 дахин өссөн бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн баривчлах байранд ирэгсдийн тоо 26.4 хувь тус тус өссөн байна.⁴¹ Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйг дагаж 1-3 хүүхэд ТХБ-нд ирдэг нь хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн давхар хохирогч болж байгааг харуулж байна. Мөн Ковид-19 цар тахлын үед ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосноор эцэг эх, асран хамгаалагчид өөрийн ажил хөдөлмөр, хүүхэд асрах үүргийн хооронд сонголт хийх сорилттой тулгарч байна. Эцэг эх, асран хамгаалагчдын хараа хяналт сулаас болж цар тахлын үед хүүхэд ахуйн осол гэмтлээс болж амь насаа алдсан тохиолдол хэд хэдэн удаа гарсан нь харамсалтай. Үүнээс үзэхэд Ковид-19 цар тахлаас үүссэн нөхцөл байдал хүүхдийн эмзэг байдлыг улам нэмэгдүүлсэн төдийгүй онцгой нөхцөл байдалд хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байгааг харуулж байна.

53. **Хүүхэд хамгаалал ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд.** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах талаар үндэсний хэмжээний тайлан, судалгаа дутмаг байна. ХБХ-ийн ердөө 55 хувь нь сургууль, цэцэрлэгт хамрагдаж байгаа нь эдгээр хүүхдүүдийн сурч боловсрох эрх хангагдахгүй байгааг илтгэнэ.⁴² ХБХ-ийн онцлогт тохирсон байдлаар хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэх, хариу үйлчилгээг үзүүлэх ажил хуруу дарам цөөн байна.

³⁷ ҮСХ болон Дэлхийн Банк. 2018. *Ядуурлын дүр төрх*. Улаанбаатар

³⁸ Ярилцлагын үр дүнгээс

³⁹ ҮСХ болон Дэлхийн Банк. 2018. *Ядуурлын дүр төрх*. Улаанбаатар

⁴⁰ ЦЕГ. 2020. *Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх танилцуулга*.

⁴¹ Хүний эрхийн үндэсний комисс. 2020. *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл*. Улаанбаатар

⁴² Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сэргээн засах төвийн ажилтай Ерөнхий сайд танилцах үеэр хийсэн мэдээлэл 2021 оны 6 сарын 3-ны өдөр

Манай хүү дауны синдромтой. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өсгөхөд манай нийгэм, хүрээлэн буй орчин, иргэдийн мэдлэг хандлага хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэхээр ээлгүй байна. Миний хүү одоо 15 настай ч амьдралдаа хэзээ ч ганцаараа гадаа гарч үзээгүй, гэр бүлийн гишүүдийн тусламжгүйгээр анхан шатны ямар ч үйлчилгээг авах боломжгүй.

Бүлгийн ярилцлагаас

54. 2020 онд АХБ-ны Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нь төслийн захиалгаар хийсэн судалгаанд хөгжлийн бэрхшээлийн онцлог тусгай хэрэгцээг харгалзан, хүртээмжтэй байдлаар мэдээлэл хүргэдэггүй, хариу үйлчилгээ болон хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа ХБХ-д хүртээмжгүй, хохирогчийн бүртгэл, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр нарийвчлан задалдаггүй, талуудын хамтын ажиллагаа сул зэргийг дурдаад судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний 74 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд ямар нэгэн байдлаар өртөж байсан, тэдний 80 хувь нь гурав болон түүнээс дээш хэлбэрийн хүчирхийлэлд хавсарсан байдлаар өртсөн байсан байна.⁴³

55. ХБХ хүчирхийлэлд өртөөд ТХБ, НЦҮТ-д очиход тухайн хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн орчин, үйлчилгээ байхгүй, үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд ХБХ-тэй ажиллах чадавх байхгүй нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлгүй байгааг харуулж байна.⁴⁴ Мөн судалгааны ярилцлагад оролцсон Хамтарсан багийн гишүүд өөрийн орон нутагт байгаа ХБХ хаана, хэнтэй амьдардгийг мэддэг ч, гэхдээ ямар нэг төрлийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг илрүүлэх, олж мэдэх чадавх, боломж байдаггүй гэдгээ хуваалцсан юм.

⁴³ ХЗДХЯ, Азийн Хөгжлийн Банк, IRIM. 2020. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн талаарх чанарын судалгаа. Улаанбаатар

⁴⁴ Чанарын судалгааны үр дүнгээс

3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООНЫ БҮТЭЦ



3. МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООНЫ БҮТЭЦ

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

56. **Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ.** Олон улсын гэрээ, конвенцид нэгдэх, соёрхон батлах асуудлыг УИХ бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэдэг бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенц нь Монгол Улсын Олон улсын гэрээ болж үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчлэхийг Үндсэн хуульд заасан.⁴⁵ Монгол Улс эдүгээ хүний эрхийн олон улсын 60 гаруй гэрээнд нэгдэн орж, мөн дээрх хуульд нийцсэн үндэсний 700 шахам хуулийг батлан хэрэгжүүлж байна. Өнгөрсөн гуч шахам жилийн хугацаанд УИХ хууль тогтоох чиг үүргээ дангаар хэрэгжүүлж, нэг парламент өөрийн бүрэн эрхийн 4 жилийн хугацаанд дунджаар 100 гаруй шинэ хууль баталж, 500 шахам хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, олон улс, улс хоорондын 50 шахам гэрээ соёрхон баталдаг хандлага байна.⁴⁶

57. Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид, түүний нэмэлт протоколууд болох Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг (2003), Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг (2004), Мэдээлэл хүргүүлэх журмын тухай (2015) онд тус тус нэгдэн орсон. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын үндсэн 8 конвенцийг соёрхон баталсны дотор Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай 182-р конвенцийг 2001, Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцийг 2002 онд тус тус соёрхон баталжээ.

Хүснэгт 2: Монгол улсын нэгдэн орсон гэрээний талаар

№	Олон улсын гэрээ, конвенцийн нэр	Соёрхон баталсан огноо
1	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	1948.12.10
2	Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц	1968.10.31
3	Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай Конвенц	1964.9.22
4	Арьс, үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай ОУ-ын Конвенц (1966)	1969.3.31
5	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (1966) нэмэлт протокол	1974.11.18
6	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай ОУ-ын Пакт (1966) нэмэлт протокол	1974.11.18
7	Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай 1949 оны конвенц нэмэлт протокол	1977.12.12
8	Олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай конвенцийн (1949.8.12) нэмэлт протокол-2	1977.12.12
9	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (1979)	1981.7.20
10	Газар доор буюу уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай (ОУХБ-ын 123)	1981.12.3
12	Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц	1990-07.5
13	Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай Конвенц (1,2)	1991.4.15

⁴⁵ Монгол Улсын Үндсэн хууль, Нэгдүгээр бүлгийн 10.3 зүйл

⁴⁶ Ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс

14	/Хүмүүсийг барьцаанд авахтай тэмцэх тухай конвенц/ Олон улсын конвенцид нэгдэн орох тухай	1992.04.10
15	МУЗГ, НҮБ-ын Хүүхдийн Сангийн хоорондын хамтын ажиллагааны тухай үндсэн хэлэлцээр	1994.02.08
16	Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц	1993.05.29
17	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенц	1992.4.10
18	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай (ОУХБ-ын 182)	2000.11.19
19	Эрүүдэн шүүх болон бусад бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенц	2000.11.02
20	/Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг” конвенц/	2001.01.25
21	Гэрээ соёрхон батлах тухай /Монгол Улсын Засгийн газар, СОС Киндердорф Интернациональ олон улсын байгууллагын хооронд “СОС хүүхдийн хотхон” байгуулахтай холбогдсон төслүүд хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах тухай	2001.01.25
22	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн (1979) нэмэлт протокол	2000.12.14
23	Ромын дүрэм батлах тухай	2002.4.15
24	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай Конвенцид оруулах Нэмэлт Протокол (2000)	2002.01.18
25	Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг ХЭК-ийн Нэмэлт Протокол (2000)	2002.02.12
26	Ажилд авах насны доод хязгаарыг тогтоох тухай ОУХБ-ын 138 Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай (ОУХБ-ын 138)	2002.10.31
27	Албадлагын хөдөлмөрийн тухай (ОУХБ-ын 29)	2005.2.24
28	Албадлагын хөдөлмөрийг устгах тухай (ОУХБ-ын 105)	2005.2.24
29	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц (2006)	2008.12.19
30	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай Гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол,	2008.5.26
31	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц нэмэлт протокол	2008.12.19
32	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт протокол-2 (1966)	2012.1.05
33	Эрүүдэн шүүх болон бусад бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенцийн (1984) 1987 нэмэлт протокол	2014.12.11
34	Мэдээлэл хүргүүлэх журмын тухай ХЭК-ийн нэмэлт гуравдугаар протокол	2015-04-16
35	Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай НҮБ-ын конвенц	2020.5.15

58. Монгол Улс нэгдэн орохоор хүүхэд хамгааллын нөхцөл байдалтай уялдуулан хилийн гадна байгаа хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах шаардлагаар улс хооронд хамтран ажиллах Гаагийн конвенц, Хүүхдээ тэжээн тэтгэх эцэг эхийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх протокол, Эцэг эхчүүд улс дамжуулж хүүхдээ булаацалдах эсрэг конвенци зэргийг судалж байгаа талаар судалгааны ярилцлагын үеэр ХНХЯ, ГХЯ-ны оролцогчид дурьдаж байлаа.

59. Монгол Улсын Засгийн газар хүн амын гуравны нэгийг эзэлж байгаа хүүхдэд хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах, сурч боловсрох, хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрх, эрх чөлөөг нь хангахад чиглэсэн бодлогыг тасралтгүй хэрэгжүүлж байна. 2016 оноос хойш явуулж буй бодлого нь Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд анхаарч байна.

60. **Хүүхэд хамгааллын холбоотой зорилтууд хөгжлийн бодлогод.** УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болох алсын хараатайгаар “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан юм. Тус бодлогын баримт бичгээр сургуулийн дотуур байрны хүүхэд хамгааллыг сайжруулах (2.1.24); Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн гэр бүл, хүүхэд, хүн амын бүлгүүдийн талаар баримтлах бодлого боловсруулж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулах (2.3.2.); хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлэх (7.3.6.); хүүхэд хамгаалах төв, асрамжийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлэх (9.1.8.); сургуулийн хүүхдэд зориулсан тээврийн үйлчилгээг хөгжүүлэх (9.3.22) зэрэг зорилтуудыг тусгажээ.

61. **ЗГҮАХ (2016-2020)** оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхдийг амьдрах ур ухааныг хөгжүүлэх, аюулгүй байдлын сургалтыг нэвтрүүлж, хүүхдийг эрсдэлгүй, осол эндэлгүй, эрүүл, аюулгүй амьдрах чадварт сургах; хүүхдийн хүмүүжил, төлөвшилд үндэсний өв уламжлал, урлаг соёлоор дамжуулан эерэгээр нөлөөлөх бодлого хэрэгжүүлэх; хараа хяналтгүй хүүхдийн бүртгэл, хяналтыг сайжруулж, насанд хүртэл нь хамгаалах, амьдралд хөлөө олоход нь туслах бодлого хэрэгжүүлэх талаар тусгайлсан заалт оруулсан бөгөөд гэр бүлийн үнэт зүйлсийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлөөр хангана хэмээн заасныг хэрэгжүүлэхээр ЗГХА-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг байгуулж, аймаг, дүүрэг, нийслэлд салбар бүтцийг бий болгосон.

62. **ЗГҮАХ-т (2020-2024)** нь хүүхэд хамгааллын чиглэлээр хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого; хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах ТХБ байгуулах; мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавьж, урьдчилан сэргийлэх; хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлд өргөжүүлэх; ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлэх, гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, хүүхдийн тэтгэмж тогтоох болон төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах зүйн орчныг бүрдүүлэх зорилтуудыг тусган хэрэгжүүлж байна.

63. **Үндэсний хууль тогтоомж.** ХЭК-ийн зарчмыг шингээн 1996 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль нь хүүхдийн эрхийн анхны бие даасан хууль болсон бөгөөд хорин жил хэрэгжүүлээд түүнийг 2016 онд шинэчлэн найруулж Хүүхдийн эрхийн тухай хууль нэртэйгээр шинэчлэн баталсан. 2016-2017 онд шинээр баталсан болон шинэчлэн найруулж Хүүхэд харах үйлчилгээний тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, хууль, Эрүүгийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зэрэг хуулиудад хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, тусламж үйлчилгээ үзүүлэх зохицуулалтуудыг нарийвчлан оруулсан юм. Энэ үед Хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулийг баталснаар хүүхэд хамгааллын үндэсний тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг хуульчилж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг нийгмийн бүх орчинд хориглосон дэлхийн 49 дэх орон болсон.⁴⁷

⁴⁷ End Corporal Punishment. <https://endcorporalpunishment.org/mongolia-becomes-49th-state-to-prohibit-all-corporal-punishment/>

64. Нийгмийн харилцааны суурь хууль дахь хүүхэд хамгааллын зарим зохицуулалтыг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3: Үндэсний хуулиуд дахь хамгааллын зарим зохицуулалт

№	Хуулийн нэр	Хүүхэд хамгаалалтай холбоотой асуудал
1	Үндсэн хууль	● Үндсэн хуулийн дагуу иргэнийхээ хувьд хүүхэд амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хувийн өмчтэй байх, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох, эвлэлдэн нэгдэх, төрийн байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах, шийдвэрлүүлэх, халдашгүй чөлөөтэй байх, шашин шүтэх эс шүтэх, итгэл үнэмшилтэй байх, үг хэлэх, жагсах, шударга шүүхээр шүүлгэх, мэдээлэл хайх, олж авах, ерөнхий боловсролыг төлбөргүй эзэмших зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх эрхтэй. ● Монгол Улсын иргэд Үндсэн хуулиараа үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх журамт үүрэг хүлээдэг. Мөн хүний амь насыг бусниулахыг хатуу хориглож түүнчлэн албадан хөдөлмөрлүүлэхийг, үзэл бодлоор эвлэлдсэний төлөө хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг, хэнд ч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг, гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдоогүй байхад гэм буруутайд тооцох, гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглодог. ● Үндсэн хуулийн эдгээр зохицуулалтыг баталгаажуулсан Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль 1996 оноос хойш үйлчилж байна. Энэ хуулиар хүүхэд төрмөгц нэр авах, харьяат байх, эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинд, хүчирхийллээс ангид, эцэг эхтэйгээ амьдрах, тэдний хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх нь гэр бүл цуцалтаас үед хэнтэй нь амьдрах саналаа илэрхийлэх, төрөөс эмнэлгийн тусламж, тэтгэвэр, тэтгэмж, асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ авах, эцэг, эхийн хамт гадаадад цагаачлах, дүрвэх, байнга болон түр оршин суух, эх орондоо амьдрах эрхийг баталгаажуулсан.
2	Иргэний хууль	● Тус хуулийн дагуу насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна. Бүрэн бус чадамжтай иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хууль ёсны төлөөлөгчийн бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хийнэ. Насанд хүрээгүй хүүхэд өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран зарцуулах, өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцэл хийх эрхийг хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр бие даан хэрэгжүүлж болно. Мөн тус хуулиар 7-гоос 14 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн зарим чадамжтай, 7 хүртэлх насны этгээдийг иргэний эрх зүйн чадамжгүй гэж тус тус тодорхойлсон.
3	Эрүүгийн хууль	● Эрүүгийн хуулийн ерөнхий ангид зааснаар гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин 14-16 хүртэлх насны хүн уг хуулийн тусгай ангийн хүнийг алах, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, хүчиндэх, хулгайлах, дээрэмдэх зэрэг арван хоёр төрлийн гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэмт хэрэг үйлдэх үедээ 14

		насанд хүрсэн ба 18 насанд хүрээгүй хүнд ял оногдуулахгүйгээр энэ хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно. Өсвөр насны хүн сэтгэцийн хөгжлийн хоцрогдлын улмаас өөрийн үйлдэл, эс үйлдэхүүн хууль бус шинж, түүний улмаас учрах хор уршгийг бүрэн хэмжээгээр ухамсарлах чадваргүй бол ял оногдуулахгүй байж болно.
4	Боловсролын тухай хууль	● Боловсролын тухай хуулиар хүүхэд сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмших, төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөх; оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах; чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийгөө хөгжүүлэх хүүхдийн эрхийг хуулиар баталгаажуулсан.
5	Хөдөлмөрийн тухай хууль	● Хөдөлмөрийн тухай хуулиар 16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй боловч насанд хүрээгүй хүнийг оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэх, шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажилд ажиллуулахыг хориглоно. Мөн ажлын цагийг 14-15 насны ажилтанд 30 цаг хүртэл 16-17 насны болон хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд 36 цаг хүртэл байхаар богиносгож насанд хүрээгүй ажилтны эрүүл мэндийг хамгаалдаг. ● 2022 оны 1-р дүгээр сарын 1-наас мөрдөгдөх Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ажил олгогч ажилтныг хүүхдээ хөхүүлэх өрөөгөөр хангах арга хэмжээг авах, жирэмсэн болон 0-3 насны хүүхэдтэй эх /ганц бие эцэг/-ийг шөнийн буюу илүү цагаар, нийтээр амрах болон долоо хоногийн амралтын өдөр, албан томилолтоор ажиллуулахыг хориглох, шинэ аавын 10 хоногийн цалинтай чөлөө, байнгын асаргаатай хүүхдээ асарч байгаа эцэг, эх тодорхой хэмжээний хөнгөлөлт эдлүүлэх зэрэг шинэ заалтууд тусгагдсан байна.
6	Гэр бүлийн тухай хууль	● Гэр бүлийн тухай хууль 1999 оноос хойш шинэчлэгдээгүй. Хүүхдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 онд батлагдсантай холбоотойгоор Гэр бүлийн тухай хуулинд ямар нэгэн өөрчлөлт ороогүй бол Хүүхэд хамгааллын хуулийг баталсантай холбоотой “эрсдэлд нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн тодорхойлолтыг нэмсэн. Гэхдээ хүчин төгөлдөр уг хуульд хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдлэх, гэрлэгчид дагавар хүүхдийг ялгаварлан гадуурхаж, эрх, ашиг сонирхлыг нь хохироохгүй байх, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, эцэг, эх хүүхдийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдвөл Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийг томилох, гэрлэгчид гэрлэлт цуцлуулах үед хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзэх, бүтэн өнчин, эцэг, эх нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх бололцоогүй, эсхүл зайлсхийсэн бол хүүхдийн эрх, ашиг сонирхлыг Засаг дарга хамгаалах зохицуулалт байдаг. ● Мөн эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар хүүхдээсээ тусдаа амьдарч байгаа нөхцөлд Засаг дарга, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага хяналт тавих, хүүхдийг орон сууц, хувцас, хоол ундаар байнга санаатай гачигдуулсан, хөдөлмөрийг нь зүй бусаар ашигласан, гуйлгачлуулсан, орон гэрээсээ дайжуулсан, гадуурхсан хүний эцэг, эх байх эрхийг зургаан сар хүртэл хугацаагаар шүүхээр хязгаарлуулах, хүнд нөхцөлд байгаа бага насны буюу насанд хүрээгүй хүүхдийг бусад гэр бүлд асруулахаар шийдвэрлэх эрхтэй.

		Эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан /хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх, шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр/, хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүний эцэг, эх байх эрхийг хасах, сэргээх эсэхийг шүүхээр шийдвэрлүүлдэг. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй. Энэхүү үүргээ эцэг, эх нь харилцан тохиролцож гэрээ байгуулан шийдвэрлэж болохоор хуульд заасан. Хэрэв тэтгэлгийн хэмжээг харилцан тохиролцоогүй, тохиролцоонд хүрч чадаагүй, гэрээ байгуулаагүй тохиолдолд тэтгэлгийн хэмжээг шүүх тогтооно. Хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй бол нэмэлт тэтгэлэг авах боломжтой. Тэтгэлгээ тогтмол авч байгаа хүүхдийн тоо нь тухайн жилд шүүхийн шийдвэрээр тэтгэлэг авах шаардлагатай хүүхдүүдээс тэтгэлгээ тогтмол авч байгаа хүүхдийн эзлэх хувиар илэрхийлнэ.
7	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	Тус хууль 2005 оноос үйлчилж эхэлсэн уг хуулийн 2016 оны шинэчлэлтээр хохирогч хүүхдийг хамгаалах үйлчилгээг нарийвчлан зохицуулсан байна. Хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангахаар зохицуулсан. Мөн энэ чиглэлээрх үйл ажиллагааны зохих журмуудыг эрх бүхий талууд баталж, цагдаа, эрүүл мэнд, нийгмийн ажилтнууд зэрэг мэргэжилтнүүд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж эхэлсэн.
8	Хүний эрхийн комиссын тухай хууль	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль энэ онд шинэчлэн батлагдсан. Уг хуулийн шинэчилсэн найруулгад Комисс болон Комиссын гишүүний бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, хүний эрхийн зөрчлийг хянан шийдвэрлэх, гомдол, мэдээлэл хүлээн авах зэрэг бүхий л зохицуулалтыг шинэчилсэн. ХЭҮК-т Эрүүдэн шүүхийн эсрэг асуудлаар бие даасан гишүүн ажиллах болсон нь чухал. Түүнчлэн Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдан энэ оны 7 дугаар сарын 1 ээс хэрэгжиж эхлэхээр бэлтгэж байна. Энэ хуулийн дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороог байгуулж, Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн тус хороог удирдана. Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд хүний эрхийн төлөв байдлын талаарх өөрийн гаргасан жил бүрийн тайлангаа УИХ –д нээлттэй хэлэлцүүлдэг.
9	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн тухай	Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.

10	Хүүхэд харах үйлчилгээний тухай	Энэ хуулийн зорилт нь эрүүл, аюулгүй орчинд хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.
11	Эрүүгийн тухай хууль	Эрүүгийн хуулийн ерөнхий ангид зааснаар гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин 14-16 хүртэл насны хүн уг хуулийн тусгай ангийн хүнийг алах, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, хүчиндэх, хулгайлах, дээрэмдэх зэрэг арван хоёр төрлийн гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн ба 18 насанд хүрээгүй хүнд ял оногдуулахгүйгээр энэ хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно. Өсвөр насны хүн сэтгэцийн хөгжлийн хоцрогдлын улмаас өөрийн үйлдэл, эс үйлдэхүүн хууль бус шинж, түүний улмаас учрах хор уршгийг бүрэн хэмжээгээр ухамсарлах чадваргүй бол ял оногдуулахгүй байж болно
12	Зөрчлийн тухай	Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд чиглэдэг.

65. **Цаашдын төлөвлөлт.** 2020-2024 оны УИХ өөрийн бүрэн эрхийн хугацаанд хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн парламент байх зорилгыг тавьж Монгол Улсад хүчин төгөлдөр байгаа 700 гаруй хууль ялангуяа идэвхтэй хэрэгждэг 400 гаруй хуульд хүний эрхийн үнэлгээ хийхээр төлөвлөн ажиллаж байна.⁴⁸ 2021 онд Монгол Улс Хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийг ази тивд анх удаа баталсан орон болоод байна.⁴⁹ 2021 оны 7 дугаар сарын 1-ээс хэрэгжиж эхлэх уг хуулиар хүний заяамал эрх түүнийг хамгаалах үйл ажиллагаанаас эхлэн улмаар хүний эрх хамгаалагчийн эрхийн тухай асуудлаар хүний эрхийн шинэ ойлголтыг бий болгож байна. Мөн түүнчлэн, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг НҮБ-ын Хүүхдийн Сан болон ДЗМОУБ-ын дэмжлэгтэйгээр хөндлөнгийн үнэлгээ хийсэн байна. Засгийн газрын зүгээс дээрх хуулиудын нэмэлт өөрчлөлт төслийг судалж бэлтгэж байна.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮТЭЦ

66. Хүүхдийн эрхийн талаарх төрийн бодлого, хөтөлбөр, хууль болон холбогдох журмуудыг баталж үйл ажиллагааны салбар чиглэлүүдээр олон шинэ болон шинэчилсэн бүтэц, зохион байгуулалтууд бий болсон. Үүнд:

- 2016 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан агентлаг;
- 2016 онд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан агентлагийн дэргэд 108 хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төв;
- 2016 онд Монголын нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний болон салбар хороо;
- 2016 онд Нэг цэгийн үйлчилгээний төв;


⁴⁸ УИХ-ын гишүүнтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

⁴⁹ НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар. 2021.

<https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/MongoliaHumanRightsLaw.aspx>

- 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс;
- 2017 онд 108 хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төвийн дэргэд Түр хамгаалах байр;
- 2017 онд Сургалт, судалгаа, мэдээллийн төв;
- 2016 онд Монголын нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний болон салбар хороо;
- 2017 онд Хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх, сурган хүмүүжүүлэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх төв;
- 2017 онд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо
- 2017 онд Хамтарсан баг;
- 2017 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон дэд зөвлөлүүд тус тус байгуулагдсан байна.


67. Үндэсний хэмжээний хүүхэд хамгааллын тогтолцооны өнөөгийн зураглалыг доорх байдлаар гаргасан бөгөөд үндэсний хэмжээнд ХНХЯ, ХЗДХЯ, ГБХЗГ, ГХЗУСАЗЗАА зэрэг талууд тэргүүлэх үүргийг гүйцэтгэж байна. 2021 онд ХНХЯ-ны бүтэц шинэчлэгдэн Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтэс ажиллах болов. Орон нутгийн түвшин ГБХЗХБ, ГХЗУСАЗЗСЗ, нутгийн өөрөө удирдах байгууллага, харин орон нутгийн түвшинд ХЭХЗХ, анхан шатанд Хамтарсан баг хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үүргийг хүлээж байна.



— хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүд

— хамтарсан багийн гишүүд

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО



— ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТӨЛӨӨ ҮНДСЭНИЙ ЗӨВЛӨЛЛИЙН ГИШТД


— ХАМТАРСАН БАГҮЙН ГИШҮҮД

68. **Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам** нь Хүн амын хөгжлийн газрын Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтэст хоёр мэргэжилтэн хүүхэд хамгааллын асуудлыг хариуцан бодлого, зохицуулалтаар ханган ажиллаж байна. Мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтод хүүхдийн эрх, хамгааллын бодлого зохицуулалтыг хангаж ажиллах зорилт, үйл ажиллагааг тодорхойлсон байна. 2021 оны 5 сард тус яамны бүтэц дахин шинэчлэгдэн Гэр бүл, хүн амын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон түүний дор Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтэс бий болгон ажиллах хүний нөөцийг нэмэгдүүлж байгаа нь сайшаалтай юм.

69. **Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл.** Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлсэн тус зөвлөлийн бүрэлдэхүүнд бүх яамдын дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нар, ОУБ-ын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл нийт 45 хүн ажилладаг байна. Энэ бүтэц 1995 оноос хойш ажиллаж байгаа ч хүүхэд хамгааллын тогтолцооны салбар дундын зохицуулалтыг хангаж ажиллах оновчтой хэлбэр мөн эсэхэд эргэлзмээр.

70. **Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар.** Хүүхдийн эрхийг хангах бодлогыг хэрэгжүүлэгч үндэсний байгууллагыг Засгийн газрын бүтцэд 1991 онд анх бий болсон бөгөөд 2016 оноос гэр бүл, залуучуудын хөгжлийн асуудлыг нэмж хариуцуулан ЗГХА-ГБХЗГ болгон өөрчлөн зохион байгуулсан. Эдүгээ тус агентлаг нь орон нутаг, харьяа байгууллагын нийт 1,054 гаруй ажилтныг нэгтгэсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг статустай бодлогын хэрэгжилтийг хангах үндэсний гол механизм болсон байна. 2016 онд нийгмийн тухай багц хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор тус агентлагийн чиг үүрэг хэд дахин нэмэгдсэн ч орон тооны хувьд төдийлөн нэмэгдээгүй байна. Хавсралт-1 ГБХЗХГ-ын хуулиар хүлээсэн үүргийг харна уу.

График 4: Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын бүтэц, зохион байгуулалт



71. Тус байгууллага нь хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, хүүхэд, гэр бүлд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх анхан, дунд шатанд ажиллах чиг үүрэг бүхий нэгж,

субъект⁵⁰, албан тушаалтнууд⁵¹ сонгуульт үүрэгтэн, сайн дурын байгууллага, ажилтнууд⁵² болон нийгмийн үйлчилгээний болон хууль сахиулах зэрэг талуудын үйл ажиллагааг уялдуулах, хамтын ажиллагааг дэмжих үүрэгтэй. ГБХЗХГ-ын ажилтнуудын хандлага, мэргэжлийн ур чадвар сул, ажлын байранд тогтворгүй, ойр ойрхон солигддог төдийгүй улс төрийн нөлөөгөөр удирдлага, мэргэжилтнийг солих хандлага тогтож байна.

72. Улс төрийн намын нөлөөгөөр тус агентлагийн албан тушаалд төрийн албаны мэргэшсэн байдлыг үл харгалзан томилдог нь байгууллагын үйл ажиллагаа, удирдлагын тогтвортой байдал, алсын хараанд сөргөөр нөлөөлж байна. Мөн түүнчлэн, ГБХЗХГ-ын үйл ажиллагааг шинжлэхэд орон нутагт гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан байгууллагын дотоод нэгжүүд ажлын уялдаагүй, ачаалал тэнцвэргүй байна. Жишээ нь: Аймаг, дүүргийн хэлтэст хүүхэд хамгаалал хариуцсан хоёр мэргэжилтэн ажилладгийн нэг нь Улсын байцаагчийн ажлыг давхар хариуцан ажиллаж байна.

73. Хүүхдийн эрхийн тухай хуульд туссан хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан, ГБХЗХГ-ын нийгмийн ажилтан, орон нутгийн ГБХЗХГ-ын нийгмийн ажилтан, Хүүхдийн эрхийн ажилтан, улсын байцаагч гэсэн албан тушаалын чиг үүргийг нарийвчлах, мэргэжлийн хүнийг тогтвортой ажиллуулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын ажилтны эрүүл мэнд, сэтгэл зүйг хамгаалахын зэрэгцээ хүүхдийн эрхийг хангах ажлын байрны шаардлагын дагуу тасралтгүй сургаж, лицензжүүлэх, мэргэшүүлэх, урамшуулж дэмжих, нийгмийн хамгааллыг нь сайжруулах шаардлагатай.

⁵⁰ Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлүүд 1995 оноос өнөөг хүртэл сум, дүүрэг, аймаг, нийслэл болон үндэсний хэмжээнд, 2014 оноос Хүүхдийн тусламжийн 24 цагийн үйлчилгээ бүхий үнэ төлбөргүй утас, 2016 оноос аймаг дүүргийн түвшинд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, аймаг дүүргийн түвшинд, анхан шатны нэгж сум, хорооны түвшинд Хамтарсан баг, 2018 оноос хохирогчийг ТХБ-ууд, 2020 оноос ЕБС –дад Хүүхэд хамгааллын баг ажиллаж байна.

⁵¹ Хүүхдийн асуудал эрхэлсэн ажилтан, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сургуулийн нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, улсын байцаагч болон хүүхэд, өсвөр үеийнхнээс сонгогдсон хүүхдийн элч хэмээх сонгуультан сум, дүүрэгт ажиллах боллоо.

⁵² Төрийн бус байгууллагын болон олон улсын байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн ажилтнууд, хүүхэд хамгаалагч нарын зэрэг

4. ХҮҮХЭД ХАМГААЛАЛ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



4. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ХҮҮХЭД ХАМГААЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

74. **Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилт.** Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид нэгдэн орсноос хойш манай улс конвенцын хэрэгжилтийн тайлан илтгэлийг таван удаа НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд (ХЭХ) хүргүүлэн, хэлэлцүүлсэн юм. 2017 онд ХЭК-ийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын тавдугаар тайланг хэлэлцээд, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос ирүүлсэн дүгнэлт зөвлөмжид Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протоколыг соёрхон баталсан мөн хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэргийг шинэчлэн найруулсныг сайшаасан байна. ХЭК-ын Илтгэлийг хэлэлцээд Хорооны зүгээс нөөцийн хуваарилалт; хүүхдийн эрх ба бизнесийн салбар; ялгаварлан гадуурхахгүй байх; гэр бүлийн орчин; орчны эрүүл ахуй; эдийн засгийн мөлжлөг, хүүхдийн хөдөлмөр, хурдан морь унаач хүүхдийн асуудалд яаралтай арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт зөвлөсөн.⁵³

75. **Хүний эрхийн төлөв байдлын талаарх ээлжит дүгнэлт, хэлэлцүүлгийн тайланд.** 2020 онд Хүний эрхийн төлөв байдлын гурав дахь циклийн тайланг Засгийн газар, иргэний нийгэм болон бусад талуудаас илгээсэн байна. Хүний эрхийн зөвлөлийн 46-р хуралдааны Монгол дахь хүний эрхийн төлөв байдлыг улс орнууд хэлэлцэн 71 төлөөлөгчид санал, зөвлөмж өгсөн байна. Эдгээр санал зөвлөмжөөс хүүхэд хамгааллын талаарх зөвлөмжийг дүгнэн үзвэл хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийг таслан зогсоох; орчин үеийн боолчлолын бүхий л хэлбэрийг гэмт хэрэгт тооцох, хүүхэд эмэгтэйчүүдийн хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар дотоодын хууль тогтоомжийг бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлэх; хүүхдийн хувийн нууцыг тэр дундаа бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдийг нууцын эрхийг хангах талаар үндэсний хууль тогтоомжид тусгах; ХЭХ-оос хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний журмын талаарх №6 ерөнхий зөвлөмжийг харгалзан үзэх; хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн мөлжлөгтэй тэмцэх; хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах; хүний нөөц, чадавх, санхүүгийн нөөцөөр дэмжсэн хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө батлах зэрэг байв.⁵⁴

76. **Үндэсний хууль тогтоомжийн шинэчлэл.** Хүүхэд хамгааллын асуудлаар 2016 оноос хойших эрх зүйн орчны шинэчлэлийн дүнд хүүхэд хамгааллын талаарх ойлголт, нэр томъёо тодорхой болж, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг мэдээлэх, түүнийг хүлээн авч бүртгэх, тухайн тохиолдолд хариу үйлчилгээ, арга хэмжээг шуурхай үзүүлэх нөхцөл бүрдсэн. Энэ хүрээнд хуулиар чиг үүрэг хүлээсэн төрийн байгууллага, албан тушаалтны хариуцлага тодорхой болсон, тэдний хамтын ажиллагаа ялангуяа хүүхдийн болон цагдаа, хууль сахиулах байгууллагын хүрээнд нэмэгджээ. Үйлчилгээний холбоотой дэд бүтэц буюу ТХБ болон НЦҮТ-ийн орчин, ажил үйлчилгээний хөрөнгө төсөв, санхүүжилтийн хэмжээ өмнөхөөс хэд дахин нэмэгдсэн. Мөн Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүүхдийн элч, сум болон багийн Хамтарсан баг, аймаг, дүүргүүд ХЭХЗ-той болж хүүхэд хамгааллын үйлчилгээг бэхжүүлэх боломж нээгдсэн. Сум, хороо, сургууль, эрүүл мэндийн байгууллага, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага, нэгжид нийгмийн ажилтан, сэтгэл зүйч ажиллах, хүүхэд олон цугларах орчинд Сургуулийн хүүхэд

⁵³ Committee on the Rights of the Child. 2017. *Concluding observations on the fifth periodic report of Mongolia*

⁵⁴ Human Rights Council. 2020. *Report of the Working Group on the Universal Periodic Review*

хамгааллын баг, эцэг эхийн зөвлөлүүд ажиллах болж тэдний гол анхааралд хүчирхийллээс сэргийлэх, хариу арга хэмжээ авах асуудалд чиглэж эхэлжээ. Нийгмийн ажилтан мэргэшсэн, чадавхтай байх төдийгүй тэдний ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүргийг Засаг дарга нар хүлээх болсон. Энэ оны 7 дугаар сарын 1-ээс шинээр хэрэгжиж эхлэх Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын хуулийн дагуу хүүхэд, гэр бүлтэй ажиллаж, тэдний эрх ашгийг хамгаалдаг иргэний нийгмийн байгууллага, ажиллах орчин төдийгүй ажилтны нийгмийн баталгаа бүрдэх болж байгаа зэрэг ахиц дэвшлүүд бий.

77. **Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилт.** Хүүхэд хамгааллын зөрчил, асуудлыг таних, илрүүлэх, мэдээлэх, бүртгэх, шалгах улмаар хариу арга хэмжээ авч ажиллах үндсэн нөхцөл, түүнд хамтран ажиллах механизм, талуудын үүрэг, оролцоог тодорхойлсон шинэхэн хуулийн хэрэглээ, үр нөлөөг чамлахааргүй байна. Үндэсний болон аймаг, нийслэлийн түвшинд хүүхэд хамгааллын удирдлага хүний болон санхүүгийн нөөц харьцангуй бэхжих, үйлчилгээний хүртээмж нэмэгдэх, ойлголт, хамтын ажиллагааны нэгдмэл байдал дээшилсэн байна. Гэвч анхан шатны нэгжид буюу гэр бүл, хүүхдэд хүрч ажиллан эрсдэлд хүчин зүйлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд хүний болон санхүүгийн нөөц нэмэгдээгүй хэвээр байна.

78. УИХ-ын Хууль зүйн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороод хамтран 2019 оны 5 дугаар сарын 29-нд Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Ерөнхий хяналтын сонсголыг анх удаа зохион байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцтай танилцан, холбогдох чиглэл, зөвлөмж гаргажээ.

79. Үйлчилгээний гол механизмын уялдааны талаарх хууль хоорондын зохицуулалт сул, хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай холбоотой хуулиудыг дагаж гарсан журмууд нь хүчирхийллийн хохирогч, гэрч хүүхдийг хамгаалахад голлон анхаарснаас хөдөлмөр эрхэлдэг, ялгаварлан гадуурхагдсан зэрэг хүүхдэд шаардлагатай үйлчилгээгээ авч чадаж буй нь эргэлзээтэй байна. Зөрчил, дуудлага цагдаагийн байгууллага эсвэл ХТУ-аар хүлээн авч бүртгэсэн дуудлага, мэдээллээр үйлчилгээний бүртгэл хязгаарлагдаж байна. Үйлчилгээ үзүүлэгч талуудыг магадлан итгэмжилж, стандарт шаардлага, удирдамжийг хэрэгжүүлэх төрийн бус байгууллага, иргэний нийгмийн чадавх бэхжилт орон нутагт удаашралтай байна.

80. НҮБ-ын Хүүхдийн Сангийн захиалгаар Корам Интернэйшнл Хүүхэд хамгааллын тухай хуулийн үнэлгээг 2021 онд гүйцэтгэсэн байна. Үнэлгээний тайланд өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд олон ахиц дэвшил гарсан ч хүүхэд хамгааллын үйлчилгээ хүртээмжгүй, хүний нөөцийн чадавх сул, санхүүжилт дутмаг, мэдээлэл цуглуулалт болон кейс менежмент хангалтгүй зэрэг олон шалтгааны улмаас хуулийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай хэмээн дүгнэсэн байна.⁵⁵

81. **Хүүхэд хамгаалалтай холбоотой хуульчилсан актын хэрэгжилт.** Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хуульд заасан дараах журмыг баталж хэрэгжүүлж байна. Үүнд:

⁵⁵ Aplan, K.; Hamilton, D. C.; Burke, C. & Arndt, J. 2021. Evaluation Report: Evaluation of the Implementation of the Law on Child Protection in Mongolia. London

Хүснэгт 4: Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг хуулийн хэрэгжилтийг хангах хуульчилсан актууд

Актын дугаар	Тушаалын хавсралтын нэр
ХНХС, ХЗДХС, ЭМС-ын тушаал 2017.10.04 А-173/А-251/А-3801	Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам
ХНХС, ХЗДХС-ын тушаал 2017.07.04, А-1201/А-178	Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам
ХЗДХС, ХНХС, ЭМС-ын тушаал 2017.04.06 А-841/А-59/А-130	Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам
ХЗДХС-ын тушаал 2017.04.04 А-73	- Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр - Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам
ХЗДХС, ЭМС, ХНХС-ын тушаал 2017.04.06 А-80/А-132/ А-60	Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам
ХНХС-ын тушаал 2017.04.20 А-74	Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх журам
ХНХС-ын тушаал 2017.04.20	Холбон зуучлах үйлчилгээний журам
ХНХС-ын тушаал 2017.02.23 А-33	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам
БСШУС-ын тушаал 2018.05.01 А-239	Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам
БСШУС-ын тушаал 2018.10.01 А-612	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам
ЭМС-ын тушаал 2017.10.12 А-394	- Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам - Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам - Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам
ХЗДХС-ын тушаал 2017.01.31 А-25	- Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам - Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам
УЕП, ХЗДХС-ын тушаал 2017.06.30 А-70/А-174	Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам
УЕП, ХЗДХС-ын тушаал 2017.02.09 А-22/А-31	Гэр бүлийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам
ХЗДХС, ХНХС, ЭМС-ын тушаал 2017.03.22 А-63/ А-48/ А-106	Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журам
ХЗДХС-ын тушаал 2017.02.06 А-29	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам
ХЗДХС-ын тушаал 2017.02.14 А-38	Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам

ХЗДХС-ын тушаал 2017.02.14 А-37	- Аюулын зэргийн үнэлгээ хийх журам - Хохирогчийн аюулгүйн зэргийн үнэлгээний маягт, аргачлал - Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн аюулын зэргийн үнэлгээний маягт, үнэлэх аргачлал
ХЗДХС-ын тушаал 2017.02.14 А-39	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам, холбогдох маягтууд
ХНХС-ын тушаал 2017.12.26 А-331	Хүүхдийн эрхийн мэдээллийн санг бүрдүүлж, ашиглах журам
ХНХС-ын тушаал 2016.07.06 А-79	Хүүхдийн эрхийн ажилтны ажиллах журам
ХНХС-ын тушаал 2016.12.26 А-330	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам
ХНХС, ХЗДХС-ын тушаал 2017.03.27 А-51/А-69	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам
ХЗДХС, ХНХС-ын тушаал 2017.03.12 А-56/ А-35	Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журам
ХНХС-ын тушаал 2017.06.23 А-116	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам
ХНХС-ын тушаал 2016.12.26 А-329	Монголын нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм

82. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг шинээр батлагдсан хуулиудын хэрэгжилтийг дэмжин, хуульд заасны дагуу гарсан олон журмыг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байна. Дээрх хуулиуд батлагдмагц хэрэгжиж эхлэх хугацаа богино, дагалдах журмуудыг эхлэх хугацаа богино байх нь баримт бичгийн төслийг шуурхай боловсруулах, зарим акт, журмуудыг хэрэглэх талаар сургалт явуулаагүй зэргээс ойлголтын зөрүү үүсэх, гол хэрэгжүүлэгч Хамтарсан баг, ХЭХЗХ-ын үйл ажиллагаанд удирдамж, арга зүй, төсөв нөөц дутагдах зэрэг хэрэгжилтийг сааруулах нөлөөлөл ажиглагдаж байна. Гэхдээ тодорхой хугацаанд туршиж шалгасан журмуудад үнэлгээ хийх, сайжруулах ажил алхам алхамаар явагдсаар байна.

83. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чадавх орон нутагт тогтворжоогүй нь мэргэшсэн хүний нөөц дутагдалтай, үүрэг хүлээсэн ажилтны ажлын ачаалал их, тогтвор суурьшилгүй байх, нэг ажилтанд олон ажлыг давхардуулан өгдөг зэрэг нөлөөлж байна.⁵⁶ Иймд журмуудыг хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Нэрлэвэл, хэрэгжүүлбэл хуулиуд хангалттай байна. Хууль дагасан журмууд олон байна. Аль алины хэрэгжилт л алга. Монгол Улсын бодлого, хууль, журмууд чанарын хувьд дор орохгүй. Гагцхүү түүнийг хэн, хаана, хэрхэн хийх, хэдэн төгрөгийн зардал шаардлагатай вэ? Гэдэг асуултыг хариулдаггүй үлдээдэг. Хуулиудынхаа уялдааг хангахуйцаар бичиж чаддаггүй.

Ганцаарчилсан ярилцлагаас

84. Хүчин төгөлдөр байгаа журмуудыг сайжруулахдаа хүүхэд хамгааллын үйлчилгээ механизмтай холбоотой хуулиудад үндэслэн хүүхдэд үзүүлэх үйлчилгээг зааглан, хамаарах субъектын онцлог хэрэгцээ, нөхцөл байдалтай уялдуулан үйлчилгээг


⁵⁶ Монгол Улсын Хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ 2018

төрөлжүүлэх, шаардлагатай үйлчилгээний талаарх журмуудын уялдааг хангахад анхаарах шаардлагатай байна.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ МЕХАНИЗМ

85. Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн дагуу дараах загвараар хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлж байна. Хүчирхийллийн хохирогч хүүхдийн талаар хүүхэд өрөө, найз нөхөд, хэн нэгэн иргэн, багш, эмч, төрийн байгууллагын мэргэжилтнүүд цагдаа, нийгмийн ажилтан, Хамтарсан баг нь яаралтай тусламжийн утас (102, 103, 107, 108) болон ТББ-д мэдээлснээр үйлчилгээ эхэлдэг байна. Мэдээлэл хүлээн авсан байгууллага дуудлагыг нөхцөл байдал, аюулын зэргээс хамааран Хамтарсан баг, тухайн аймаг, дүүргийн ГБХЗХБ, цагдаад шилжүүлдэг байна. Дуудлагын мөрөөр очсон үүрэг хүлээгч талууд мэдээллийг бүртгэн авах, яаралтай тусламж, зөвлөгөө үзүүлэх, нөхцөл байдлыг үнэлэх, аюулын зэргийг тодорхойлох, хүчирхийлэгчийг тусгаарлах, таслан зогсоох даамжрахаас сэргийлэх үйлчилгээг үзүүлнэ. Бусад салбарын болон ТББ-ийн оролцоотойгоор хохирогчийг хамгаалах, тусгаарлах, яаралтай тусламж (эмнэлэг, шүүх шинжилгээ, гэмтлийн зэрэг, НЦҮТ, ТХБ, бусдын асрамж), хууль ёсны эрх ашгийг хамгаалах, АХХД, ХЕТ-ийг томилох, ХХША-нд оролцуулах, холбон зуучлах, гэр бүлтэй нь ажиллах, нийгэмд эргэн нэгтгэх, хяналт дэмжлэгийн үйлчилгээг үзүүлж байна.

График 5: Хүүхэд хамгааллын үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэх механизм




86. Хэдийгээр хариу үйлчилгээнд хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, асрамж халамжид хүлээлгэн өгсний дараа хяналт, дэмжлэгээ үзүүлнэ гэсэн боловч энэ үйлчилгээ хангалтгүй байна. Хөдөө орон нутгийн хүн ам цөөн, бие биенээ таньдаг, жижиг орон нутгийн хувьд хүүхэд дахин эрсдэлд орсныг мэдэхэд хялбар байдаг бол Улаанбаатар хотын хүн ам ихтэй хороодын хувьд кэйс хаагдсанаар тухайн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ зогсдог байна. Мөн хүүхэд хамгааллын нэгдсэн системгүйгээс хүүхэд нэг дүүргээс нөгөө дүүрэг рүү эсвэл аймаг хооронд шилжихэд тухайн хүүхэд өмнө нь ямар үйлчилгээ авч байсныг мэдэх боломжгүй байна.

87. Мөлжлөгийн хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд хохирогчийн талаар хандах, мэдээлэл хүргэх, хүлээн авах ажилд цагдаа, ХТУ-108, эцэг эх, асран хамгаалагч, гэр бүл, хүний эрхийг хамгаалагч, Хамтарсан баг, нийгмийн ажилтан, ангийн багш, сургууль, ТББ-ын оролцоотой байгаа бол хэрэг бүртгэх, шалгах ажлыг цагдаа, аюулгүй байдлыг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ зөвхөн төрийн бус байгууллагууд үзүүлэн ажиллаж


байна. Харин хилийн чандад мөлжлөгийн хохирогч болсон хүүхдэд элчин сайдын яам, консулын алба яаралтай тусламж үзүүлэх, түр хамгаалах, бичиг баримт олгох, эх орондоо буцаах ажлыг төрийн бусад байгууллага, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын тусламж дэмжлэгтэйгээр зохион байгуулж байна.

График 6: Мөлжлөгийн хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд хохирогчийн талаар хандах, мэдээлэл хүргэх



88. Харин хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр, хараа хяналтгүй хүүхдийн талаарх мэдээллийг ХТУ-108, цагдаагийн 102 утсанд ихэвчлэн ирдэг бөгөөд цагдаагийн ажилтан тухайн гуйлга гуйж байгаа эсвэл хараа хяналтгүй хүүхдийг очиж авч, цагдаагийн хэлтэст авчран нөхцөл байдлын үнэлгээ хийнэ. Үүний дараа цагдаагийн ажилтан тухай хүүхдийн АХХД, ХЕТ-ийг тогтоон, тухайн хүүхдийн нөхцөл байдлаас хамаарч хэрэг шалгах ажиллагаа явуулах эсэхийг шийдвэрлэдэг байна. Үүний дараа тухайн хүүхдийн харьяа ГБХЗХБ-д шилжүүлэн өгдөг байна. ГБХЗХБ болон Хамтарсан багийн зүгээс хариу үйлчилгээний хэрэгцээг тодорхойлон, төлөвлөгөө гаргаж шаардлагатай гэж үзвэл тодорхой хугацаагаар асрах үйлчилгээнд авах эсвэл бусад салбарын үйлчилгээнд холбон зуучилдаг байна. Хүүхэд хууль зөрчсөн нөхцөлд ХЭХЗХ-ны хүүхдийн кэйсийг шилжүүлэх, холбох замаар ажиллаж байна.

График 7: Хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхэлдэг хүүхдэд үзүүлэх үйлчилгээ



89. Өнөөгийн хүүхэд хамгааллын үйлчилгээ нь эрсдэлд нөхцөлд байгаа, гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэхэд чиглэн ажиллаж, урьдчилан сэргийлэх ажлыг төдийлөн хүртээмжтэйгээр тогтмол зохион байгуулж ажиллахгүй байна. ГБХЗХХ-ийн ажилтнуудтай хийсэн ярилцлагаар нийт ажлын 60-70 хувийг урьдчилан сэргийлэх ажилд зарцуулдаг бол Хамтарсан багийн түвшинд урьдчилан сэргийлэх ажлыг төдийлөн хийдэггүй гэсэн байна. Судалгаанд оролцсон эцэг эх, асран хамгаалагчид, үүрэг хүлээгчдийн хувьд эцэг эхэд хүүхдийн эрх, хамгаалал, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар тэдний хамгийн их ашигладаг мэдээллийг сувгаар дамжуулан мэдээлэл өгөх, биечлэн сургалтад хамруулах замаар хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх ажлыг хийх нь оновчтой юм.

90. **Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо.** МУЗГ НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтран хэрэгжүүлсэн арав гаруй жилийн хугацааны төслийн үр дүнд үндэслэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны (ХЭХЗХ) талаар анх удаа хуульчилжээ. Тус хуулийг үндэслэн уг хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг ХНХ-ын болон ХДЗХ-ийн сайд нар 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А-51, А-69 дүгээр хамтарсан тушаалаар баталсан. Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрт (2017-2021) гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, сэжигтэн, мөрдөн шалгагдаж байгаа, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, шүүхээр шийтгэгдсэн хүүхдэд хууль зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ХЭХЗХ-ны үйл ажиллагааг тогтмолжуулахаар тусгажээ.

91. ХЭХЗХ нь зөвхөн 21 аймаг, 9 дүүргийн түвшинд нийт 30 хороо нь төрийн байгууллагын 400 шахам удирдах албан тушаалтнаас бүрдэн ажиллаж байна. Засгийн газрын тайлангаас харахад 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 852 хүүхдээс орон нутагт 684, нийслэлд 168 хүүхэд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээнд хамрагдсан байна.⁵⁷ Үйлчилгээ авсан хүүхдүүдийг ангилан доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5: Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа 2020 онд

Төрөл	Байршил	Тоо	Нийт
1. Гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлсэн	Орон нутагт	359	469
	Нийслэлд	110	
2. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг туслалцаа	Орон нутагт	23	25
	Нийслэлд	2	
3. Гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар саналыг	Орон нутагт	31	41
	Нийслэлд	10	
4. Хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөтөлбөрт	Орон нутагт	135	168
	Нийслэлд	33	

⁵⁷ Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн талаарх ГБХЗХГ-ын 2020 оны тайлангаас

5. Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага	Орон нутагт	121	190
	Нийслэлд	69	
6. Хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад	Орон нутагт	50	53
	Нийслэлд	3	
Нийт		121	121

92. ХЭХЗХ-ны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг 2021 оны эхэнд хийсэн үнэлгээний дагуу шинэчлэн батлахаар бэлтгэн хэлэлцэж байна. Үнэлгээний тайланд уг журам нь захиргааны ерөнхий хуультай нийцэх эсэх нь эргэлзээтэй, тухайлбал, бүртгэгдэх эсэх, хүчин төгөлдөр эсэх нь тодорхойгүй, уг журмын практик хэрэглээнд бусад хууль тогтоомжтой уялдуулан хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй, хэрэглэгдэх нэр томъёо нь зөрүүтэй байгааг дурджээ. Журмаар зохицуулсан харилцаанд хамааралтай Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зэрэг хуулиуд шинээр болон шинэчлэгдэн батлагдаж 2017 оны 7 дугаар сарын 1-ны өдрөөс мөрдөж эхэлсэн тул эдгээр хуулиудтай нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах, мөн шинэчлэн найруулсан Өмгөөллийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиуд болон Шүүхийн тухай хууль (2021 онд) батлагдсан тул тэдгээртэй уялдуулах шаардлага байна.


93. Судалгааны ярилцлага, баримт бичгийн шинжилгээний үр дүнгээс харахад ХЭХЗХ-ны үйл ажиллагаа үндэсний хэмжээнд харилцан адилгүй байгаа нь улс төрийн намын нөлөөллөөс болж гишүүд байнга солигддог; хүүхэд, өсвөр үеийнхэнтэй ажиллах арга зүй, чадвар сул, гишүүдийн ажил үүргийн хуваарь, гүйцэтгэлийн үнэлгээнд тус хороонд ажиллах талаар дурдаагүй, цалин урамшуулал байхгүй, ажлын ачаалал их, үйл ажиллагааны санхүүжилт хязгаарлагдмал зэрэг олон бэрхшээлтэй тулгарч байна. Тус хорооны үйл ажиллагааны журмын хэрэгжилтээс үзвэл ХЭХЗХ-ны үйл ажиллагааны тайлан тогтмол бус, тайлан мэдээлэлд нэгдсэн дүн шинжилгээ хийгддэггүй, нэгдсэн удирдлага хангалтгүй, хариуцлага, үр дүнг тооцдоггүй байна.

94. ХЭХЗХ нь хүүхэд сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжих хугацаанд ар гэрийн орчин нөхцөлийг холбогдогч байгууллагуудтай хамтран сайжруулах, суллагдсан хүүхдийг эргэн нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэгт холбогдох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, албадлагын арга хэмжээний хэрэгжилтийг хангах үүрэгтэй. Гэвч хүүхдийн ар гэртэй ажилладаггүй, суллагдсан хүүхдийг хүлээн авах, давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй байна. Тус хороодын үйлчилгээний чадавх, нэгдсэн удирдлага зохион байгуулалт сулаас гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд хохирогч төвтэй, жендэрийн мэдрэмжтэй үйлчилгээг үзүүлж чадахгүй байна. Мөн ярилцлагад оролцогч талуудын мэдээлснээр ХЭХЗХ нь ихэвчлэн улиралдаа нэг удаа, зарим аймаг, дүүрэгт жилдээ нэг удаа хуралдаж байгаа нь чамлалттай юм.

95. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагаас ковид-19 цар тахал үед хүүхдэд үзүүлж байгаа сөрөг нөлөөг бууруулах зорилгоор ХЭХЗХ-ын чадавхыг бэхжүүлэх замаар эрсдэлд бүлэг байгаа хүүхдүүд, гэмт хэрэг зөрчлийн хохирогч, холбогдогч хүүхдүүдэд үзүүлж буй хууль зүйн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны журам, гарын авлагыг шинэчилж байна.


96. **Хүүхдийн тусламжийн 108 утас.** 2014 онд Хүүхдийн төлөө үндэсний газар (одоогийн ГБХЗХГ), Мобиком корпораци, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын хамтран хэрэгжүүлсэн төслөөр мөн оны 6 сараас эхлэн 24 цагийн, төлбөргүй, шинэчилсэн системээр Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээ эхлүүлсэн билээ. 2016 онд Хүүхэд хамгааллын тухай хуулиар тус утасны үйл ажиллагааг хуульчилсан нь Хүүхдийн эрхийн тухай ХЭК-ийн хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд томоохон алхам болсон юм.

График 8: Хүүхдийн тусламжийн 108 утасны төвийн дуудлагын тоо



97. ХТУ-108 нь хүүхдийн эрхийг зөрчлийг мэдээлэх, зөвлөгөө, мэдээлэл авах үндсэн эх сурвалж болж олон нийтэд тэр дундаа хүүхдүүд дунд танигдсан байна. ДЗМОУБ, НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр ХТУ-108 мэдээлэл хүлээн авах эх сурвалж нэмэгдэж чатбокс, мессеж (sms) ашигладаг болсон нь сайшаалтай байна. Хүүхдэд мессеж үйлчилгээгээр үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгөх, хандах техникийн боломжийг бүрдүүлэхээр үүрэн телефоны бүх операторууд хамтран ажиллаж байна.

График 9: Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага, төрлөөр



98. Судалгааны явцад хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс ХТУ-г маш сайн мэдэж байсан бөгөөд өөрт нь асуудал тулгарвал тус утас руу залгана гэж хэлж байгаа нь тус утса олонд танигдсан байгааг илтгэнэ. Гэсэн ч дуудлага өгч байсан эцэг эх, хүүхдүүд ХТУ-ны үйлчилгээнд сэтгэл дундуур байгаагаа ярилцлагын үеэр илэрхийлсэн юм. Мөн хүүхдүүдийн зүгээс ХТУ-108-ийг гэмт хэрэг, зөрчлийг мэдээлэх 102 утастай адил залгасан даруй цагдаа ирж өөрт нь тусална гэдэг ойлголт давамгайлж байгаа нь ярилцлагын үеэр харагдаж байсан бөгөөд дуудлага өгтөл зөвхөн зөвлөгөө өгсөн хэмээж байлаа.

Манай хүүхэд 108 утас хүчирхийллийг таслан зогсооно гэсэн ойлголтыг зурагтаас авсан байсан. Нэг удаа хүүхэдтэйгээ муудалцахад хүүхэд 108 дуудсан. Дуудлагын дагуу цагдаа ирээд та 108 утсаар дуудуулсан тул гээд торгосон. Цагдаа хүүхдээс яагаад 108 утсаар яагаад дуудлага өгсөн шалтгааныг нь асуугаагүй.

Бүлгийн ярилцлагаас

Хөгжлийн бэрхшээлтэй аав хүүхдээ хичээлийг нь хийлгэх гээд зодоход хүүхэд нь 108 дуудсан. Аав хичээлийг нь зааж чадахгүй учраас аргаа барж ийм үйлдэлд хүрсэн гэв. Гэтэл тэр аавд хүүхдээ сургах чин хүсэл байсан. Ийм үед аавыг шийтгээд орхихгүйгээр сэтгэлзүйн зөвлөгөө, хүүхэдтэйгээ яаж ажиллах талаар зөвлөгөө, үйлчилгээ үзүүлдэг баймаар байна.

Ганцаарчилсан ярилцлагаас

99. **Мэдээллийн удирдлагын систем:** Дэлхийн бусад орны сайн туршлагаас харахад Хүүхэд хамгааллын мэдээллийн удирдлагын систем нь вэб дээр суурилсан кейс менежментийн систем болон мэдээллийн сангаас бүрдэх бөгөөд мэдээлэл хадгалах, боловсруулах, хүүхэд хамгааллын хяналт, үнэлгээг хийх замаар эрсдэлд байгаа хүүхдэд үзүүлэх үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлэн, кэйс менежментийг үр дүнтэй удирдах зорилготой байна. Тус систем үйлчилгээ үзүүлэгч, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч талуудад хүүхэд хамгааллын кэйсийн талаар үнэн бодит, найдвартай мэдээллийг, цаг тухай бүрд нь авах боломжийг олгодог тул мэдээллийн менежментийг хөнгөвчлөх мөн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал, уялдаа холбоо, шат дарааллыг хангахад ихээхэн дэмжлэг болдог байна. Цаашлаад хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжид мониторинг хийх, үр дүнд суурилсан бодлого боловсруулах ажилд ч ашиглагддаг.⁵⁸

100. ГБХЗХГ нь “Хүүхэд гэр бүлийн мэдээллийн сан” бүртгэлийн программыг ашиглаж байгаа бөгөөд уг сан нь уралдаанч хүүхдийн бүртгэл; асрамж халамжийн үйлчилгээ; хүүхдийн зуслан; эрсдэлийн үнэлгээ, явуулын бүртгэл, статистик, өрхийн бүртгэл гэсэн 8 цэстэй. Одоогоор сангаас хэрэглээнд зориулж тайлан гараагүй. Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд Хүүхдийн эрхийн мэдээллийн сан бүрдүүлэх; Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх; Залуучуудын мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөх гэсэн журмуудыг мөрддөг байна.⁵⁹

101. Монгол Улсын хувьд эрсдэлд нөхцөлд буй хүүхдийн мэдээллийн сан, асрамж халамжийн хүүхдийн мэдээллийн сан зэрэг олон жижиг мэдээллийн сангуудын сүүлийн 20 жилийн хугацаанд эрх бүхий байгууллага өөрийн дотоод хэрэгцээнд ашиглаж байна. Хүүхэд, гэр бүлийн мэдээллийн сангийн эрсдэлийн үнэлгээний программд 2020 оны жилийн эцсийн дүнгээр нийт 22,154 хүүхдийг бүртгэн авч, 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ГБХЗХГ, хэлтсүүд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж байна. Эдгээр хүүхдийн 9,723 нь эмэгтэй, 13,031 нь эрэгтэй бөгөөд 0-2 насны 966, 3-5 насны 9,759, 6-10 насны 7,334, 11-16 насны 7,859, 17-18 насны 1,929, 19-21 насны 907 хүүхэд бүртгэлтэй байна.⁶⁰ Цагдаагийн байгууллага ESC tablete, ESC программд гэр бүлийн хүчирхийллийн дуудлагыг

⁵⁸ International Medical Corps, UNICEF, UNHCR, Rescue, Terres de Hommes, & Institution for Family Health. 2019. Child Protection Information Management System: 2018 Child Protection Case Management Information and Data Analysis. Available at: <https://reliefweb.int/sites/reliefweb.int/files/resources/73756.pdf>

⁵⁹ ГБХЗХГ-тай хийсэн ярилцлагаас

⁶⁰ ХЭҮК.2021.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл. Улаанбаатар

төрөлжүүлэн бүртгэх болсноор хохирогч хүүхдийн мэдээлэл нэгтгэгдэн, түүнд тохирсон тусламж үйлчилгээг авах боломжтой болсон байна.

102. Хүүхэд хамгааллын тогтолцоог бүхэлд нь хамарсан Хүүхэд хамгааллын мэдээллийн удирдлагын нэгдсэн систем өнөөг хүртэл байхгүй хэвээр байна. Мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв байдлаар солилцох тогтолцоо байхгүйгээс хүүхэд хамгааллын мэдээллийг тогтмол цуглуулж, дүн шинжилгээ хийж чадахгүй байна. Тиймээс хүүхэд хамгааллын үйлчилгээ болон бодлого төлөвлөлтөд ашигладаггүй байна. Судалгааны явцад хүүхэд хамгааллын кэйс менежмент, НЦҮТ, ТХБ-аар үйлчилүүлсэн хүүхдийн талаар мэдээлэл цуглуулахад ХНХЯ, ХЗДХЯ, ГБХЗХГ, аймаг болон дүүрэг дэх ГБХЗХХ-ээс авсан мэдээллүүд нь хоорондоо зөрүүтэй байна.

Хүүхэд бүр регистрийн дугаартай, түүгээр нь боловсрол, эрүүл мэнд, хамгааллын үйлчилгээг харах боломжгүй учир орон нутгийн түвшинд мэдээлэл тулдаггүй, холбогддоггүй. Тиймээс бүх салбар тус тусдаа явдаг. Гэтэл хүүхэд хамгааллын тогтолцоо чинь датанаасаа эхлэх ёстой. Хүүхдийн мөнгөөр дамжуулан эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ заавал сургах, хөгжүүлэх шаардлага тавьж болно шүү дээ

Ганцаарчилсан ярилцлагаас

103. ХНХЯ-аас хүүхэд хамгааллын үйлчилгээ хүлээн авагчдын мэдээллийн тогтолцооны и-тусламж системийг (www.etuslamj.mn) нэвтрүүлж байгаа нь сайшаалтай байна. Гэхдээ тус мэдээллийн системийг хүүхэд хамгааллын бүх түвшний үйлчилгээ үзүүлэгч бүрт нээлттэй байлгах, бусад салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцох байдлаар ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, бүртгэлтэй мэдээлэлд дүн шинжилгээ хийн үйлчилгээний чанар хүртээмж, эрх зүйн орчинг сайжруулахад ашиглах нэн шаардлагатай байна.

104. **Хүүхдийн эрхийн улсын байцаагч:** нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн дагуу хүүхдийн эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах үүрэгтэй.⁶¹ Өнөөгийн байдлаар зохих шалгуур, болзол хангасан 70 шахам ажилтан Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрхээ авч, уг албан тушаалыг хашиж байна. Гэвч аймаг, дүүргийн ГБХЗХБ-ын хүүхэд хамгааллын мэргэжилтэн хүүхдийн эрхийн улсын байцаагчийн үүргийг давхар хариуцан ажиллаж байгаа нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх боломжгүй болгож байгаа бөгөөд ажлын ачааллаас болж хүүхдийн эрхийн зөрчлийн дагуу тухайн газар оронд хүрч ажиллаж чадахгүй байна. Мөн хүүхдийн эрхийн улсын байцаагч нь Зөрчлийн хуулийн дагуу торгохоос өөр эрх мэдэлгүй тул Зөрчлийн хуулиар заагдаагүй хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд ажиллах боломж хомс байна. Хүүхдүүдийн зүгээс багшийн ёс зүй, харилцааны талаар гомдол их ирдэг бөгөөд энэ асуудлаар Хүүхдийн эрхийн улсын байцаагч ажиллахад багшид шууд арга хэмжээ авч ажиллаж чаддаггүй байна.

105. Иймд Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөрчил шалгах үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх, хүүхдийн эрхийн яаралтай асуудлаар кейст дараалалгүй шуурхай ажиллах нөхцөлийг хуулиар хангах мөн үйлчилгээ үзүүлэгч төрийн байгууллагын хамааралгүй, бие даасан байдлаар хяналт, шалгалт хийх эрхтэйгээр ажиллуулах; нийгмийн ажил, мэргэжлийн, багадаа 15 жил ажилласан туршлагатай хүнийг ажиллуулах мөн лиценз олгох; үйлчилгээний чанар, хүртээмжийг хангах үүднээс 10,000 хүүхэд тутамд нэг хүүхдийн эрхийн улсын байцаагч ажиллуулж тухайн орон нутгийн сургууль, цэцэрлэг,

⁶¹ Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20.3-р заалт

эмнэлэг, цагдаа, хувийн хэвшлийн байгууллагуудтай хүүхдийн асуудлаар хамтарч ажиллах боломжийг бүрдүүлэх; хүүхдийн эрхийн улсын байцаагчийг ТЗ-6-аар цалинжуулж тогтвортой байдлыг хангах шаардлагатай байна.

106. **Хамтарсан баг:** Анх 2007 онд Нийслэлийн Засаг даргын 144 тоот захирамжаар хороодод бий болж улмаар 2010 оноос орон нутагт ажиллах болсон. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар “гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Хамтарсан баг” хэмээн хохирогч, түүний гэр бүлийн гишүүдэд энэ хуульд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг хэлдэг болсон байна. Хамтарсан багийг байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавихыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, чиглэл өгөх үүргийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлүүд, харин тус багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллуулах үүргийг сум, хорооны Засаг дарга нар тус тус хүлээдэг.

107. Хамтарсан багийн гишүүд болох Засаг дарга, хорооны нийгмийн ажилтан, эмч, цагдаа, сургуулийн нийгмийн ажилтан тус бүр өөрийн мэргэжлийн байгууллагад харьяалагддаг бөгөөд гишүүдийн ажил үүргийн хуваарьт тус багт ажиллах талаар заалт байдаггүй, Хамтарсан багт ажилласны төлөө цалин урамшуулал авдаггүй, үйл ажиллагааны зардалгүй нь нэг талаас үүрэг, хариуцлага тооцох боломжгүй болгож байна. Мөн хүүхэд хамгааллын асуудал хариуцсан байгууллагад харьяалагддаггүй байна. Түүнчлэн, хороо, багийн Засаг дарга нар УИХ сонгуулийн дараа байнга солигддог бөгөөд шинэ Засаг дарга өөрийн багаа бүрдүүлнэ хэмээн хороо, багийн ажилтнуудыг тэр дундаа нийгмийн ажилтныг байнга сольдог байна. Иймээс Хамтарсан багийн үйл ажиллагаа тогтвортой, сайн явагдах эсэх нь шинээр томилогдсон засаг даргын хандлагаас бүрэн хамаардаг байна. Судалгаанд оролцсон аймгуудын хувьд аймагт Хамтарсан багт зориулж бага хэмжээний төсөв ирснийг бүх Хамтарсан багтаа хувааж өгөхөд хэцүү учир аймгийн хэмжээнд Хамтарсан багуудын дунд уралдаан зарлан, түрүүлсэн багт нь шагнал болгон өгөхөөр төлөвлөсөн гэдгийг хуваалцсан юм.

108. Хамтарсан багийн ажлыг сайжруулахын тулд нөхцөл байдлын үнэлгээг хорооны Хамтарсан баг, нийгмийн ажилтан гүйцэтгэн дүүрэгт хэлтэс нь хянан, дүгнэлтийг баталгаажуулан дүүргийн Засаг дарга захирамж гаргадаг байх; Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журмыг өөрчлөх, Хүүхдийн хувийн хэргийн маягтыг товч болгох, бусад зүйлтэй холбоотой кейст хөтлөх маягтыг зөвхөн хүчирхийллийн асуудлаар зориулсан тул бусад унаач зэрэг олон төрлийн кейст тохирохоор өөрчлөх; кэйс менежментийн онлайн системийг нэвтрүүлэх зэрэг олон өөрчлөлтийг хийх шаардлагатай байна.

109. Цаашлаад Хамтарсан баг нь анхан шатны нэгжид ажилладаг тул ачаалал их байна. Жишээ нь: Улаанбаатар хотын бүх хороодод нийгмийн эмзэг давхаргын үйлчилгээ, судалгаа, цэрэг татлага зэрэг захиргааны олон ажил нийгмийн ажилтан хариуцахаар болдог. Суманд кэйс гарахад эхэндээ ганц нэг хуралдахаар гишүүд нь бүрдэхгүй, эмч нь дуудлагад, Засаг дарга нь хадлан, зуд гээд хөдөө явдаг. Судалгааны явцад Хамтарсан багийг хүүхдүүд, эцэг эх, асран хамгаалагчид төдийлөн мэдэхгүй байсан бөгөөд Хамтарсан багийн гишүүдийн хувьд орон нутгийн иргэд Хамтарсан багийн үйл ажиллагааг сайн мэддэг хэмээн хуваалцсан юм. Нийслэлийн хороо, аймгийн төвийн Хамтарсан багуудын хариуцах хүн ам, өрхийн тоо, ажлын ачаалал их байдаг. Сумын Хамтарсан багийн хувьд бүх иргэдээ таньж мэдэх учир нууц хадгалах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд шаардлага тавьж ажиллахад хүндрэлтэй байдаг байна.

Манайх суманд байдаг нөхөртөө зодуулаад цагдаа дуудахад цагдаа нөхөр рүү залгаад эхнэр чинь ингээд байна үнэн юм уу гэж асууна. Сум даяар нэгнийгээ таньдаг болохоор тэр. Би зодуулахаас айж хамгаалалт хайж байхад илүү айдас хүчирхийлэлд ордог. Сумынхан надад туслахгүйг ойлгоод хүүхдүүдтэйгээ замын машинд сууж, аймагт хамгаалах байранд очсон.

Бүлгийн ярилцлагаас

110. 2021 онд Нийслэлийн ГБХХГ-аас зохион байгуулсан судалгаагаар нийслэлийн Хамтарсан багийн гишүүдийн 61 хувь нь 1-2 жил, 39 хувь 3-7 жил ажиллаж байна. Хамтарсан багууд дуудлага мэдээллээ ХТУ-108, хэсгийн ахлагч болон иргэдээс, цагдаагийн 102 утаснаас хүлээн авдаг. Багийн гишүүдийн тэн хагаст нь үндсэн ажил үүргийн хэт ачааллаас болж кейс үйлчилгээнд ажиллахад бэрхшээлтэй тулгардаг байна. Хамтарсан багууд үйл ажиллагааны тайланг холбогдох газарт хүргүүлж хэвшээгүйгээс ХЗДХЯ, ХНХЯ, ГБХЗХГ, ГБХЗХХ-ийн хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой тоо баримт зөрүүтэй байна. Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих зардлыг улсын болон орон нутгийн төсөвт суулгадаггүй, үүнд хуулиар үүрэг хүлээсэн хорооны Засаг дарга нарын 50 хувь нь холбогдох эрх бүхий байгууллагад хохирогчид үйлчилгээ үзүүлэх зардлыг төсөвт суулгах талаар өргөн мэдүүлж үзээгүй, нийгмийн ажилтны 33 хувь нь хувиасаа үйлчилгээний зардлыг гаргадаг гэдгээ нотолж болно.

111. Дээрхээс дүгнэн үзвэл Хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийн хуваарь тус багт ажиллах талаар заагаагүй, гишүүд байнга солигддогтой холбоотойгоор чадавх сул, цалин, урамшуулал олгодоггүй, үйл ажиллагааны санхүүжилт байхгүй зэрэг олон асуудалтай тулгарч байгаа нь тогтвортойгоор үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад хүндрэл бэрхшээлтэй байна.

112. **Асрамж, халамжийн үйлчилгээ.** Нийгмийн халамжийн хуулийн дагуу төрөлжсөн асрамжийн газарт Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүнд нөхцөлд байгаа, эсхүл байнгын асрамжид байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхэд, улсын зардлаар төрөлжсөн асрамжийн газар асрамжлан өсгөхийг эцэг, эх нь зөвшөөрсөн дөрөв хүртэлх насны гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг хамруулна. Энэ үйлчилгээг ГБХЗХГ-аас хариуцан гэрээт байгууллагуудаар дамжуулан үзүүлдэг. 2019 оны байдлаар улсын хэмжээнд хүүхдийн халамж, асрамжийн 21 байгууллагын 31 төв байнгын үйл ажиллагаа явуулж 1,057 (бүтэн өнчин 506, хагас өнчин 239, гэр бүлтэй 294) хүүхдэд үйлчилж байна.⁶² Халамж, асрамжийн төвүүдийн хоёр нь улсын төсвөөс санхүүжиж, бусад нь гаднын байгууллага, хувь хүн, аж ахуйн нэгжийн хандив санхүүжилтээр ажилладаг байна.

113. Аймаг, нийслэлийн Засгийн даргын захирамжийг үндэслэж 2-18 насны хүүхдийг байнгын асрах үйлчилгээнд хамруулах зорилгоор ГБХЗХГ харьяа Өнөр бүл төв (цэцэрлэгийн хамт) нь нийт 103 ажилтантайгаар 40 гаруй жил үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага юм. 2019 оны байдлаар бүтэн өнчин, эцэг, эх нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, хөдөлмөрийн чадвараа 70 хувиас дээш алдсан, хориход ял эдэлдэг, хүчирхийллийн харилцаатай, донтох хамааралтай зэрэг эрсдэлд нөхцөлд амьдардаг 188 хүүхэд энэ төвд харьяалагдаж байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн 20 хувь орчим хувь байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна. Тус төвд амьдарч байгаа хүүхдүүдэд тулгардаг бэрхшээлийн хувьд бие даах чадвар сул, сургуулийн орчинд

⁶² ГБХЗХГ.2020. Монголын хүүхдийн байдал: 2019 оны статистикийн эмхтгэл. Улаанбаатар

“асрамжийн хүүхэд” гэж гадуурхагддаг, мөн 18 нас хүрээд харьяа орон нутгийн Засаг дарга руу шилжихэд амьдралын баталгаа бүрхэг хэвээр байсаар байна.

114. Асрамж халамжийн төвөөс 18 нас хүрээд гарч байгаа хүүхдүүдийг харьяа аймаг, дүүргийн Засаг даргад нь захирамжаар шилжүүлдэг боловч Засаг дарга нарын зүгээс хүүхдийг хүлээн авч үргэлжлүүлэн сурч боловсрох, амьдрах орчин нөхцөлөөр хангаж, үнэлгээ хийн ажиллах явдал дутмаг хэвээр байна. Тиймээс засаг даргын ажил үүргийн хуваарьт мөн засаг даргын ахлан ажилладаг Хүүхдийн зөвлөлд асрамж, халамжийн төвөөс гарч байгаа хүүхдийг анхаарч ажиллах талаар үүрэг оруулж, хэрэгжилтийг тухайн үүрэг хүлээгчдийн жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээнд оруулах шаардлагатай байна.

115. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор төв нь 2014 онд байгуулагдсан юм. Энэхүү төвийн үйл ажиллагаа нь нийслэлийн хүүхдийн асрамж халамжийн төвүүдэд амьдарч байгаад 16 нас хүрсэн, асран хамгаалагчгүй, гэр оронгүй, мэргэжилгүй, төрөөс зайлшгүй анхаарал шаардлагатай 16-20 насны залуучуудыг байнга болон түр хугацаагаар байрлуулан мэргэжлийн сургалтад хамруулж, чадамжийн гэрчилгээ олгож хөдөлмөрт зуучлан амьдралд бэлтгэх зорилготой төв юм. Тус төвийн 18-21 настай залуусыг хүлээж авах байранд одоогоор 40 гаруй залуучууд амьдарч байна.

116. ЭМЯ-ны харьяа Хүүхдийн төв сувилал нь 1967 оноос хойш амьдрал хүнд эхчүүдэд туслах, бүтэн өнчин хүүхдийг асрах, эмчилгээ сувилгаа хийх зорилгоор анх ажиллаж ихэр хүүхдүүд болон бага жинтэй буюу дутуу төрсөн нярайг асарч, сувилсаар үйл ажиллагаагаа явуулсаар байна. Энэхүү сувилалд сүүлийн жилүүдэд эцэг, эхдээ хаягдсан хүүхэд цөөрсөн боловч гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эцэг, эх нь сэтгэцийн хувьд өөрчлөлттэй, архинд донтсон, санхүүгийн чадамжгүй мөн ял эдэлж байгаа иргэдийн хүүхдүүд ирж байна. Тус сувилал хүүхдүүдээ 3 нас хүрэхээр нь “Өнөр бүл” төвд шилжүүлж байснаа сүүлийн 5 жил нэг ч хүүхдийг шилжүүлээгүй байна.

117. 2000 оны үетэй харьцуулахад сүүлийн жилүүдэд тус сувилалд жилдээ ирж байгаа бүтэн өнчин хүүхдийн тоо 4-5 байна. Баянгол дүүргийн Засаг даргатай хамтран эхлээд хүүхэд үрчилж авах хүсэлтэй Монгол айлд санал болгоод, дараа нь гадаад хүмүүст ханддаг байна. Гэвч нийгмийн дунд эрүүл хүүхэд үрчлэх сонирхолтой байдаг бөгөөд асаргаа шаардах, эрүүл мэндийн асуудалтай хүүхдийг гадаад иргэд үрчлэх нь бий. Гадаад руу өргүүлсэн хүүхдийг нас биед хүрээд иргэншлээ сонгох хүртэл нь жилд нэг удаа бүх мэдээллийг нь авч хяналтын протоколыг хөтөлдөг байна.

118. Кристина Нобелийн Хүүхдийн Сангийн харьяа “Нархан” гэр хотхон халамж, асрамжийн төв нь 24 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж, таваас дээш насны хагас, бүтэн өнчин, хараа хяналтгүй, эрсдэлд нөхцөлд амьдардаг хүүхдэд үйлчилдэг юм. Холбооны Бүгд Найрамдах Герман улсад төвтэй “Альфа Коммунитиз” ТББ-ын “Найдвар” салбар нь амьжиргааны түвшин доогуур өрхийн сургуулиас завсардсан, эцэг эхийн халамжаас гадуур хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг. Харин Донбоско төв нь хагас бүтэн өнчин, нэн ядуу өрхийн хүүхдүүд, сургууль завсардсан, хамгаалал шаардлагатай 7-18 насны зөвхөн эрэгтэй хүүхдийг төвдөө авч, асрамж халамжийн үйлчилгээ үзүүлдэг юм.

Хүүхэд асрамжийн газрыг улс дэмжээд 2 хүүхдийн дунд 1 хүн ажиллаад өртөг өндөртэй үйлчилгээ. Гэр бүлд түшиглэсэн үйлчилгээг хөгжүүлэхгүй, тэрэнд анхаарал бага тавьж байгаа.

Ганцаарчилсан ярилцлагаас

119. Харьцуулсан судалгаагаар асрамжийн төвийн хүүхдийн өөртөө итгэх итгэл, өөрийгөө хүлээн зөвшөөрөх, өөрийн үнэлгээ нь үе тэнгийнхнийгээ үнэлэх үнэлгээнээс доогуур байгаа нь өөрийн зан чанар онцлогтойгоо зөрчилддөг, бусдаас дутуу гэсэн мэдрэмжтэй болохыг харуулсан бөгөөд бусадтай ярилцах талаар төдийлөн анхаардаггүй, бусдын өмнөөс санаа тавьдаггүй өөрийгөө зөвөөр илэрхийлэх чадвар сул, асуудлыг шийдвэрлэх чадвар бага байна.⁶³

120. Тиймээс цаашид хүүхдийг үрчлүүлэхдээ гэр бүлд түшиглэсэн үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай бөгөөд ингэхдээ хүүхэд үрчилж авч байгаа гэр бүлээ судлах; тогтмол сурган бэлтгэх; хүүхэд, үрчилж авч буй гэр бүлийн хэрэгцээг тодорхойлон, нарийн судалсны үндсэнд тохирох гэр бүлд нь өргүүлж, байнгын хяналт тавьж ажиллах нь зүйтэй. ХЭК-ийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн Газрын 5 дугаар тайланд ХЭХ-оос асралт гэр бүл, үрчлэлт зэрэг гэр бүлд суурилсан хувилбарт үйлчилгээг орон нутагт нь түшиглэн үзүүлэх; хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих зарчим, хэрэгцээнд суурилан хүүхдийг хувилбарт үйлчилгээнд хамруулах шаардлагатай эсэхийг тогтооход чиглэсэн шалгуур үзүүлэлт, хамгааллын арга хэрэгслээр хангахад анхаарахыг зөвлөсөн байна.

121. **Түр хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээ.** 2020 оны байдлаар улсын хэмжээнд 17 НЦҮТ, 20 ТХБ байгаагийн 8 нь цагдаагийн байгууллагын дэргэд, 3 нь эрүүл мэндийн байгууллагын, 1 нь шүүх шинжилгээний байгууллагын, 2 нь ТББ-ын, 23 нь ГБХЗХГ, хэлтсийн дэргэд тус тус ажиллаж байна.⁶⁴ 2020 оны байдлаар ТХБ, НЦҮТ-өөр нийт 4,659 хүн үйлчлүүлсний 45.6 хувь (2,118) нь хүүхэд байна. ТХБ-аар үйлчлүүлсэн хүүхдүүдийг хүүхдийн эрхийн зөрчлөөр авч үзэхэд үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхэд 44 хувь; биемахбодийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд 21 хувь; сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхэд 17 хувь; хараа хяналтгүй хүүхэд 12 хувь; бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд 7 хувь; гуйлга гуйсан болон төөрсөн хүүхэд тус бүр 1 хувь, амиа хорлох гэж оролдсон хүүхэд 0.5 хувиаг тус тус эзэлж байна.

122. Судалгаанд оролцогч олон талуудын зүгээс ТХБ-ны үйлчилгээнд стандарт байхгүйгээс үзүүлж байгаа үйлчилгээний төрөл, чанар харилцан адилгүй байгаад шүүмжлэлтэй хандаж байлаа. Хохирогч хүүхдүүдэд нөхөн сэргээх үйлчилгээ, сэтгэл зүй, эрүүл мэндийн, боловсролын гээд олон үйлчилгээг чанартай, онцлогт тохируулан хохирогч төвтэйгээр хүргэх шаардлагатай. Гэвч өнөөдрийн байдлаар ТХБ-нд байгаа хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг үзүүлж чадахгүй байна. Мөн бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд ТХБ-д байх хугацаанд сэтгэл заслын үйлчилгээ авч байгаа ч урт хугацаанд нөхөн сэргээх үйлчилгээ авах шаардлагатай хүүхдийг ТХБ-аас гарсны дараа үргэлжлүүлээд нөхөн сэргээх үйлчилгээ хэн үзүүлэх нь тодорхойгүй байна. ТХБ, НЦҮТ, ГБХЗХБ, Хамтарсан багуудад дунд мэдээлэл солилцох боломж байдаггүйгээс нэг хүүхэд хэдэн ТХБ, Хамтарсан баг дамжин явсныг мэдэх аргагүй учир хариу үйлчилгээний үр дүн, оновчтой байдлыг тодорхойлж чадахгүй байна

123. Ярилцлагад оролцогчдоос ХТУ-108 харьяа ТХБ-д хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогч хүүхэд, хараа хяналтгүй хүүхдийг хамт байлгаж байгаад шүүмжлэлтэй хандаж байсан бөгөөд хохирогч хүүхэдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр энэ асуудал мөн л хөндөгдсөн юм. Төрийн болон ТББ-ын ажиллуулж байгаа ТХБ-р үйлчлүүлэгчийн тоо,

⁶³ Г.Ойнбаяр.2019. Зан Үйлийг Өөрчлөх Арга Зүйгээр Асрамжийн Төвийн Хүүхдийн Нийгмийн Харилцааны Чадварыг Сайжруулах нь.Хүний эрх онол, арга зүйн сэтгүүл 2019/02 43-53 тал

⁶⁴ ХЭҮК.2021.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл. Улаанбаатар

ажилтнуудын тоо, зарцуулж байгаа хөрөнгөнд зөрүүтэй зүйл их байгаа нь тэдгээр байгууллагуудын үйлчилгээний чанар, үр дүн, бүтээмжийг судлан цаашид оновчтой болгох хэрэгцээ, шаардлага байгааг илтгэж байна.

ХТУ 108-аас манай түр хамгаалах байранд ах дүү хоёрыг авчирч өгсөн бөгөөд бид хүлээлцэх акт үйлдэн хүүхдүүдийн мэдээллийг авахад ХТУ 108-д давтан дуудлагаар ирсэн хүүхдүүд байсан. Ах нь манай дүү халуурахаараа татдаг гэж эмчийн үзлэгээр хэлсэн. Гэтэл шөнө дүү нь таталт өгч, бид сандран түргэн тусламж дуудан, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд очсон. Гэтэл хүлээн авахын үүдээр ороход тэр хүүг эмч, сувилагчгүй бүгд танин хүүг эпилепси буюу унаж татах өвчтэй байнгын эм уудаг, энэ жил тус төвд дөрөв дэх удаагаа ирж байгаа, аав ээж нь архины хамааралтай учир ахтай нь хамт гэрт үлдээгээд хэд хоногоор орхиод явдаг мөн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нэг цэгийн үйлчилгээний төвд мөн л олон удаа ирж байсан гэдгийг хэлж байсан. Хэрэв хүүхдийн амь нас хохирсон бол бидний буруу болох байсан уу эсвэл хүүхдийн мэдээллийг дутуу бүртгэж шилжүүлсэн ХТУ 108-ийн буруу болох уу?

Ганцаарчилсан ярилцлагаас

Гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар туслалцаа үзүүлэх 107 дугаарын утасны хамгаалах байр 30 хүний багтаамжтай 38 ажилтантай. Гэтэл ТББ руу очихоор 10 хүрэхгүй ажилтантайгаар бүх үйл ажиллагааг явуулж болоод байдаг. Төрийн байгууллага бүхнийг өөрөө хийнэ гээд улам л данхайгаад байдаг.

Ганцаарчилсан ярилцлагаас

124. Энэ бүгдээс дүгнэхэд ТХБ-ны үйл ажиллагааг нарийвчлан журамлах, ажилтнуудыг сургах, хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн санг бий болгон хариу үйлчилгээ үзүүлэгч талуудад хүүхдийн талаар үнэн, бодит мэдээллийг өгөх, хохирогч төвтэй үйлчилгээг бий болгох нэн шаардлагатайгаас гадна олон улсын сайн туршлагыг судлан ТХБ-ны үйлчилгээг мэргэжлийн төрийн бус байгууллагуудад гэрээлэн өгөх нь оновчтой юм. Төр өөрөө хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний бодлого боловсруулагч, санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч, хяналт тавигч байх нь өөрийн сул талыг харж, сайжруулах, чанарыг хянах боломжгүй болгож байна.

125. **Хүүхдийн элч** нь хүүхдийн эрх, хамгааллын асуудлаарх санал хүсэлт, өргөдөл гомдлыг эрх бүхий албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх үүрэг хүлээдэг.⁶⁵ ГБХЗХГ-ын мэдээлснээр Монгол Улсад 400 орчим хүүхдийн элч ажиллаж байгаа бөгөөд сонгогдсон эдгээр элчийг ГБХЗХГ-ын дарга батламжилдаг. Хүүхдийн элчүүдээс тухайн орон нутгийн Хүүхдийн төлөө зөвлөл, ХЭХЗХ, Хамтарсан багийн гишүүнээр сонгогдсон цөөн хэдэн тохиолдол байна. Өнөөгийн байдлаар хүүхдийн элч нь төрөөс ямар нэгэн урамшуулалгүй; өөрсдийн дотоод нөөцөд тулгуурлан ажилладаг төдийгүй үйл ажиллагаа явуулах удирдамж, чиглэл, сургалт хангалтгүй; элчийн ажлыг олон нийтэд сурталчилж, мэдээлдэггүйгээс олон нийт төдийлөн мэддэггүй; талуудтай хамтын ажиллагаа хангалтгүй байна. Цаашид нийгэм, олон нийтийн хариуцлагатай оролцоо, түншлэлийг дэмжих, үр дүнтэй, зардал багатай байдлаар хүүхэд хамгааллын ажлыг өрнүүлэх шинэлэг нэг аргачлал нь хүүхдийн элч тул хүүхдийн элчийн ажлыг үр дүнтэй болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх, эрх мэдэл, хамтын ажиллагаа нэмэгдүүлэх, урамшууллын хөшүүрэг⁶⁶ бий болгоход анхаарах шаардлагатай. Мөн түүнчлэн, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс хүүхдийн элчийг хүүхдийн тоонд харьцуулан сонгох, квотын зарчмаар ажиллуулах нь зүйтэй.

⁶⁵ Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20.6 зүйл

⁶⁶ Хүн амын албан татвараас чөлөөлөх; эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах гэх мэт

126. **Хүүхэд хамгааллын албан бус оролцогчид.** Хүүхэд хамгаалалд олон нийт, иргэдийн оролцоог дэмжихдээ бүх хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийг Хүүхэд хамгааллын бодлоготой ажиллахыг ХТҮЗ-өөс уриалж 2018 онд байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг болон байгууллагын эцэг эхийн зөвлөлийн зөвлөмжийг баталсан байна. ХТҮЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэхээр 2018 оноос хойш ХНХЯ, ГБХЗХГ хамтран төрийн захиргааны байгууллагуудад сургалт, сурталчилгаа өрнүүлж түүгээр дамжуулан бусад байгууллагад түгээж байна. Тухайлбал Хэнтий аймагт 58 байгууллага эцэг эхийн зөвлөл байгуулж, Хүүхэд хамгааллын бодлогоо хэрэгжүүлдэг болжээ.

127. “Хүүхэд хамгаалагч” төслийг Цагдаагийн байгууллагаас ХНХЯ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран 2019 онд зарим орон нутагт туршин 2020 оноос 21 аймгийн төв, нийслэлийн 9 дүүргийн 172 хороонд хэрэгжүүлж эхэлсэн. Зорилго нь хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, гудамж талбай, олон нийтийн газарт аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж аливаа эрсдэлээс хамгаалахад чиглэнэ. Төслийг цагдаа, төрийн байгууллагаас тэтгэвэрт гарсан 65 хүртэлх насны ахмадыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж “Хүүхэд хамгаалагч” эргүүлд гаргадаг. Хуваарьт газраар эргүүлийн үүрэг гүйцэтгэхдээ тэд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил болон гэр бүлийн хүчирхийлэл, ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр хүүхэд, иргэдэд зөвлөгөө өгч, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага мэдээллийг цагдаагийн байгууллагад мэдээлэх үүрэг хэрэгжүүлдэг.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ТАЛУУДЫН ЧАДАВХ, НӨӨЦИЙН ХУВААРИЛАЛТ

128. **Үндэсний түвшний хүүхэд хамгааллын төсөв:** ГБХЗХГ нь хүүхэд хамгааллын үндэсний хэмжээний төсвийн бодлого, санхүүжилт, зарцуулалтыг хариуцдаг байна. Судалгааны явцад улсын хэмжээнд хүүхэд хамгааллын төсөв, санхүүжилтийн зардлын нарийвчилсан дүн, мэдээллийн олдоц, ил тод байдал хангалтгүй байв. ГБХЗХГ нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж шилэн дансанд төсвийн зарцуулалтын мэдээллийг тогтмол байршуулдаг хэдий ч хэт ерөнхий, санхүүжилт гаргах тухай тушаалын хавсралтууд дутуу зэргээс хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд зориулж буй төсвийн зарцуулалтыг нарийвчлан тооцох боломжгүй байна.

129. Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн хүүхдийг хүчирхийллийн эсрэг санаачилга, Хүүхэд хамгаалал, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын үр дүнд хүүхдийн хүчирхийллийн эсрэг арга хэмжээний төсвийг эрс нэмэгдүүлж чадсан байна.


Хүснэгт 6: Хүүхэд хамгааллын төсөв (сая төгрөгөөр)

№	Байгууллага	2017	2018	2019	2020
1	Агентлаг	645.8	3,491.1	2,600.0	3,500.0
2	21 аймаг дахь хэлтэс	172.3	1,769.8	1,834.2	2,084.9
3	УБ хотын хэлтэс	82.0	639.1	2,739.1	1,915.1
4	ХНХЯ	-	500.0	500.0	500.0
	Нийт	900.1	6,400.0	7,673.3	8,000.0

130. Тухайлбал, хүүхэд хамгаалалд улсын төсвөөс 2017 онд 900 сая төгрөгийг төлөвлөн зарцуулж байсан бол 2018 онд 6.4 тэрбум төгрөг, 2019 онд 7.6 тэрбум төгрөг, 2020 онд 8 тэрбум төгрөг болж 2017 оны түвшнээс 8 дахин нэмэгдсэн байна. Улсын төсвийн нийт зарцуулалтын дийлэнх буюу 43.8 хувь нь ГБХЗХГ-т, 26.1 хувь нь орон нутагт, 23.9 хувь нь

Нийслэл, 9 дүүрэгт, 6 хувь нь ХНХЯ -нд тус тус харьяалагдаж байна. Хэдийгээр хүүхэд хамгааллын үйлчилгээнд зарцуулах төсвийн хэмжээг 900 сая төгрөгөөс 8 тэрбумд хүргэж нэмэгдүүлж чадсан хэдий боловч НҮБ-ын Хүүхдийн Сангийн тусламжтайгаар хийсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, зардлын шинжилгээ судалгаанд дурдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн хэмжээнд хүрээгүй хэвээр байна.

График 10: Нийт төсөвт эзлэх хувь



131. Тус судалгаанд хүүхэд хамгааллын үйлчилгээнд зарцуулах шаардлагатай төсвийн хэмжээг гурван хувилбараар авч үзсэн байдаг.


- Тэнцвэрт хувилбар буюу хүүхэд хамгааллын үйлчилгээний эрэлт нам дор байж нийт шаардлагатай төсөв 11.4 тэрбум төгрөг байна.
- Өсөн нэмэгдэх зардлын хувилбар буюу хүүхэд хамгааллын үйлчилгээний эрэлт өндөр байж нийт шаардлагатай төсөв 21.1 тэрбум төгрөг байна.
- Зардал хэмнэх буюу хүүхэд хамгааллын үйлчилгээний эрэлт тухайн үеийн хамгийн бага түвшинд байж нийт шаардлагатай төсөв 4.3 тэрбум төгрөг байна.⁶⁷

132. Хүүхэд хамгааллын үйлчилгээний эрэлт хэрэгцээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд одоогийн улсын төсвөөс хуваарилж байгаа санхүүжилтийг 13 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 21 тэрбум төгрөгт хүргэх шаардлагатай юм. Учир нь 2015 оноос хойш хүүхэд хамгааллын үйлчилгээний эрэлт нэмэгдэж байгаагаас гадна бүтээгдэхүүн, үйлчилгээ, сургалт, сурталчилгаа, байрны урсгал зардал, цалингийн зардал гэх мэт зардлуудын үнэ өртөг жилээс жилд өсөн нэмэгдэж байгаатай уялдан авч үзэх хэрэгтэй. ГБХЗХГ нь төсвийн орлогоос гадна төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс хандив, тусламжийг авдаг бөгөөд хандивын хэмжээ 2017 онтой харьцуулахад 2020 онд 2 дахин нэмэгдсэн байна. Шилэн дансны мэдээллээр хандив, тусламжийн дийлэнх хэсгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид зарцуулжээ. Хэдийгээр шилэн данс дээр хандив, тусламжийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд зарцуулсан гэсэн мэдээлэлтэй байгаа боловч яг ямар ажил үйлчилгээнд зарцуулсан нь тодорхой бус байна.

График 11: Хандив тусламжийн хэмжээ, сая төгрөг⁶⁸


⁶⁷ UNICEF. 2017. Budget analysis and costing of the child protection services in Mongolia. Ulaanbaatar

⁶⁸ Эх үүсвэр: <https://www.shilendans.gov.mn>



133. Шилэн дансанд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалтыг сар бүрээр байршуулж байгаа боловч хагас болон бүтэн жилээр байршуулдаггүй байна. Худалдан авалтын санхүүжилтийг авч үзэхэд 2019 онд нийт 4.2 тэрбум төгрөгийн зардал гарсан байна. Харин сар, улирлаар авч үзэхэд 2019 оны эхний улиралд бараг зардал гараагүй буюу ердөө 5.6 сая төгрөгийн зардал гарсан бол 2019 оны дундуур сард дунджаар 400-500 сая төгрөгийн зардал гарсан байна. Харин тус оны сүүлээр зардлын хэмжээ огцом нэмэгдсэн буюу 12 дугаар сард 743 сая төгрөгийн зардал гарчээ. Шилэн данснаас 2019 оны 12 дугаар сарын санхүүжилтийн зарцуулалтыг нарийвчлан авч үзэхэд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй нийт 743 сая төгрөгийн худалдан авалтын зардлын 36 хувь буюу 266.3 сая төгрөгийг Хүүхэд, гэр бүл хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд зориулсан кино хийхэд зарцуулсан байна. Бусад зардлыг графикт эзлэх хувиар үзүүлэв.


График 12: ГБХЗХГ-ын 2019 оны 12 дугаар сарын санхүүжилтийн зарцуулалтын шилэн дансны мэдээлэл



134. Харин 2020 оны 12 дугаар сарын санхүүжилтийн зарцуулалтыг авч үзэхэд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй нийт 244.7 сая төгрөгийн худалдан авалт, санхүүжилтийн зардлыг гаргаж, 234.3 сая төгрөгийн үлдэгдэл төвлөрүүлжээ. Энэхүү зардлаас Ковид-19 цар тахлын үед хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах хариу арга хэмжээний үйл ажиллагаанд 48.6 сая төгрөгийг зарцуулжээ. Тус арга хэмжээг тухайн агентлагийн батлагдсан төсөв болон НҮБ-ын Хүүхдийн Сангаас санхүүжүүлсэн байна. Мөн хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээнд 48.4 сая төгрөг; хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний зардалд 27.6 сая төгрөг; тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмж

17 сая төгрөг тус тус зарцуулжээ. Улсын хэмжээнд 2017 оноос өмнө хүүхэд хамгааллын чиглэлд жил бүр дунджаар нэг тэрбум төгрөгийг төсөвлөдөг байсан бол 2018 оноос хойш эрс нэмэгдүүлж жилд 8 тэрбум төгрөгийг гэр бүл, залуучууд, хүүхэд хамгааллын зардалд төсөвлөдөг болсон.

График 13: ГБХЗХГ-ын 2020 оны 12 дугаар сарын санхүүжилтийн зарцуулалтын шилэн дансны мэдээлэл



135. Нөөцийн хуваарилалт орон нутгийн түвшинд: Хүүхэд хамгааллын чиглэлээр жил бүр 8 тэрбум төгрөгийг улсын төсөвт суулгадгаас 9 дүүрэг, 21 аймагт хуваарилагдан зарцуулагдаж байна. Нийслэлийн Засаг даргын захирамжаар НГБХЗХГ-т нийслэлийн төсвөөс санхүүжилт олгодог бөгөөд тус төсвийг Хүүхдэд ээлтэй Улаанбаатар дэд хөтөлбөр болон хүүхэдтэй холбоотой бусад хөтөлбөрүүдэд зориулж зарцуулдаг байна. НГБХЗХГ нь улсын төсвөөс сүүлийн 3 жилд тогтмол жил бүр нэг орчим тэрбум төгрөгийг гэр бүл, хүүхэд хамгаалалд зориулж авч байсан байна. Харин Нийслэлийн төсвөөс 2018 онд 220 сая төгрөгийг авч байсан бол тус хэмжээ жил бүр нэмэгдсээр 2020 онд 528 сая төгрөгт хүрчээ. Улсын болон Нийслэлийн төсвөөс гадна НҮБ-ын Хүүхдийн Сангаас жил бүр 100 орчим сая төгрөгийг хүүхэд хамгаалалд зарцуулж байна.

Хүснэгт 7: Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсөв (сая төгрөгөөр)

Он	Эх үүсвэр	хэмжээ сая₮
2018 онд	- Нийслэлээс /дэд хөтөлбөрүүдэд зориулж, хүүхдийн зусланд зориулж/;	219.3
	- НҮБ-ын Хүүхдийн Сангаас /Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, хариу үйлчилгээ/	71.3
	- Улсын төсвөөс	935.0
	Нийт	1,225.6
2019 онд	- Нийслэлээс	416.6
	● НҮБ-ын Хүүхдийн Сангаас/Зорилтод бүлэгт сургалт/	33.0
	● НҮБ-ын Хүүхдийн Сангаас /Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ/	76.0
	● Улсын төсвөөс	988.1

		Нийт	1,513.7
2020 онд	● Нийслэлээс		527.9
	● НҮБ-ын Хүүхдийн Сангаас /эрсдлийг бууруулахад/		59.7
	● НҮБ-ын Хүүхдийн Сангаас хамгааллын хариу үйлчилгээ/	/Хүүхэд	54.3
	● Улсын төсвөөс		1.0 тэр бум
		Нийт	1,642.3

136. Нийслэлийн хэмжээнд гэр бүл, хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлд 2020 онд нийт 988.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж байсан байна. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсанаар

- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхэд ТББ-уудтай хамтран ажиллахад 295 сая төгрөг;
- Зорилтод бүлгийн хүүхдийн хөгжлийг дэмжихэд 130 сая төгрөг;
- Холбогдох мэргэжилтэн, хүний нөөцийг чадавхжуулахад 151 сая төгрөг;
- Хууль тогтоомжийн хэрэгжилт, стандартад хяналт тавих, тайлагнахад 175 сая төгрөг;
- Сурталчилгааны ажлыг зохион байгуулахад 72 сая төгрөг;
- Тэмдэглэлт өдрүүдийн үйл ажиллагааг зохион байгуулахад 55 сая төгрөг;
- Бусад 110.2 сая төгрөг.

137. **Аймгийн хэмжээний төсвийн хуваарилалт:** Судалгааны явцад 21 аймгийн төлөөлөл болгон нэг аймгийн төсөвт шинжилгээ хийсэн бөгөөд шинжилгээний үр дүнг судалгааны ёс зүйн дагуу нэрийг нууцлан хүргэж байна. Тус аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын зардалд улсын төсвөөс 2019 онд 68 сая, 2020 онд 78 сая, 2021 онд 121.3 сая төгрөг батлагдсан байна. Эдгээр зардлыг задалж харвал:

- Залуучуудын хөгжлийн төвийн цалингийн зардал;
- Хүүхэд хамгаалах түр байрны урсгал зардал;
- Хүүхэд хамгаалал, хүүхдийн хөгжил зэрэгт тус тус зарцуулдаг байна.

138. Тухайлбал, Залуучуудын хөгжлийн төвийн цалинд 2021 онд 25 сая төгрөгийг зарцуулсан бол бусад зардлыг хүүхэд хамгаалал буюу өмгөөллийн хөлс, шатахууны зардал, хоол, хүнсний дэмжлэг, шүүх, цагдаагаар явах бичиг хэргийн зардал зэрэг зардлуудад зарцуулсан байна. Хүүхэд түр хамгаалах байр нь 2019 оны 10 сард ашиглалтад орсон бөгөөд улсын төсөв дээр тус байрны урсгал зардал тусгадаггүй тул хүүхэд хамгааллын зардлаас гаргаж байна. Тус аймгийн хэмжээнд 2019 онд хүүхэд хамгаалалд төсөвлөгдсөн нийт зардлын 52.4 хувийг хүүхдийн хөгжилд зарцуулж байсан бол тус хэмжээ 2020 онд 22.6 хувь болж буурсан байна. Харин хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний зардал 2020 онд 16.4 сая төгрөг болж өмнөх оноос 2.7 дахин, хууль сурталчлах арга хэмжээнд 12.5 сая төгрөг буюу өмнөх оноос 2.8 дахин, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах зардал 9.5 сая төгрөг болж өмнөх оноос 6.4 дахин тус тус нэмэгдсэн байна.⁶⁹

Хүснэгт 8: Аймгийн ГБХЗХХ-ийн төсвийн зарцуулалт (төгрөгөөр)

Төсвийн зарцуулалтын ангилал	2018 он	2019 он	2020 он
------------------------------	---------	---------	---------

⁶⁹ Эх үүсвэр: Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ		5,970,000	16,427,500
Хууль сурталчлах	1,444,000	4,429,064	16,429,520
Сургалт	835,000	4,920,000	9,004,600
Хүүхдийн хөгжил	4,294,600	35,700,000	12,791,750
Төрийн бус байгууллага	750,000	1,500,000	21,796,350
Бусад	450,000	15,600,000	1,323,480
НИЙТ	7,773,600	68,119,064	77,773,200

139. Тус аймагт хүүхэд хамгааллын үйл ажиллагаа зөвхөн улсын төсвөөс санхүүжүүлдэг бөгөөд бусад эх үүсвэрийн санхүүжилт одоогоор байхгүй байна. Сүүлийн жилүүдийн төсвийн зарцуулалтыг авч үзэхэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд зарцуулж буй зардал эрс нэмэгдэж байна. Энэ нь хүүхдийн хүчирхийлэл нэмэгдэж байгаа болон үйлчилгээний эрэлт хэрэгцээ өсөж байгаатай холбоотой юм. Мөн хүүхэд хамгаалалд урьдчилсан арга хэмжээ болон санхүүжилтийн төлөвлөлт тэр бүр оновчтой байж чадахгүй байгааг харуулж байна.

140. Аймгийн хэмжээнд хүүхдийн хүчирхийлэл жил бүр нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидын тоо 2019 онд 4 байсан бол 2020 онд 6 болж нэмэгджээ. Мөн ТХБ-нд 2020 онд нийт 44 хүүхэд үйлчлүүлсэн бол 2021 оны эхний таван сарын байдлаар 42 хүүхэд үйлчлүүлж өмнөх оны мөн үеэс эрс нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ нь ковидоос шалтгаалсан хөл хорионы үеэр гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Хүүхдийн хүчирхийлэл жил бүр нэмэгдэж байгаатай уялдан хүүхэд хамгааллын зардлыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэхэд анхаарах, эцэг эхийн ухамсар, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулах шаардлага байсаар байна.

141. Хөдөө орон нутаг, аймгуудад хүүхэд хамгааллын үйлчилгээнд зарцуулж буй Хамтарсан багийн зардлын хэмжээ 2020 онд нийт 259 сая төгрөг байна. Хүүхэд хамгааллын зардалд зориулсан улсын төсвийг аймаг тус бүрээр авч үзэхэд нэг аймагт дунджаар 3 сая төгрөг ногдож байхад харин Увс аймагт 77 сая төгрөгийг Хамтарсан багийн үйл ажиллагаанд зарцуулсан байна. Энэ нь аймаг тус бүрд харилцан адил, тэнцвэртэй санхүүжилтийн бодлого байхгүй байгааг илтгэж байна. Түүнчлэн тэдгээр санхүүжилт ямар үр дүнд хүрсэн талаарх тайлан буюу үр дүнд суурилсан тайлан, санхүүжилтийн бодлого байхгүй байна.

Хүснэгт 9: Санхүүгийн эх үүсвэр

Санхүүгийн эх үүсвэр	Санхүүжилт, сая төгрөг
Хүүхэд хамгааллын зардал /улсын төсөв/	121.6
Орон нутгийн төсөв	80.2
Олон улсын байгууллага	27.7
Бусад /Хандив/	29.4
НИЙТ	259

142. **Олон улсын байгууллагын санхүүжилт:** Дэлхийн Зөн Монгол ОУБ, Японы Хүүхдийг Ивээх Сан, Норвегийн Тусламжийн Байгууллага, Гүүд нэйборс зэрэг хэд хэдэн олон улсын байгууллагууд нь Монгол Улсын хэмжээнд хүүхэд хамгаалал, хүүхдийн хөгжил чиглэлээр өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг хамгийн их санхүүжилтийг зориулдаг байгууллагууд юм. Жишээ нь: Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын сүүлийн 3 жилд жил бүр 2-3

сая ам.доллар буюу жилд дунджаар бараг 6.5 тэрбум төгрөгийг хүүхэд хамгаалалд, харин 9 тэрбум төгрөгийг хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт зориулан зарцуулж байна. Энэ нь нийт дүнгээрээ хүүхэд хамгаалалд зарцуулж буй улсын төсвөөс бараг 2 дахин өндөр үзүүлэлт юм.

Хүснэгт 10: Хүүхэд хамгаалал болон хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр (мянган ам.доллар)⁷⁰

№	Төрөл	2018	2019	2020
1	Хүүхэд хамгаалал	2,244	2,617	2,237
2	Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр	3,768	3,074	2,656
	Нийт	6,012	5,691	4,893

143. Санхүү, нөөцтэй холбоотой мэдээллийг дүгнэн үзвэл хүүхэд хамгааллын тогтолцооны төсвийн зарцуулалтын талаар судалж үзэхэд системийн хувьд сайжруулах олон асуудал урган гарч ирж байна. Тухайлбал, мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна. Тэр дундаа хүүхэд хамгааллын зардал, эх үүсвэрүүд, зориулалт, зарцуулалтын нарийн дата, санхүүжилтийн үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл тун хомс, олдоц муутай мөн ил тод биш байна. Судлаач, олон нийтэд ил байгаа ганц мэдээлэл нь шилэн дансны мэдээлэл байгаа ч шилэн дансанд оруулсан мэдээлэл хэт ерөнхий мөн санхүүжилтийн тушаал шийдвэрийн хавсралт, зарцуулалтын зардлыг тэр бүр хавсаргадаггүй байна. Мөн шилэн дансанд хүүхэд хамгаалалд зориулж бусдаас өгсөн хандив, тусламжийн зарцуулалт ерөнхий байдлаар орсон нь зарцуулалтын ил тод байдал хангалтгүй байгааг илтгэнэ.

144. Төсвийн зарцуулалтын зориулалт, ангилал тодорхойгүй байна. Хүүхэд хамгааллын зардалд жил бүр 8 тэрбум төгрөг төсөвлөгддөг боловч зарцуулах зориулалт, санхүүжүүлэх үүрэг, чиглэл нь холбогдох хууль, журамд тусгагдаагүй байна. Тиймээс хүүхэд хамгааллын зардал нь халамжийн үйлчилгээ болон бусад салбарын зардалтай давхцах, зориулалтын бусаар ашиглах зэрэг хүндрэлүүдтэй тулгардаг. Хүүхэд хамгааллын тогтолцоонд урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах санхүүжилт хангалтгүй байна. Мөн хүүхэд хамгааллын зардлын нэгж бүрийн жишиг норм, норматив, тариф байхгүй байна. Иймд төсвийн зарцуулалт бодитой бус, үр ашиг, үр дүн багатай зарцуулагдах эрсдэлтэй байгаа нь харагдаж байна.

145. Санхүүжилттэй холбоотой хууль эрх зүйн орчин хангалтгүй байна. Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхэд хамгааллын үйл ажиллагааг санхүүжүүлэх тухай ерөнхий заалт байгаа боловч төсвийн тухай хуульд хүүхэд хамгааллын санхүүжилтийн талаар зохицуулалт тусгагдаагүй байна. Цаашлаад хүүхэд хамгааллын санхүүжилтийн нарийн төлөвлөлт, зарцуулалтын зориулалт, ангилал болон ил тод байдал зэрэг нарийвчилсан эрх зүйн баримт бичиг байхгүй байна.

146. **Хүүхэд хамгааллын тогтолцооны чадавх:** 2016 оноос хүүхдийн төлөө үндэсний байгууллагын чиг үүргийг гэр бүл, залуучуудын хөгжлийн асуудлаар өргөжүүлэн, эрх хэмжээний хувьд хуучин хэвээр Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар болгон өөрчлөн зохион байгуулсан билээ. Үндэсний агентлаг 50 шахам хүний орон тоотой, аймаг нийслэлд дунджаар 15-30 хүнтэй төрийн захиргааны байгууллагын бүтэц ажиллаж байна. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар мэргэшиж, бэлтгэгдсэн хүний нөөц 2017 оноос сарниж, чиг үүрэг өөрчлөгдөх, зарим ажилтнууд улс төрийн намын нөлөөгөөр ажлаас

⁷⁰ Эх сурвалж: Дэлхийн Зөн Монгол ОУБ 2018, 2019, 2020 оны жилийн тайлангаас

халагдах, өөрчлөгдөх байдал үргэлжлэх болсон. Шинэ залуу ажилтныг сургах, хөгжүүлэх системтэй хөтөлбөр төлөвлөгөө байхгүйгээс ажлын байрны тогтвор суурьшил хангагдаж чадахгүй байна.

147. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 14.3-т заасны дагуу ГБХЗХГ-ын Сургалт, судалгаа, мэдээллийн төвтэй байх бөгөөд тус төв хүүхэд, гэр бүлийн асуудлаар үр дүнд суурилсан бодлого төлөвлөлтөд зориулсан судалгаа, үүрэг хүлээгч талуудад тогтмол сургалт, мэдээлэл өгөн ажиллах хүүхэд хамгааллын тогтолцооны амин сүнс нь болж ажиллах ёстой юм. Гэтэл өнөөгийн байдлаар тус төв нь хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр судалгаа, сургалт, мэдээллийг тогтмол, үр дүнтэйгээр зохион байгуулж чадахгүй байна. Иймд олон улсын байгууллагууд, донор байгууллагуудын санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр нь хүүхэд хамгааллын тогтолцооны чадавхыг бэхжүүлэн, мэргэжлийн арга зүйд дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа хамгийн том хөрөнгө оруулагч болж байна. Жишээлбэл: ДЗМОУБ өөрийн салбарын үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн Хамтарсан баг, ХЭХЗХ, ХТЗ, аймаг болон дүүргийн ГБХЗХБ-д сургалт, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн нягт хамтран ажиллаж байна. Мөн Японы Хүүхдийг Ивээх Сан нь Хамтарсан багийн сургалтаар мэргэшин үндэсний оролцогч бүх талуудад мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

148. Хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд мэргэшсэн, туршлагатай ажилтнууд анхан шатны нэгжээс эхлэн бодлого тодорхойлох түвшинд хүртэл ажиллах шаардлагатай байна. Гэтэл хүүхэд хамгааллын тогтолцооны үүрэг хүлээгчид, үйлчилгээ үзүүлэгчдийн мэргэшсэн байдал тогтолцооны хамгийн сул талбаруудын нэг байсаар байна. Хүүхэд хамгааллын тогтолцоонд ажиллаж байгаа төрийн байгууллагын ажилтнууд өөрийн өдөр тутмын ажлыг хийхэд олон төрлийн бэрхшээлтэй тулгарч байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч ГБХЗХГ болон харьяа хэлтсийн ажилтнуудын хувьд ажлын ачаалал их, ажлын байранд сурах боломж бага, ирээдүйд ямар тогтолцоогоор албан тушаал ахиж, мэргэшиж ажиллах нь тодорхойгүй байна.

149. Хамтарсан багийн гишүүд үүргээ өөрийн үндсэн ажлын хажуугаар хавсарга байдлаар урамшуулал, мэргэжлийн чиглүүлэг, дэмжлэггүйгээр ажилладаг бөгөөд, төрөөс болон ОУБ-ын санхүүжилтээр сургалтууд жил бүр зохион байгуулж байгаа ч гишүүдийн тогтвортой байдал сул, ажлын залгамж халаа хадгалагдахгүй байна. 2020 оны УИХ-ын сонгуулийн дараа нийт нийслэлийн хороодын Хамтарсан багийн гишүүдийн 60 хувь нь өөрчлөгдсөн байна. Цаашлаад төрийн байгууллагын бүх түвшний ажилтнууд парламентын сонгуулийн дараа солигддог, улс төрөөс хараат томилгоотой, цалин бага, ажлын ачаалал их учир чадварлаг мэргэшсэн боловсон хүчин төрийн байгууллагын ажилд орох хүсэл эрмэлзэл бага байна.

150. Төрийн албаны тухай хуулиар улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байна. Мөн төрийн албан хаагч сонгон шалгаруулж томилоход аливаа хэлбэрээр нөлөөлөх, дарамтлах, шахалт үзүүлэх хориотой.⁷¹ гэсэн хэдий ч дөрвөн жилийн хугацаатай хороо, баг, цэцэрлэг сургуулиас эхлэн төрийн байгууллагын дарга солигдож, багаа бүрдүүлэх нэрийдлээр гүйцэтгэх албан тушаалтныг солих нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн дадал болон тогтож байгаа нь харамсалтай. Ийнхүү улс төрийн нам, эвслээс хамааралтай төрийн албан томилгоо нь нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд тушаа болж байна

⁷¹ Төрийн албаны тухай хууль 31.2 Энэ хуульд заасан журмын дагуу төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж томилоход Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, төсвийн ерөнхийлөн захирагч, улс төрийн албан тушаалтан, улс төрийн нам, эвслийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад этгээдийн зүгээс аливаа хэлбэрээр нөлөөлөх, дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.

Засаг дарга хамтарсан баг, багийн ажлыг сайхан ойлгож эхлэх үед дараагийн сонгууль болдог. Сонгуулийн дараа бүх дарга нар солигддог. Хүүхэд хамгаалал дээр гэр бүлийн хүчирхийллийн асуудал дээр сонгуулиас сонгуулийн хооронд түр зуурын шинжээр ажиллахад бэрхшээлтэй байна.

Бүлгийн ярилцлага

151. Ийнхүү төрийн ажилтнуудын тогтвортой бус байдал нь бодлогын хэрэгжилт, залгамж халаа, ажлын байр нь дээр хөгжиж, ажлын үр бүтээмжийг сайжруулах боломжийг хязгаарлаж мэргэшсэн, туршлагатай, чин сэтгэлээсээ ажиллах албан хаагчийн тоо жилээс жилд цөөрсөөр төрийн үйлчилгээний чанар хүртэмж улам л муудсаар байна. Энэ бэрхшээл нийгмийн салбарыг тэр дундаа хүүхэд хамгааллын салбарыг ч тойрч гарсангүй. Шинэ хууль журмын хэрэгжилт бэхжээгүй, туршлага нимгэн хүүхэд хамгааллын тогтолцоонд улс төрөөс хараат томилгооны сөрөг нөлөө хүчтэй орж ирж байгаа нь төрийн, ОУБ, донор байгууллагын оруулсан хувь нэмэр хий дэмий урсан өнгөрч, дөрвөн жил тутамд бүх төрийн байгууллагатай дахин шинээр танилцан, хамтын ажиллагаагаа эхлүүлдэг мөчлөгт шилжиж байна.

152. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан тайланд төрийн албаны томилгоо улс төрийн нам, хахуулаас хэт хамааралтай байгаагаас Монгол Улсад мэргэжлийн төрийн алба үгүйлэгдэж байна. Тиймээс шинэчлэн баталсан Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхийн тулд Төрийн албаны зөвлөл улс төрийн нөлөөллөөс ангид, чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхтай байх; төрийн албан хаагчдын цалинг өрсөлдөхүйц хэмжээнд нэмэгдүүлэх; ил тод, шударга цалин, урамшууллын системтэй болох; хүний нөөцийн менежментийг сайжруулахын тулд төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн системийг нэвтрүүлэхийг зөвлөсөн байна.⁷²

153. 1997 онд Их Британий Нэгдэн Вант Улсын Засгийн газрын түншлэлийн хөтөлбөрийн санхүүгийн шууд дэмжлэг, туслалцаатайгаар Нийгмийн ажилтны сургалт судалгаа арга зүйн төв нь Боловсролын Их Сургуульд байгуулагдсанаар нийгмийн ажилтныг Монгол Улсад бэлдэж эхэлсэн билээ.⁷³ Сүүлийн 24 жилийн хугацаанд нийгмийн ажилтны карьер хөгжилд нарийвчлан мэргэших, мэргэжил дээшлүүлэх, карьер төлөвлөлт, мэргэжлийн зэрэг, лицензжүүлэх, цалин, урамшуулал шатлалтайгаар нэмэгдүүлэх тогтолцоо хараахан хөгжөөгүй бөгөөд цаашдын ажил мэргэжлийн төлөвлөлт бүрхэг учир нийгмийн ажилтнаар төгссөн залуучууд мэргэжлээрээ ажиллах нь бага байна. Тиймээс хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, тогтвортой байдлыг хангахын тулд нийгмийн ажилтны карьер хөгжлийг боловсрол, эрүүл мэндийн салбартай адил дээрх дурдсан асуудлуудыг нарийн тодорхой төлөвлөн, эрх зүйн баримт бичгээр баталгаажуулан нийгмийн ажилтнуудыг мэргэжлээрээ ажиллах боломжоор хангах нэн шаардлагатай байна.

⁷² OECD.2019. Anti-Corruption Reforms in Mongolia: Fourth Round of Monitoring of the Istanbul Anti-Corruption Action Plan. available at: <https://www.oecd.org/corruption/acn/OECD-ACN-Mongolia-4th-Round-Monitoring-Report-2019-ENG.pdf>

⁷³ МУБИС, Боловсрол судлалын сургуулийн танилцуулгаас <https://ses.msue.edu.mn/Category/Read/6ebe8c47-33aa-459c-95cf-400099d5b68d>

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА, САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТ

154. **Хүүхдийн төлөө зөвлөл үндэсний болон орон нутгийн зөвлөл** нь Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн эрхийг хангахад нийгмийн нөөц баялгийг дайчлах; салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээ авах; холбогдох төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгөх үүрэгтэй. Үндэсний хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүнд бүх яамдын төрийн нарийн бичгийн дарга нар, ХЭҮК, ОУБ болон ТББ төлөөлөл ордог бол орон нутгийн түвшинд Засаг дарга, нийгмийн ажилтан буюу нийгмийн бодлогын түшмэл, боловсролын газар, эрүүл мэндийн газар, цагдаагийн газар, хөдөлмөр, нийгмийн халамжийн газар зэрэг орон нутгийн түвшний нийгмийн үйлчилгээ үзүүлэгч. Үндэсний хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүнд бүх яамдын төрийн нарийн бичгийн дарга нар, ХЭҮК, ОУБ болон ТББ төлөөлөл ордог бол орон нутгийн түвшинд нийслэлд Хүүхдийн төлөө зөвлөлийг тухайн шатны Засаг дарга тэргүүлдэг.

155. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл нь жилд нэгээс хоёр удаа хуралдаж тухайн жилийн ажлын төлөвлөгөөг баталж, өнгөрсөн онд хийсэн ажилтай танилцах зарчмаар ажиллаж байгаа нь тус зөвлөл салбар дундын зохицуулалт хийж ажиллах үүргээ биелүүлэхгүй, бэлэг тэмдэг төдий ажиллаж байгаагийн илрэл юм. Тиймээс Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс шийдвэр гарган хүүхдийн талаар шийдсэн салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлсэн тохиолдлууд хуруу дарам цөөн байна.

Хүүхдийн төлөө зөвлөл хоёрхон цагт багтааж жилийн ажлаа дүгнэн, тухайн жилийн төлөвлөгөө батлах жишээтэй. Аль нэг байгууллагад үүрэг даалгавар өгдөг ямар ч ажил хэргийн уялдаа холбоогүй, үр дүнтэй хэлэлцүүлэг өрнөхгүй дуусдаг.

Ганцаарчилсан ярилцлагаас

156. Сумын Хүүхдийн төлөө зөвлөл, ГХЗУСАЗЗСЗ-ийн бүрэлдэхүүнд хэд хэдэн албан тушаалтан давхардаж ордог. Энэ зөвлөлүүдийн гишүүд ихэнх нь зорилго, чиг үүргийн ялгааг сайн мэдрээгүй байдал ярилцлагын үеэр ажиглагдсан. Зарим орон нутагт ХТЗ, ХЭХЗХ-ны ээлжит хуралдааныг хамтад нь нэгдсэн байдлаар зохион байгуулж байна. Дүүрэг, аймаг, нийслэл дэх ХТЗ хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж байгаа эсэхийг хянах хяналт байхгүй, гишүүдийн ажил үүргийн биелэлт, жилийн гүйцэтгэлийн үнэлгээ зэрэгт ордоггүй учир сайн дурын үндсэн дээр тус зөвлөл ажиллаж байна. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.1-д заасан уг зөвлөлийн чиг үүргийг оновчтой болгох; удирдамж, арга зүйн дэмжлэг үзүүлэх; гишүүдийн ажил үүргийн хуваарьт тус зөвлөлд үр дүнтэй ажиллах талаар нэмж оруулах, гишүүдийг тогтмол мэдээллээр хангах, чадавхыг бэхжүүлэх, үйл ажиллагааг нь хянах хэрэгтэй байна. Засаг дарга УИХ-ын сонгуулийн дараа үргэлж солигддог нь тогтвортой байдлыг хангахад хүндрэл болж байна. Судалгаанд оролцогч аймаг, дүүргийнхний төлөөлөлтэй хийсэн ярилцлагаар тус зөвлөлийн ажил явагдах эсэх нь засаг даргын хүсэл эрмэлзэл, хандлагаас шууд хамаардаг гэдгийг дурдаж байсан юм.

157. Иймд салбар дундын хамтын ажиллагааг зохицуулахын тулд салбар бүрийн оролцоог нарийн тодорхойлж холбогдох хууль, журамд тусгах, салбар бүрд хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллуулах, салбарын хүүхэд хамгааллын чадавхыг бэхжүүлэх, сургалтыг одоо байгаа сургалтын системд суулгах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд шаардлагатай төсөв, хөрөнгийг жил бүр салбарын төсөвт суулгах ажлуудыг хийж байж хүүхэд хамгааллын тогтолцоонд оролцогч тал бүр үүрэг хариуцлагатайгаар, нөөцтэйгөөр үйл ажиллагаа хамтран явуулах боломж бүрдэх юм.

158. **Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал.** Боловсролын орчинд хүүхдэд аливаа шийтгэлийн арга хэрэглэх, ялгаварлан гадуурхах, дарамт, хүчирхийлэлд өртүүлэхийг хориглож, хүчирхийллийн асуудлыг илрүүлэх, мэдээлэх, үйлчилгээг дэмжих, хүүхдэд хүчирхийллийн бус харилцааны мэдлэг, ур чадвар олгох, зан үйлд нөлөөлөх зэрэг сургалт явуулах, хүчирхийллээс ангид орчин бүрдүүлэх үүрэг зохицуулалтыг Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай зэрэг хуулийн 40 гаруй заалтаар хуульчилжээ.

159. Тиймээс сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие мах бодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор БШУЯ-ны зүгээс 2017-2020 онуудад хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр дараах дүрэм журам, нийтлэг шаардлагуудыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

- “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”,
- “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”,
- “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам”,
- “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын стандарт”,
- “Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын дотуур байрын орчин, үйлчилгээний стандарт”,
- “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчны эрүүл ахуйн стандарт”

160. Эдгээрийг хэрэгжүүлснээр хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хангах; хүүхэд хамгааллын зарчим, ёс зүйг түгээх; эцэг эхэд нөлөөллийн үйл ажиллагаа явуулах; хүүхдийн хамгаалал, аюулгүй байдлыг хангах үйлчилгээ үзүүлэх⁷⁴; сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх; хүчирхийллээс сэргийлэх үйлчилгээ болон хариу үйлчилгээ⁷⁵; эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийг хүлээн авах, шалгах⁷⁶; Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах; нөхцөл байдлын үнэлгээ хийх⁷⁷; суралцагчийн эрүүл мэндийн болон сэтгэцийн тулгамдсан асуудлын эрсдэлийн үнэлгээ хийж, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын тусламж үзүүлэх⁷⁸ чанар хүртээмж нэмэгдэх боломжтой болсон.

161. БШУЯ, УИХ-ын байнгын хорооны зөвлөмжөөр дунд сургуульд хүүхэд хамгааллын үйлчилгээнд шаардлагатай төсвийн тооцоог хийж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 445.0-485.0, эрсдэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд 162.0-331.0 сая төгрөг нийт 521.0-708.0 сая төгрөг нэг сургуульд дунджаар шаардагдах тооцоолол гаргажээ.⁷⁹ Дархан-Уул, Орхон, Говь-Алтай, Хөвсгөл, Увс аймаг болон нийслэлийн зарим сургуулиуд сэтгэл зүйч ажиллуулахдаа ихэнх нь олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгээр ажилтны цалин хөлсийг шийдэж эхэлсэн байна.

⁷⁴ Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт

⁷⁵ Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам

⁷⁶ Хүүхдийн эрхийн ажилтны ажиллах журам

⁷⁷ Хүүхэд хамгааллын тухай хууль

⁷⁸ Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар

⁷⁹ Ярилцлагын үр дүнгээс

162. Сургуулийн Хүүхэд хамгааллын бодлого батлагдаж хэрэгжээд даруй дөрвөн жил болж байгаа ч тус бодлого мэргэжлийн хяналтад үзүүлдэг олон цаасны нэг болж хэрэгжилт биеллээ олохгүй байна. Багш нарын хувьд хүүхдийн эрх, хамгааллын талаар мэдлэг дутмаг байгаа учир заавал мэдээлэх үүргээ төдийлөн ухамсарлахгүй байна. Сургуулийн орчинд гарч байгаа хүүхэд хамгааллын хамгийн түгээмэл асуудал нь багшийн ёс зүйн зөрчил, үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт мөн дотуур байрны сурагчдын асран хамгааллын асуудал юм. ЕБС-ийн хэмжээнд 2019 оны эхний таван сарын байдлаар 395.0 мянган хүүхэд эрсдэлд нөхцөлд байгааг үнэлж тогтоосон байна. ЕБС-ийн дотуур байранд амьдардаг 150.0 мянган хүүхдийг судалж нарийвчлан хяналт тавьж ажиллаж эхэлж байсан. Судалгаанд оролцсон хүүхдүүдийн зүгээс ч сэтгэл судлаач сургууль дээр ажиллуулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг хамгийн их өгч байсан нь хүүхдүүдийн зүгээс ч сэтгэл зүйчдэд асуудлаа нээлттэй хэлэх хүсэлтэй байгаа нь харагдаж байлаа.

Хүүхэд хамгааллын бодлого гараад 2 жил болоход нийт ЕБС-ийн дөнгөж 80 хувь нь өөрсдийнхөө онцлогт тохирсон хүүхэд хамгааллын бодлого боловсруулсан. Харин 20 хувь нь судлаагүй, онцлогтоо тохируулж буулгаагүй. Тийм сургуулиудыг ажиглавал удирдлага тогтворгүй, мэргэжлийн бус зэрэг шалтгаан байх магадлалтай.

Ганцаарчилсан ярилцлагаас

163. Хүүхэд хамгааллын тухай хуулинд боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилтнууд хүүхдийн эсрэг хүчирхийллийг таамагласан, мэдсэн тохиолдолд заавал мэдээлэх үүрэгтэй. Гэсэн хэдий ч боловсролын салбар сургуулийн нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын ажлыг зохион байгуулах ёстой гэсэн ташаа хандлага түгээмэл байгаагаас багш, бусад ажилтнуудын зүгээс хамгаалал шаардлагатай хүүхдийг нийгмийн ажилтанд даатган үлдээдэг байна. Гэтэл нийгмийн ажилтанд сургуулийн захиргааны ажил, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ, Хамтарсан багийн гишүүний ажил гээд дуусашгүй олон ажилтай байдаг бөгөөд тэдэнд хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэжлийн арга зүй дэмжлэг үзүүлдэггүй, аюулгүй байдлыг нь хангах тогтолцоо байхгүй, сургуулийн зүгээс хийж байгаа ажлыг нь ойлгон дэмжих хандлага дутмаг байна.

Суманд багш нар хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдсэн ч хүнтэй муудалцахаас айдаг. Зарим нь танхай архичин учир үр хүүхдийг маань цохиж зодох юм билүү гэж болгоомжилно. Би мэдээлмээргүй байна гэдэг. Сум цөөн хүнтэй мэдээлэх үүргээ биелүүлэхэд хэцүү. Тиймээс мэдээлэх үүргээ биелүүлэх гэдэг чинь дахиад нарийн зохицуулалт хэрэгтэй.

Ганцаарчилсан ярилцлагаас

164. Хүүхэд хамгааллын тогтолцоон дахь бусад үүрэг хүлээгчдийн адилаар холбогдох ажилтны ажил үүргийн хуваарьт хүүхэд хамгааллын үүрэг ороогүй, дүрэм, журам, стандарт дутмаг, зориулсан төсөвгүйгээс тухайн сургууль хүүхэд хамгааллын чиглэлээр хэр сайн ажиллах нь захирлын мэдлэг, хандлага, туршлагаас бүрэн хамаарч байна. Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хүүхдийн зөвлөлтэй холбогдох ажилтны ажил үүргийн хуваарьт хүүхэд хамгааллын Энэ субъектуудын үндсэн ажлын байрны тодорхойлолтод Хамтарсан багт гүйцэтгэх үүрэг, гүйцэтгэлийг үнэлэх ажил байхгүй байна. Сургуулийн орчинд хүүхэд хамгааллын журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг, зориулсан төсөвгүйгээс тухайн сургууль хүүхэд хамгааллын чиглэлээр хэр сайн ажиллах нь захирлын мэдлэг, хандлага, туршлагаас бүрэн хамаарч байна.

Манай сургууль Дэлхийн Зөнгийн салбартай ойр ажилладаг учир хүүхэд хамгааллын бодлогыг сайтар боловсруулж хэрэгжүүлж байгаа. Хүүхэд хамгааллын сургалтыг бүх ажилтнуудад шат дараалалтай өгсөн. Тиймээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх асуудлаар жижүүрээс авахуулаад бүх түвшний ажилтнууд хүүхэд хамгаалахад чухал үүрэг оролцоотойг мэддэг болсон. Хавар, намар эцэг эхтэй заавал уулзах, сургалт хийж эерэг арга, хүүхдийн эрхийг зүрх, тархинд нь шингээж өгдөг.

Ганцаарчилсан ярилцлагаас

165. Сургуулийн дотуур байранд хүүхдүүд бүтэн жилийн есөн сарыг өнгөрөөдөг бөгөөд энэ хугацаанд хүүхдүүдэд эцэг эх, асран хамгаалагчийн халамж, хараа хяналт байхгүйгээс хүүхдүүдэд олон асуудал тулгардаг байна. Судалгааны ярилцлагаар сургуулийн дотуур байр боловсролын салбарт харьяалагддаг учир хүүхэд хамгааллын ажилтнууд төдийлөн очдоггүй тухай олон удаа дурдагдсан юм. Цаашлаад МСҮТ-ийн дотуур байранд хүүхдүүд эцэг эхээс хол, хараа хяналт сул орчинд бие биенээсээ олон муу зүйл сурдаг сөрөг талтай бөгөөд МСҮТ-ийн дотуур байранд хүүхдийн эрхийг хамгаалах, амьдрах ухаанд сургах хөтөлбөр үйл ажиллагаа явуулдаггүй байна. Хэдийгээр ХНХЯ-ны харьяа боловч МСҮТ болон дотуур байранд нь хамгааллын бодлого байдаггүй, хүүхэд хамгааллын үйлчилгээ орхигдсон талууд хэвээр байна.

166. ЕБС-ийн төлөөлөлтэй хийсэн уулзалтаар сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн зүгээс эрсдэлд бүлэгт байгаа хүүхэдтэй ажиллаж байгаа боловч хүүхдүүдийн ар гэрт нь байгаа асуудлыг шийдвэрлэж чаддаггүй учир асуудал хэвээрээ байгаад байгааг дурдаж байсан юм. Зарим сургуулийн хувьд эрсдэлд бүлгийн хүүхдээ хамгаалахын тулд сургуулийн дотуур байранд оруулдаг гэдгийг хуваалцаж байсан юм. Мөн түүнчлэн хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөд сургуулийг хүүхэдтэйгээ хамтарч ажилласангүй гээд сургуулийн нэр дээр асуудал үүсдэг тул зарим сургуулийн хувьд асуудал гарсан ч сургуулийн нэр хүндэд халтай гээд нуудаг, хүүхдийг сургуулиас шилжүүлдэг үзэгдэл амь бөх хэвээр байна. Нөгөөтэйгүүр сургуулийн ажилтнуудын зүгээс хүүхэд гэртэй байхдаа хүчирхийлэлд өртсөн бол сургуулийн нэрээр явахгүй байх саналыг дамжуулж өгөхийг хүсч байсан юм. Үүнтэй холбоотойгоор судалгаанд оролцогч хүүхдүүдийн зүгээс сургууль дээр асуудал гарвал нууцлал хангагдаагүй учир аль болох мэдээлэхгүй өнгөрөөдөг гэдгийг мөн хэлсэн юм.

Багш гэдэг хүн хүүхдийн найз байх ёстой байдаг гэтэл багшдаа өөрт тулгарсан асуудлаа очоод хэлчихвэл нөгөөдөх нь сургууль даяар тарж, бөөн хэл ам болчихно. Тиймээс хэл амнаас нь айгаад ер нь бол хэлдэггүй.

Бүлгийн ярилцлагаас

167. **24 цагийн цэцэрлэг.** Сүүлийн жилүүдэд цэцэрлэгүүд 24 цагийн анги нээж мөн 24 цагийн улсын болон хувийн цэцэрлэгүүд шинээр бий болсон байна. Хамтарсан баг, ГБХЗХХ-ийн зүгээс эрсдэлд нөхцөлд байгаа, малчны хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт холбон зуучлах ажлыг хийж байна. Ганцаарчилсан ярилцлагаар 24 цагийн цэцэрлэгт төрийн албан хаагчид, урлаг, спортын салбарын ажилтнууд хүүхдээ ихэвчлэн өгдөг мөн хүүхэд хамгааллын ажилтнууд дунд хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт өгөх нь архины хамааралтай эцэг эхтэй нь байлгахаас дээр гэсэн үзэл давамгайлдаг талаар хуваалцсан юм.

168. Цаашид боловсролын салбар дахь хүүхэд хамгааллыг сайжруулахын тулд хүүхэд хамгааллын бодлогыг боловсронгуй болгох, сургуулийн багш, ажилтнуудын ажил үүргийн хуваарьт хүүхэд хамгааллын ажлыг оруулах, сургуулийн багш, ажилтнуудыг хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сэдэвчлэн сургах, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх болон урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад шаардлагатай төсвийг суулгах, сургуулийн нийгмийн ажилтны тоог нэмэгдүүлэх, сургууль бүрд сэтгэл зүйч ажиллуулах хэрэгцээ шаардлагатай байна.

169. **Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал.** Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчдад заавал мэдээлэх үүрэг хүлээдэг. Шүүх эмнэлгийн амбулаторийн үзлэг оношлогоо болон лабораторийн шинжилгээ нь насанд хүрээгүй хүнд үнүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэ⁸⁰ Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Нийгмийн эрүүл мэндийн алба 2019-2020 онд НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр 10 аймгийн эмч эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдэд “Хүчирхийллийн хохирогчид эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, түүний дагуу заавал мэдээлэх үүргийн талаарх” сургалтыг тогтмол шат дараалалтай зохион байгуулж байна. Сургалтын үр дүнд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг ЦЕГ-ын Хүүхэд хамгааллын хэлтэст мэдээлэх журам гарсан. Мөн нийслэлийн дүүргүүдийн эмнэлгийн ажилтнуудад тус сургалтыг зохион байгуулсан нь хохирогч төвтэй үйлчилгээний эхлэл тус салбарт тавигдаж байгаагийн илрэл болсон юм.⁸¹

170. Улсын төсвөөс эрүүл мэндийн салбарт хүүхэд хамгааллын төсөв одоогоор байхгүй. Хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний тухайд эмч, ажилтнуудад маш тодорхой мэдлэг мэдээлэл хэрэгтэй байгааг ярилцагч талууд судалгааны үеэр онцолж байлаа. Эрүүл мэндийн салбарт одоогоор хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид, түүний дотор хүүхдэд зориулсан жендерийн мэдрэмжтэй, сэтгэл зүйн засалд чиглэсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ, түүнийг зохицуулсан журам байхгүй байна. Ярилцлагын үеэр эрүүл мэндийн салбарын удирдлагын зүгээс хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд эрүүл мэндийн салбартай хамтын ажиллагааны бэхжүүлэх, эмч мэргэжилтнүүдийнхээ хүүхэд хамгааллын мэдлэг ойлголтуудыг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээтэй гэж үзэж байна.

171. **Иргэний нийгэм, ТББ-ын хамтын ажиллагаа.** Судалгааны хүрээнд үндэсний хэмжээнд хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагуудын төлөөллөөс ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага авсан юм. Ярилцлагын үр дүнд хүүхэд хамгааллын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-дад нь дараах хоёр нөхцөл байдалд ажиглагдаж байна. 1990 оноос хойш ОУБ-ын байгуулагдсан төрийн бус байгууллагуудын хувьд ОУБ-ууд, төрөөс дэмжлэггүй учраас үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон хэсэг ТББ байхад өөрийн чадавх, нөөцөд тулгуурлан дотооддоо хөрөнгө босгох, донор байгууллагуудаас төсөл авч хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байгаа ТББ-ууд мөн байна. Эдгээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хувьд төрөөс төсвийн дэмжлэг авахгүйгээр төрөөс үзүүлж буй хүүхэд хамгааллын үйлчилгээнд бодит хувь нэмэр үзүүлэн, ачаалал үүрэлцэж байгаа юм.

⁸⁰ ХЗДХС. ЭМС, СС-ын 2017 оны А/115, А/176, 142 тушаал 3.5 “Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам”-ыг эрүүл мэндийн албан журмын даатгалын шимтгэлийг сар бүр улсын төсвөөс хариуцаж төлөх, төрөөс бүх нийтийн олгох талаар журамласан.

⁸¹ Ганцаарчилсан ярилцлагаас

172. Сүүлийн жилүүдэд олон улсын хэмжээнд хүүхдэд чиглэсэн хувь хүмүүсийн хандив тусламж буурсантай холбоотойгоор донор байгууллагуудын тендер, төсөлд ОУБ, үндэсний ТББ-ууд өрсөлддөг болсон нь хүний нөөцийн чадавх, үйл ажиллагааны туршлага дутмаг үндэсний ТББ нь ОУБ-тай энэ зэрэгцэн өрсөлдөхөд бэрхшээлтэй байна. Монгол Улсын газар зүйн онцлог, Улаанбаатар дахь хүн амын төвлөрлөөс шалтгаалан аймаг, сумын түвшинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг ТББ бараг байхгүйтэй адил байна. Иймд ТББ-ын зүгээс хүүхэд хамгааллын асуудлаар ХНХЯ, ГБХХГ, аймаг/ дүүрэг дэх ГБХЗХХ-ийн үйл ажиллагаанд мэргэжлийн тусламж үзүүлэх, хяналт тавьж, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах тул дээр хангалттай ажиллаж чадахгүй байна. Үүрэг хүлээгч талуудтай хийсэн ярилцлагаар орон нутгийн болон үндэсний түвшинд хүүхэд хамгааллын тогтолцоонд шашны байгууллагын оролцоо байхгүй гэж мэдээллээ.

ХҮҮХДИЙН ТАЛААРХ НИЙГМИЙН ҮЗЭЛ БОДОЛ, ХАНДЛАГА

173. Өнгөрөгч жилүүдэд төр, ОУБ, ТББ, хувь хүмүүсийн зүгээс хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор олон тооны үйл ажиллагааг зохион байгуулсан нь хүүхэд хамгааллын талаар нийгмийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх дадлыг нэмэгдүүлсэн байна. Хэдийгээр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал сүүлийн жилүүдэд сайнгүй байгаа ч иргэдийн зүгээс хүүхэд хамгааллын ажилд оролцох идэвх, хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг ТББ-уудад хандив тусламж өгөх нь нэмэгдэж байна. Үүний тод жишээ нь Хүүхдийн төлөө фонд ТББ 2.2 тэр бум төгрөгийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан босгож 2021 оны 5 дугаар сарын 21-нд Хүүхдийн төлөө санд хүлээлгэн өгсөн явдал байлаа. Мөн түүнчлэн Лантуун дохио ТББ нь үндэсний болон олон улсын хэмжээнд амжилттайгаар хөрөнгө босгож Ид шидийн орон-1 болон 2 төвүүдийг хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ нэн шаардлагатай Улаанбаатар хотын гэр хорооллуудад нээн, үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байгаа нь сайшаалтай.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хандах иргэдийн хандлага өөрчлөгдөж байна. Хүүхэд навсайсан хувцастай явж байсан ч иргэд маань мэдээлэх болсон нь урьдчилан сэргийлэх ажлын үр дүн.

Ганцаарчилсан ярилцлагаас

174. Иргэдийн дунд хүүхэд хамгаалал гэдгийг хүүхэд гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон хойно нь хүүхдэд үзүүлэх үйлчилгээ гэсэн ойлголт давамгайлж байгаа бөгөөд хүүхэд хамгааллын амин сүнс нь урьдчилан сэргийлэх ажил гэдгийг иргэд, үүрэг хүлээгчдийн зүгээс төдийлөн ухамсарлахгүй байна. Үүний нэг илрэл нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээж байгаа хүүхэд хамгааллын мэдээлэлд хүүхэд эрсдэлд орсон нөхцөлд ХТУХ-108-д мэдээлнэ, Хамтарсан баг үйлчилгээ үзүүлнэ гэсэн агуулгатай мэдээлэл, сурталчилгаа давамгайлж байна.

175. Үл хайхрах хүчирхийлэл өндөр байгаагийн нэг шалтгаан нь эцэг эх, асран хамгаалагч олон цагаар ажилладаг, цалин хөлс нь амьжиргаанд хүрэлцэхгүйн улмаас давхар ажил эрхэлдэг, дэд бүтэц муу тул ажил гэрийн хооронд явахад олон цаг зарцуулдагтай мөн л холбоотой юм. Тиймээс ажил олгогчид ажилтныхаа хүүхдийн сайн сайхан байдал, хамгаалалд санаа тавьж, дэмжиж ажиллах хэрэгцээтэй байна. Ковид-19 цар тахал бидэнд ажлын цагийг уян хатан болгох, гэрээс ажиллах, ар гэрийн ажлыг эхнэр, нөхөр хоёр хуваалцах зэрэг олон боломж байдгийг сургасан юм.

176. Хэдийгээр нийгмийн үзэл бодол, хандлага хүүхдийг хамгаалахад чиглэж байгаа ч улс төрийн намууд, төрийн албан тушаалтнуудын хувьд хүүхдийн эрхийн асуудал төдийлөн чухал асуудлын тоонд эрэмбэлэгдэн орж чадахгүй байна. Жишээлбэл улсын хэмжээнд хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр тогтмол судалгаа, шинжилгээ хийдэггүй тэр дундаа хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар үндэсний түвшинд хийсэн судалгаа мэдээлэл дутмаг байгаа нь хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр оновчтой ажиллагаа явуулахад бэрхшээлтэй байна.

Манай сум, багийг удирддаг хүмүүс хамгийн түрүүнд мал ярина, тоо толгойг сайн мэднэ, эр эм, хээлтэгч эсэхээр нь хэлнэ. Хүний хөгжил, хүүхдийн эрх, гэр бүлийн асуудлыг мэддэггүй юм уу, ойлгодоггүй юм уу хойш нь тавьдаг. Тэдгээрт хэрхэн хандах, яаж өөрчлөхөө мэддэггүй.

Ганцаарчилсан ярилцлагаас

177. **Хүүхэд хамгаалал ба үндэсний соёл уламжлал:** Хурдан морины уралдаан нь Монголын ард түмний төрт ёсны өв соёлын үнэт, баяр цэнгээн байх уламжлалт хэв маягаас илүү өргөн цар хүрээтэй болж, зөвхөн зун биш өвөл, хаврын улиралд уралдаан зохиогдох болсноор хүүхэд унаж бэртэх, тэр бүү хэл амь насаа алдах хүртэл тохиолдол гарч байгаа тул олон улсын байгууллагууд болон Монголын ард түмэн ч уралдаанч хүүхдийн эрхийн асуудалд анхаарал хандуулах болсон.⁸²

178. 2017 үндэсний ТББ-ууд, ОУБ-ууд, Өмгөөллийн “ИЭлСи” ХХН хуулийн фирмтэй хамтран уралдаанч хүүхдийн хамгааллын асуудлаар Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гарган хариуцагчаар Монгол Улсын Засгийн газрыг татсан бөгөөд жил бүр өвөл, хаврын улиралд хурдан морины уралдаан зохион байгуулдаг байсан үйлдэл нь хүүхдийн эрхийн зөрчил болохыг шүүхээс тогтоосон юм. Засгийн газрын маргааны нэг үндэслэл нь уламжлал, соёл, зан заншилтай холбоотой тул бид хориглож чадахгүй гэсэн боловч Улсын төв архивын баримт бичигт шинжээч томилж дүгнэлт гаргуулахад Монголчууд өвөл, хаврын улиралд хурдан морины уралдаан зохион байгуулдаггүй байсан болох нь тогтоогдсон.

179. 2019 онд дээрх нэхэмжлэл гаргасан ТББ-ууд дахин Засгийн газрын эсрэг нэхэмжлэл гаргаж, өвөл хаврын хурдан морины уралдаан болон бэлтгэл, сургуулилтыг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хориглох, бүх шатны Засаг дарга нарт биелүүлэлтийг хариуцахыг даалгах нэхэмжлэл гаргасан бөгөөд Засгийн газраас тус нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч, 2019 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр 57 дугаартай Засгийн газрын тогтоол гаргасан. Хэдийгээр өвөл, хаврын улирлын хурдан морины уралдаантай холбоотой асуудал ийнхүү шийдвэрлэгдсэн боловч зуны улиралд үндэсний их баяр наадамтай холбоотой морин уралдаан уламжлалт соёл гэсэн нэрийн дор огт шийдвэрлэгдэхгүй байна. Үндэсний баяр наадмын тухай хуулиар хурдан морины уралдаанч хүүхдийн насыг 7 нас гэж заалт хүчин төгөлдөр үйлчилсээр байна.

180. 2021 онд ОУХБ-ын Шинжээчдийн хорооноос хурдан морь унаач хүүхэд гэмтэл бэртэл авч амь насаа алдаж байгаа санаа зовниж байгаагаа илэрхийлэн Монгол Улсын Засгийн газар хурдан морины уралдаан нь хүүхдүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд аюултай гэдгийг санан, жилийн аль ч улиралд 18-аас доош насны хүүхдийг хурдан морь унаж уралдах, бэлтгэл, сунгаанд оролцуулахгүй байхыг хуулиар баталгаажуулж,

⁸² ХЭҮК, Эрх зүйн судалгааны төв, ОУХБ, НҮБ-ын Хүүхдийн Сан. 2015.Хурдан морины хаврын уралдаан ба хүүхдийн эрх. Улаанбаатар

хэрэгжилтийг хангаж ажиллахад шаардлагатай арга хэмжээг яаралтай авахыг Хорооноос шаардсан байна.⁸³

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООН ДАХЬ ХҮҮХДИЙН ОРОЛЦОО

181. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, дарамт, хүчирхийлэл, үл хайхрах байдал, мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй бөгөөд эрхийг нь зөрчсөн эцэг эх, асран хамгаалагчаас хууль ёсны харилцаагаа зохих журмын дагуу зогсоох, таслах, сэргээх эрхтэй. Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй мөн өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй.⁸⁴ Хүүхэд нийгмийн амьдралд оролцох, өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох; өөрийн бүтээсэн зохиогчийн эрх, шинэ бүтээл, оновчтой саналыг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, түүний үр шимийг хүртэх; эд хөрөнгийг өмчлөх, өвлөх, хуулиар олгогдсон эрхээ эдлэх, шаардах зэрэг хууль тогтоомжоор баталгаажсан эрхтэй юм.⁸⁵

182. Хүүхэд өөрийн үзэл бодлыг гэр бүл, сургуулийн орчинд чөлөөтэй илэрхийлэх, өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцох боломж, нөхцөл байхгүйгээс хүүхдийн оролцоог хангах дадал нийгмийн аль ч орчинд бэхжээгүй байна. Өнөөгийн хүүхэд хамгааллын тогтолцоонд хүүхдийн оролцоо нь хамгийн сул талбаруудын нэг байгаа бөгөөд хүүхэд хамгааллын үйл ажиллагаа төлөвлөх, төсөвлөхөд хүүхдийг огт оролцуулдаггүй. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн өмнөөс Хамтарсан баг, ТХБ, НЦҮТ, багш, цагдаа зэрэг үйлчилгээ үзүүлэгч талууд шийдвэр гаргаж байгаа нь хүүхдийн үзэл бодлыг сонсох, насанд нь тохирсон шийдвэр гаргах нөхцөл боломжоор хангах талаар наад захын ойлголт мэдлэг байхгүйтэй холбоотой юм. Зарим аймаг, дүүргийн Хүүхдийн төлөө зөвлөлд хүүхдийн төлөөллийг оруулж байгаа нь зөвхөн бэлэг тэмдэг төдий байдалтай байна.

183. Судалгааны явцад ТББ-ын хамгаалах байранд байгаа хүүхдүүдээс сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нь гэр бүлдээ эргэн очих эсвэл асрамжийн газар шилжих хүсэлтэй эсэхийг нь асуун харьяа дүүрэг, аймгийн ГБХЗХХ болож Хамтарсан багт нь уламжилж хэлсэн боловч хүүхдийн хүслээр асуудлыг шийдээгүйгээс тухайн хүүхэд 2 жилийн дотор 4 өөр хамгаалах байранд нийт 8 удаа очсон байна. Сүүлийн удаа буюу 8 дахь удаа тухайн хүүхдийг анхлан авсан ТХБ-ны ажилтан Хамтарсан багийн гишүүнтэй хамт хүүхдийг гэрт эргэлтээр очихдоо авчирсан байна.

184. НҮБ-ын ХЭХ-ны Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн тухай 12 дугаар (2009) Ерөнхий зөвлөмжид хүүхэд хамгааллын тогтолцоонд хүүхдийн оролцоог хэрхэн хангах талаар тусгайлан заасан байна. Үүнд: хүүхэд хамгааллын бодлого, эрх зүйн баримт бичиг боловсруулах, төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг төлөвлөхөд хүүхдийн оролцоог хангах тэр дундаа хүчирхийлэлд өртсөн, хараа хяналтгүй хүүхдийн дуу хоолой, үзэл бодлыг тусгаж ажиллахыг; хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчлийг мэдээлэх, хариу үйлчилгээний бүхий л шатанд хүүхдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг бүрдүүлэх; хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх хүүхдэд ээлтэй механизмыг

⁸³ ОУХБ Шинжээчдийн хороо. 2021. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцийн хэрэгжилтийн зөвлөмж.

https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:13100:0::NO::P13100_COMMENT_ID:3998161

⁸⁴ Хүүхэд хамгааллын тухай хууль (2016) <https://www.legalinfo.mn/law/details/11710>

⁸⁵ Хүүхдийн эрхийн тухай хууль (2016) <https://www.legalinfo.mn/law/details/11709>

бүрдүүлэх; хүүхэд хамгааллын үйлчилгээний бүх шатанд хүүхэд хүчирхийллээс ангид, эрүүл, аюулгүй амьдрах эрхтэйг хүүхдэд тогтмол мэдээлэх зэргийг зөвлөсөн байна.⁸⁶

185. Хүүхэд хамгааллын үйлчилгээний явцад хүүхдийн оролцоог хангах талаар НҮБ-ын үндсэн хэл дээр байгааг арга зүй, гарын авлага, эх сурвалжийг судлан Монголын нөхцөл байдалд уялдуулан, нэн шаардлагатай мэдээллийг эх хэлнээ буулган хүүхэд хамгааллын тогтолцооны үүрэг хүлээгч, үйлчилгээ үзүүлэгч талуудад хүргэх, сургах, хэрэгжүүлэх замаар үйлчилгээг хүүхэд, гэр бүлд хүртээмжтэй болгох шаардлагатай байна.⁸⁷ Судалгаанд оролцсон 14-18 насны хүүхдүүдийн хувьд бид өөрсдийгөө аливаа эрсдэлээс хамгаалж чадна. Ингэхийн тулд бидэнд мэдлэг, мэдээлэл хамгийн чухал гэдгийг онцолж байлаа. ЕБС-ийн хөтөлбөрт хүүхдийн амьдрах ухаан, зөөлөн чадвар, таван туулах чадварт сургах хөтөлбөр хангалтгүй бөгөөд сургуулиас гадуурх үйл ажиллагаагаар эдгээр чадварыг эзэмших боломжтой байна. Гэтэл эдгээр чадварыг сургах сургалтын төв, сургууль нь төлбөртэй байдгаас хүүхэд бүрт хүртээмжтэй биш юм.

ХҮҮХЭД БА ХУУЛЬ

186. Хүүхэд хууль зөрчсөн тохиолдолд хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог, зөрчлийн нийгмийн хор аюулын шинж тэмдэг, хохирол зэргийг нь харгалзаж “Эрүүгийн гэмт хэрэг” эсвэл “Зөрчлийн хэрэг” гэж ангилан тусгайлсан процессоор шийдвэрлэдэг. Эрүүгийн болон Зөрчлийн хуулиар субъектийн нас, түүний үйлдсэн ямар үйлдлийг “гэмт хэрэг” эсхүл “зөрчил”-ийн хэрэг болох талаар тусгайлан тодорхойлон заасан бөгөөд ийнхүү тодорхойлоогүй аливаа үйлдэл, эс үйлдлийг “гэмт хэрэг” эсвэл “зөрчлийн хэрэг”-т тооцохгүй, төсөөтэй хэрэглэхийг хатуу хориглодог онцлогтой. Өөрөөр хэлбэл “Эрүүгийн хууль” эсвэл “Зөрчлийн хууль”-д тусгайлан заагаагүй тохиолдолд хүүхдэд аливаа хэлбэрийн хариуцлага хүлээлгэхгүй юм.

187. Хэрэв хүүхдийн хууль зөрчсөн үйлдэл нь “эрүүгийн хууль” эсвэл “зөрчлийн хууль”-д тусгайлан заагаагүй хэдий ч бусдад хохирол учруулсан, бусдын эрх ашиг сонирхлыг хөндсөн тохиолдолд хүүхдийн эцэг, эх, АХХД хариуцлага хүлээх, хохирлыг барагдуулах үүрэгтэй. Энэ харилцааг “Иргэний хууль” болон “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулдаг онцлогтой.

188. Хүүхэд аливаа гэмт хэрэг, зөрчилд холбогдох эсхүл гэмт хэрэг зөрчлийн хохирогч болох тохиолдолд Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “гэмт хэргийн шинжтэй үйлдэл” байж болзошгүй тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу Зөрчлийн тухай хуульд заасан “зөрчлийн шинжтэй үйлдэл” байх тохиолдолд, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар тус тус хянан шийдвэрлэнэ.

189. Иргэний хэрэг маргаан тэр дундаа гэр бүл цуцлалтын үед хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хамгийн их хөндөгддөг бөгөөд энэ ажиллагаанд хүүхдийн эрхийг хэрхэн хангах нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тодорхойлогддог. Тиймээс хүүхэд хамгааллын тогтолцоо нь эдгээр процессын хуулиар хүүхэдтэй холбоотой аливаа маргаан, хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэгдэж байгаа үед хэрэгжиж байх учиртай.

⁸⁶ Committee on the Rights of the Child. 2009. *General Comment No.12 The Rights of the Child to be heard.*

⁸⁷ Keeping Children Safe Coalition. Child Participation in Child Protection. <https://codeofgoodpractice.com/wp-content/uploads/2019/03/KCS-Childrens-Participation-in-Child-Protection-Tool-4.pdf>

Энэ талаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2.5–д заасныг үндэслэн хэрэгжүүлэх боломжтой.⁸⁸

190. **Эрүүгийн хэрэгт холбогдсон хүүхэд.** Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж 2017 оноос хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн бөгөөд тус хуулиар гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тодорхойлж байна. Улсын хэмжээнд 2020 онд насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг 811 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 257 хэргээр буюу 24,1 хувиар буурчээ. Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэм хэргийн 631 буюу 77,8 хувийг хөнгөн, 180 буюу 22,2 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, 68,8 хувь нь Улаанбаатар хотод, 31,2 хувь нь орон нутагт тус тус бүртгэгдсэн. Хэдийгээр насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэргийн тоо буурсан боловч хүчиндэх гэмт хэрэг 25 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн хэрэг 28,6 хувиар тус тус өссөн. Бүртгэгдсэн гэмт хэргийн 32,4 хувь нь гэр, орон сууцанд, 28,2 хувь нь гудамж талбайд үйлдэгдсэн. Улсын хэмжээнд 2020 онд гэмт хэрэгт 990 хүүхэд холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 366 буюу 27,0 хувиар буурсан. Холбогдогчдын 105 буюу 10,6 хувь нь эмэгтэй, 885 буюу 89,4 хувь нь эрэгтэй хүүхэд байна. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийн 489 буюу 49,3 хувь нь суурь, 322 буюу 32,5 хувь нь бага боловсролтой байна.

191. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 6.2-д 14-16 насны этгээд 12 төрлийн гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр, гэмт хэрэг үйлдэх үед 16 насанд хүрсэн бол бүх төрлийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан. Гэмт хэргийг нийгмийн хор аюул, учруулах хор уршиг зэрэг шинжээр нь хөнгөн болон хүнд гэж ангилдаг бөгөөд 14-16 насны этгээдийн үйлдсэн гэх 12 төрлийн гэмт хэргийн 31 төрлийн зүйлчлэл дээр үзэхэд 11 зүйлчлэл нь хөнгөн бөгөөд хохирол шаардахгүй гэмт хэрэгт хүүхдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулжээ. Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу.


192. Хүүхэд эдгээр 31 төрлийн гэмт хэргийг үйлдсэн байж болзошгүй гэсэн гомдол, мэдээлэл ирмэгц хийгдэх ажиллагаа нь насанд хүрсэн хүн дээр хийгдэх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас ямар ялгаатай байгааг хэрэг хянан шийдвэрлэх үе шат бүр дээр тусгайлан схемчилж үзүүлээ. Гэмт хэргийн мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд (ЭХХШТХ) заасны дагуу нийт 6 үе шатны дагуу эрх бүхий этгээд хийж, хянан шийдвэрлэнэ.

193. Нэгдүгээр үе шат буюу Гомдол мэдээлэл шалгах: Гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл цагдаагийн байгууллагад ирмэгц 5 хоногийн дотор мөрдөн шалгах ажиллагаа явуулна. Тус ажиллагааны явцад тухайн хэрэгт холбогдсон байж болзошгүй этгээдээс “гэрч”-ийн мэдүүлэг авч улмаар гэмт хэргийн шинжтэй байна гэж үзвэл мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлнэ. “Гэрч”-ээс мэдүүлэг авах үед ЭХХШТХ-ийн 25.3 дугаар зүйлийн 25.3.2-д *“Арван найман насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахад түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгана”*.

⁸⁸ Хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэх, хамгаалах талаар Монгол Улсын хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд тухай үйлчилгээ, үйл ажиллагаа, арга хэмжээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болно.

194. Ярилцлагын явцад уг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдээс “гэрч” гэж мэдүүлэг авдаг тул өмгөөлөгчөөр зайлшгүй хангах шаардлагагүй, зарим тохиолдолд хүүхэд гэж мэдэлгүй шууд гэрчийн мэдүүлэг авдаг бөгөөд шалгалтын явцад 18 нас хүрээгүй байх тохиолдол гардаг мөн энэ үед гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн биед үзлэг, нэгжлэг хийх тохиолдол түгээмэл тул сэжигтэн, яллагдагч гэдэг статустай болоогүй байдаг тул шууд л нэгжлэг хийдэг зэрэг нь насанд хүрсэн хүнтэй яг адилхан байдлаар гомдол мэдээллийг шалгах ажиллагаа явагддаг болох нь ажиглагдсан.


График 14: 1-р үе шат, Гэмт хэргийн гомдол мэдээлэл шалгах ажиллагаа



195. Хоёрдугаар үе шат буюу Хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулах: Гэмт хэргийн талаар гомдол, мэдээллийг шалгаж дуусаад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзвэл Хэрэг бүртгэлийн ажиллагааг 1 сар явуулдаг. Хүүхэд тухайн гэмт хэрэг үйлдсэн гэх нөхцөл байдал тогтоогдсон бол мөрдөгч “яллагдагч”-аар татах саналаа прокурорт

хүргүүлнэ. Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдэнэ. Энэ үе шатанд хүүхдийг хэрхэн оролцуулах талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй, нэг сарын турш “гэрч” гэсэн статустай уг ажиллагааны явцад оролцоно.

График 15: 2-р үе шат, Хэрэг бүртгэлийн ажиллагаа




196. Гуравдугаар үе шат буюу Мөрдөн байцаах ажиллагаа: Хэрэг бүртгэлийн ажиллагаа дуусаж эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэнээс хойш хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл хэргийн талаар нотолбол зохих байдлыг тогтоох зорилгоор явуулж байгаа ажиллагааг Мөрдөн байцаалтын ажиллагаа гэнэ. Мөрдөн байцаалтын ажиллагааны хугацаа нь “хөнгөн” гэмт хэрэг байвал 14 хоног “хүнд” гэмт хэрэг байвал нэг сарын хугацаанд явуулна. Яллагдагчаар татах тухай тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг “сэжигтэн” гэх ба энэ үе шатнаас эхлэн **“сэжигтэн” хүүхдэд хамааралтай хамгааллын** зохицуулалтууд үйлчилж эхэлдэг онцлогтой.

197. Энэ үе шатанд хүүхэдтэй холбоотой дараах ажиллагааг тусгайлан журамласан. Үүнд:

- Яллах дүгнэлт танилцуулахаар дуудахдаа “Өсвөр насны яллагдагчийг түүний хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан дуудна”.
- Мэдүүлэг авахад Өмгөөлөгч заавал оролцуулах, шаардлагатай гэж үзвэл багш эсхүл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтанг оролцуулах

- Хувийн байдлыг тогтоохдоо төрсөн он сар өдөр, амьдралын нөхцөл, хүмүүжил, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл, хамтран үйлдэгч, ухаан санааны хөгжлийг зайлшгүй тогтоосон байхыг шаардана.

График 16: 3-р үе шат, мөрдөн байцаах ажиллагаа



198. Мөрдөн байцаах ажиллагааны явцад “Мэдүүлэг авах”-аас бусад ажиллагаанд хүүхдийг хэрхэн оролцуулах, таслан сэргийлэх, баривчлах ажиллагаанд насанд хүрэгчтэй адилхан процесс явагддаг. Ярилцлагын явцад хүүхдийн хувийн байдлыг тогтоох болон мэдүүлэг авах ажиллагааны явцад хүүхдийн эрх хамгийн их зөрчигддөг, голдуу эрэгтэй мөрдөгч нар байдаг тул хүчирхийлэлтэй холбоотой гэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог, хүүхдийн нас биеийн сэтгэхүйн онцлог зэргийг харгалздаггүй, тухайн ажиллагааг эмэгтэй мөрдөгчөөр явуулах боломжгүй, ямар үед хүүхдийг баривчлах эсвэл баривчилж болохгүй тухай нарийвчилсан зохицуулалт байдаггүй тул “оргон зайлах” эсвэл “ажиллагаанд саад болох” гэсэн үндэслэлээр “баривчлах” ажиллагаа хийгддэг талаар онцолж байлаа.


199. Сэжигтэн хүүхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “саад” болох үндэслэл байвал тус хуулийн 18.2-д заасан дараах зүйлийг баримтлахгүй гэж заасан. Үүнд:

- Өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах
- Өсвөр насны шүүгдэгчтэй харьцахдаа түүний нэр төрийг хүндэтгэн харьцаж, насны онцлогийг харгалзан хүмүүжих, алдаагаа засах боломж олгохыг анхаарах
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулах
- Шуурхай, богино хугацаанд явуулах нөхцөлийг шүүх хангах

200. Мөрдөн байцаах ажиллагаа дууссан, нотлох баримтаа хангалттай бүрдүүлсэн гэж мөрдөгч үзвэл холбогдох саналыг хавтаст хэргийн хамт 3 хоногийн дотор прокурорт хүргүүлж, прокурорын хяналтад шилжүүлнэ.

201. Дөрөвдүгээр шат буюу Прокурорын хяналт: Мөрдөн байцаах ажиллагааг хуульд заасны дагуу явуулсан эсэх, хэргийн шинжийг бүрэн нотолсон эсэх, яллагдагчийн гэм буруутай үйлдлийг тогтоосон эсэх зэргийг Прокурор хянаж үзээд ажиллагаа бүрэн хийгдсэн байна гэж үзвэл хэргийг “Эрүүгийн шүүх”-д шилжүүлэх шийдвэр гаргадаг. Хэргийг шүүхэд шилжүүлэхдээ яллах дүгнэлт үйлдэх бөгөөд энэ үед тухай хэрэгт холбогдсон хүүхдийг “яллагдагч” гэж нэрлэнэ. Яллагдагч хүүхдэд яллах дүгнэлт танилцуулахдаа *Хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан дуудах бөгөөд өмгөөлөгчийг заавал байлцуулна.*

График 17: 4-р үе шат, Прокурорын хяналт




202. Прокурорын хяналтын явцад холбогдогч хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд заасны дагуу хангасан эсэхэд хэргийн оролцогч, өмгөөлөгчид гомдол гаргах, хуулийн шаардлагыг хангаагүй бол тухайн ажиллагааг хүчингүй болгох зэрэг мөрдөгчийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг энэ үе шатанд гаргах боломжтой байдаг. Мөн энэ үе шатны нэг онцлог нь хэргийн оролцогчид хэргийн материалтай бүхэлд нь танилцаж нотлох эсвэл цагаатгах нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн эсэхийг мэдэх боломжтой болдог.


203. Ярилцлагад оролцсон прокурор нарын зүгээс хүүхдийн эрхийг хангасан эсэх талаар хавтаст хэрэгт цугларсан баримтын хэмжээнд хянадаг бөгөөд зарим тохиолдолд хэргийг прокурорт явуулахын тулд өмгөөлөгч байлцсан гэж нөхөн гарын үсэг зуруулах тохиолдол байсаар байна гэдгийг онцоллоо. Прокурор мөрдөн байцаах ажиллагаа хангалттай явуулсан гэж үзэж хэргийг Эрүүгийн шүүхэд шилжүүлсний дараа шүүхээс тухайн хэргийг “шүүхээр хэлэлцүүлэх” тухай шийдвэр гардаг.

204. Тавдугаар шат буюу анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх: Хэргийн оролцогч, өмгөөлөгч нарын зүгээс гаргасан хүсэлт, гомдлыг прокурорын шатанд хангаагүй, мөрдөн байцаалтын ажиллагааг дутуу явуулсан гэж үзвэл хэргийг шүүхэд шилжиж ирсний дараа “Урьдчилсан хэлэлцүүлэг явуулах” хүсэлтийг шүүхэд гаргаж мөрдөн байцаалттай холбоотой нэмэлт ажиллагаа хийлгэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэдэг.

График 18: 5-р үе шат, Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх



205. Анхан шатны журмаар хүүхэд холбогдсон хэргийг хянан шийдвэрлэхдээ “хаалттай” явуулах ба хэрэв хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол “нээлттэй” явуулж болно. Анхан шатны шүүхээс хэргийг хүлээн аваад гэм буруутай гэж үзвэл “шийтгэх тогтоол”, гэм буруугүй гэж үзвэл “цагаатгах тогтоол” эсвэл хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг. Шүүх гэм буруутай гэж үзвэл шүүгдэгчид хариуцлага хүлээлгэх бөгөөд анх удаа “хөнгөн” гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулдаг ба түүнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина. Хэрэв шүүгдэгч тогтоосон хязгаарыг зөрчвөл ялыг биечлэн эдлүүлнэ.



- Анхан болон Давж заалдах шатны шийдвэр, магадлалыг хэвээр үлдээх

- Хэргийг хэрэгсэхгүй болгох
- Хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах
- Шийдвэрийг өөрчлөх
- Гомдлыг хэлэлцэхгүй орхих гэсэн шийдвэрийн аль нэгийг гаргана.

208. Гэмт хэргийн талаар гомдол мэдээлэл хүлээн авах, шалгах ажиллагаанд сэжиглэгдэж байгаа хүн нь хүүхэд байх тохиолдолд хэрхэн шалгах талаар зохицуулалт байхгүй, “гэрч” гэж мэдүүлэг авдаг нь тухайн хэргийг мөрдөн шалгах ажиллагааны хамгийн чухал хэсэгт хүүхэд хамгаалал огт хэрэгжихгүй байна. Эрүүгийн хэрэгт холбогдсон хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсны төлөөлөгч, оролцох боломжгүй бол сурган хүмүүжүүлэгч эсвэл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтан оролцохоор хуульчилсан боловч зарим ажиллагаанд зөвхөн **“хууль ёсны төлөөлөгч”** гэж зохицуулсан. Гэтэл хүүхэдтэй ашиг сонирхлын зөрчилтэй, хүүхдийг хамгаалах боломжгүй хууль ёсны төлөөлөгчийн оронд хүүхдийн эрх ашгийг хамгаалах боломжтой бусад субъект оролцох бололцоогүй болгож байгааг засах шаардлагатай байна.

209. Эрүүгийн хэрэгт холбогдсон хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрд хүүхдийн эрхийг хамгаалах талаар зайлшгүй оруулах хэрэгтэй. Мөрдөн байцаалтын ажиллагаа эхлэхээс өмнө буюу сэжигтнээр тооцогдохоос өмнө хийгдэх хэрэг бүртгэлд, мөрдөн шалгах ажиллагаанд хүүхдийг хэрхэн оролцуулах, хувийн байдлыг тогтоох ажиллагааны явцад насанд хүрээгүй хүүхдийг хэрхэн хамгаалах, эсрэг хүйсийн алба хаагч нар холбогдогч хүүхэдтэй холбоотой ажиллагаа хийх, мэдүүлэг авах зэрэг нь мөн л хүүхэд хамгааллын явцад гарч байгаа ноцтой зөрчлийн нэг юм.

210. Хохирогч, холбогдогч эмэгтэй болон эрэгтэй хүүхдээс /ялангуяа хүчингийн гэмт хэргийн үед/ мэдүүлэг авах ажиллагааг зайлшгүй ижил хүйсийн алба хаагчаар гүйцэтгүүлэх, энэ чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх шаардлагатай байна. Ялангуяа эмэгтэй алба хаагч байдаггүй, ажилладаг эмэгтэй алба хаагчид нь даргын туслах, тоон мэдээлэл гаргах зэрэг тухайн алба нэгжийн бичиг хэргийн ажлыг хийдэг дүр зурагтай байдаг нь хэд хэдэн ярилцлагын явцад дурдагдсан.

211. ЦЕГ-ын “Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын талаар” гаргасан тоон мэдээлэл нь УЕП болон ШЕЗ-ийн тоон мэдээллийн суурь өгөгдөлтэй хэрхэн нийцдэг талаар судлах боломжгүй байх тул улсын хэмжээнд хүүхэд холбогдсон эрүүгийн хэрэгт зөвхөн мөрдөн байцаалтын ажиллагаанаас гадна бусад бүх үе шатанд хэрхэн хангагддаг талаар дүгнэлт хийх боломжгүй байна.

212. **Эрүүгийн хэрэгт хохирогчоор тогтоогдсон хүүхэд.** Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт Хүүхдийн эсрэг гэмт хэргийн талаар зүйлчилсэн байдаг.⁸⁹ Мөн бусад төрлийн хүчиндэх, хулгайлах, залилах, хүний биед гэмтэл учруулах зэрэг 8 төрлийн гэмт хэргийн улмаас хүүхэд хохирсон гэм буруутай этгээдэд ногдуулах ялыг хүндрүүлэхээр зохицуулсан. Тэр дундаа 14 насанд хүрээгүй буюу “бага нас”-ны хүүхэд хохирогч болсон 6 төрлийн гэмт хэргийг үйлдсэн этгээдийн ялыг хүндрүүлэх бүрэлдэхүүнд оруулсан. 18 насанд хүрээгүй хохирогчийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хууль ёсны төлөөлөгчөөр томилж хуульд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Мөрдөгч нь 18 насанд хүрээгүй хохирогчийг түүний хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан дуудан ирүүлж хохирогчийг мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулахаар дуудан ирүүлнэ.

⁸⁹ Үүнд (i) хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, (ii) хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах, (iii) хүүхдийг хаях төөрүүлэх, тэнүүлчлэлд хүргэх, (iv) хүүхдээр гуйлга гуйлгах, хүүхэд солих, (vi) хүүхэд худалдах, (vii) хүүхэдтэй хэрцгий харьцах, (viii) хүүхдэд садар самууныг сурталчлах, (ix) хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, болон (x) хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогддог.

213. Хохирогчийн хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “мэдүүлэг өгөх” нь хэргийг үнэн зөв, бодитой тогтооход хамгийн чухал нөлөө үзүүлдэг. Мэдүүлэг өгөх явцад насанд хүрсэн хохирогчоос ялгаатай байдлаар оролцдог:

- I. **Арван найман насанд** хүрээгүй хүнээс мэдүүлэг авахын өмнө түүнд хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн чухлыг тайлбарлана.
- II. **Арван зургаан насанд** хүрээгүй гэрч, хохирогчид санаатайгаар худал мэдүүлэг өгвөл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулахгүй.
- III. Арван найман насанд хүрээгүй **гэрчээс** мэдүүлэг авахад түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгана.
- IV. Өмгөөлөгчийг заавал оролцуулах шаардлага тавигдаагүй.

214. 18 насанд хүрээгүй хохирогчтой холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх бүх шатны шүүх хуралдааныг хаалттай явуулна. 18 насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно.

215. **Иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч хүүхэд.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (ИХШХШТХ) 24 дүгээр зүйлийн 24.2-д “Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны иргэн өөрийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо шүүхэд хамгаалах эрхтэй” гэж зохицуулсан. Шүүх хуулийн 24.2-т заасан иргэнд хамаарагдах хэрэгт түүний эцэг, эх, харгалзан дэмжигчийг татан оролцуулах үүрэгтэй. Харин насанд хүрээгүй иргэнтэй холбоотой дараах хэргийг хянан шийдвэрлэхдээ түүний эцэг, эх, харгалзан дэмжигчийг оролцуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Үүнд:

- I.Өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран зарцуулах;
- II.Өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцэл хийх;
- III.Эдгээр орлогыг банк, зээлийн байгууллагад хадгалуулах.

216. Иргэний хуулиар 7-оос 14 хүртэлх насны этгээд /иргэний эрх зүйн зарим чадамжтай/-ийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч шүүхэд хамгаална. ИХШХШТХ-аар тодорхой тохиолдолд хүүхэд нэхэмжлэгч, хариуцагч байж болохоор хуульчилсан боловч шүүхийн цахим програмд /Иргэн-2014/ энэ төрлийн хэргийг ангилан бүртгэдэггүй. Ярилцлагад оролцсон шүүхийн ажилтан, шүүгч нар энэ төрлийн хэрэг хянан шийдвэрлэгддэггүй талаар дурдсан. Харин гэр бүл цуцлалт, хүүхдийн асрамж тогтоох хэрэг маргаан нь хамгийн их хүүхдийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгддөг маргаанд оруулна гэжээ.

217. Энэ төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэсэн байдлыг судлахад шүүхийн цахим програмд /Иргэн-2014/ гэр бүл цуцалтын хэрэг маргааны талаар бүртгэл хийхдээ хэдэн хүүхдийн, ямар хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн, хэрхэн шийдвэрлэгдсэн талаар нарийвчилсан бүртгэл хийгддэггүй. Монгол Улсын дээд шүүхийн 2017.12.25 өдрийн 03 дугаар “**Гэр бүлийн холбогдолтой эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудал**” зөвлөмжөөр хүүхдийн эрхтэй холбоотой хэд хэдэн зохицуулалтын талаар аргачлал олгожээ:

- I. Харин шүүх гэрлэлтийг цуцалж, хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээж буй явдал нь тусдаа амьдрах болсон эцэг, эхийн хэнтэй нь тухайн хүүхэд **байнга оршин суухыг** тодорхойлж, **хүүхдийн амьдрах газрыг тогтоож байна** гэсэн үг юм.

- II. Хүүхэд нь гэр бүлийн эрх зүйн маргааны объект болж буй ч тухайн харилцааны бие даасан субъект учир тухайн маргааныг хянан шийдвэрлэх гол нөхцөл нь хүүхдийн өөрийнх нь эрх ашиг болно.
- III. Гэрлэлтээ цуцлуулж буй гэрлэгчдийн хүүхэд эцэг, эхийнхээ хөрөнгөөс тэдгээрийн адил тэнцүү хувааж авах эрхгүй бөгөөд шүүх тухайн маргааныг хянан шийдвэрлэхэд хүүхдийн эрх ашгийг харгалзан үзэх л үүрэгтэй болохоос бус гэрлэгчдийн эд хөрөнгийг хүүхдүүдэд нь тэнцүү хуваадаг нь эрх зүйн хувьд алдаатай болно.

218. Дээрх зөвлөмжийн дагуу хянан шийдвэрлэгдсэн хэрэг маргаан байдаг гэх боловч гэр бүлийн хэрэг маргаан нь хаалттай хянан шийдвэрлэгддэг тул бодит байдалд хэрхэн хэрэгжиж байгаа баримтыг олсонгүй. Цаашлаад дээрх зөвлөмж нь шүүхийн хэрэглээнд нэвтэрч хэрэглэгдвэл хүүхдийн асрамжийг тогтоох, өмчлөх эрхэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж судлаачийн хувьд дүгнэж байна.

219. **Зөрчлийн хэрэгт холбогдогч хүүхэд.** 14-16 насны хүн дараах төрлийн зөрчил үйлдсэн бол түүнд шийтгэл хүлээлгэнэ.

- I. Олон нийтийн газарт мансуурсан байдалтай биеэ авч явах
- II. Олон нийтийн газарт, эсхүл орон байранд танхайрах
- III. Жагсаал цуглааныг зохион байгуулагч, оролцогч зэвсэг, хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодис, орчин тойрон, хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц аливаа зүйл, амьтан авч явсан бол
- IV. Хулгайлах
- V. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол

220. Дээрх төрлийн зөрчлөөс бусад төрлийн зөрчлийг үйлдсэн 16 насанд хүрсэн бол шийтгэл хүлээлгэнэ. Эрх бүхий албан тушаалтан арван найман насанд хүрээгүй холбогдогч, хохирогчийн эцэг, эх, АХХД-ийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна. 18 насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно. 18 насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгч, шаардлагатай тохиолдолд сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны аль нэгийг байлцуулна.

221. 18 насанд хүрээгүй хүнээс авах мэдүүлгийг 1 цагийн хугацаагаар тасралтгүй явуулж болно. Мэдүүлгийг 1 цагаас илүү хугацаагаар явуулах бол 30 минутын завсарлага авна. Нэг удаагийн мэдүүлэг авах нийт хугацаа 2 цагаас илүүгүй байна. Арван найман насанд хүрээгүй оролцогчид зөрчлийн хэргийг танилцуулахад түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчийг оролцуулна. Зөрчлийн тухай хуулиар 14-18 насны хүний хувийн байдал, зөрчлийн шинж, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдлыг харгалзан шийтгэлээс чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

222. **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дахь хүүхдийн эрх.** Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг 2017 онд хүчин төгөлдөр болсон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тодорхойлсон.

Хүснэгт 11: Шүүхээс өсвөр насны хүнд оногдуулсан ял, хариуцлага

№	2018	2019	2020
---	------	------	------

1	Хянан шийдвэрлэсэн (ЭХ-12) ⁹⁰ хэрэг	314	403	369	
2	Хянан шийдвэрлэсэн (ЭХ-12) хэрэгт холбогдсон хүн	381	454	419	
3	Хянан шийдвэрлэсэн (ЭХ-16) ⁹¹ хэрэг	7	6	6	
4	Хянан шийдвэрлэсэн (ЭХ-16) хэрэгт холбогдсон хүн	7	7	10	
5	Ял шийтгүүлсэн (ЭХ-12) өсвөр насны хүн	31	19	6	
6	Ял шийтгүүлсэн (ЭХ-16) өсвөр насны хүн	0	0	0	
7	Хорих ял шийтгүүлсэн (ЭХ-12) өсвөр насны хүн	31	19	6	
8	Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн (ЭХ-12) насанд хүрэгч	51	95	73	
9	Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн (ЭХ-16) насанд хүрэгч	4	0	0	
10	өмнө нь ял шийтгүүлж байсан өсвөр насны хүн	2	2	0	
11	Нийтэд тустай ажил хийх	0	0	0	
12	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	0	0	0	
13	СХТБ-д хорих ял эдэлсэн	23	9	4	
14	Шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулсан	8	7	0	
15	Хөнгөн хэрэгт хорих ял	6 с-3 жил	6	9	0
		3-5 жил	7	0	3
16	Хүнд хэрэгт хорих ял	1-3 жил	8	1	1
		3-5 жил	0	2	1
		5-8 жил	9	3	2
		8-10 жил	1	3	0
		10-15 жил	0	4	0
17	Хорих+ эрх хасах нэмэгдэл	14-15 настай	5	5	1
		16-17 настай	25	14	7
10	Боловсрол: сурагч	25	8	5	

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2021 оны 06 дугаар сард ирүүлсэн мэдээлэлд

223. Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь өсвөр насны эмэгтэй хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх тусгай нэгжтэй байна. Өсвөр насны хоригдол 18 насанд хүрсэн тохиолдолд ялыг нь хорих ангид шилжүүлэн эдлүүлэх эсэх асуудлаар хоригдлыг арван найман насанд хүрэхээс гурван сарын өмнө сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дарга прокурорт санал гаргах бөгөөд прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ. Ийнхүү шилжүүлсэн хоригдлын эдлээгүй үлдсэн ялыг эдлүүлэх хорих ангийн дэглэмийг прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

224. Шүүх дээр заасан хоригдлын эдлээгүй үлдсэн ялын хугацаа 2 жилээс илүүгүй тохиолдолд түүний хувийн байдал, төлөвшлийг харгалзан сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын даргын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн хорих ялын хугацааг дуусах хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн ял эдлүүлж болно. Өсвөр насны хоригдлын илгээмж авах, түр уулзалт хийх, утсаар ярих тоог хязгаарлахгүй бөгөөд 15 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болно.

⁹⁰ ЭХ-12 гэдэг нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг

⁹¹ ЭХ-16 гэдэг нь Хүүхдийн эсрэг гэмт хэрэг

225. Энэ хэсгийг товч дүгнэвэл Өсвөр насны этгээдтэй холбоотой гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд зөвхөн “хорих ял шийтгүүлсэн” этгээдтэй холбоотой хөнгөвчилсөн зохицуулалт үйлчилж байна. Бусад төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дахь хүүхдийн эрхийн асуудлыг хуулиар огт нарийвчлан зохицуулаагүй байна. Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны этгээдэд хэрхэн хяналт тавих, сургууль, боловсрол эзэмших эрхийг нь хэрхэн хангах, хүүхэд хамгааллын бусад байгууллагатай хэрхэн хамтран ажиллах талаар зохицуулаагүй байна.

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

226. ГБХЗХГ-ын тайлангаар 2019 онд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч 9 хүний 5 (55.6 хувь) нь 14-17 насны хүүхэд байсан байна. Энэ нь 2016 оноос 4, өмнөх онтой харьцуулахад 1-ээр тус тус нэмэгдсэн байна.⁹² Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйлд заасан (хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх) гэмт хэрэгт 2019, 2020 болон 2021 оны эхний таван сарын байдлаар дараах үзүүлэлттэй байна.

Хүснэгт 12: Хүн худалдаалах гэмт хэргийн тоо баримт

Он	Хүн худалдаалах гэмт хэрэг	Хүний наймаа	Бэлгийн мөлжлөг	Албадан хөдөлмөр
2019	Хэрэг бүртгэлд	14	6	2
	Хохирогчоор тогтоосон	65	-	-
	Үүнээс хүүхэд	12	3	1
2020	Хэрэг бүртгэлд	14	9	1
	Хохирогчоор тогтоосон	40	-	-
	Үүнээс хүүхэд	24	6	0
2021	Хэрэг бүртгэлд	3	0	0
	Хохирогчоор тогтоосон	4	-	-
	Үүнээс хүүхэд	4	0	0

Эх сурвалж: Цагдаагийн Ерөнхий Газраас тус судалгаанд зориулж гаргасан мэдээлэл

227. Хүүхдийн эсрэг хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг далд хэлбэрт байдаг учир ЦЕГ гаргасан тоо баримт бодит байдлыг төдийлөн харуулж чаддаггүй байна. Судалгаанд оролцогчдын зүгээс охид бэлгийн мөлжлөгөд, хөвгүүд хөдөлмөрийн мөлжлөгөд өртөх нь элбэг байдаг гэдгийг мэдээлсэн. Монгол Улсын хувьд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын талаар тоон мэдээлэл тогтмол цуглуулдаггүй учир энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлыг судлах боломж хомс бөгөөд АНУ-ын Төрийн департаментаас жил бүр гаргадаг “Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан” хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлыг мэдээлэх гол эх сурвалж болж байна.

⁹² ГБХЗХГ.2020. Монголын хүүхдийн байдал: 2019 оны статистикийн эмхтгэл. Улаанбаатар

228. Хүнийг хил дамнуулан худалдах гэмт хэрэгт насанд хүрэгчид ихэвчлэн хохирогч болдог бол дотоодод үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэрэгт, тэр дундаа бэлгийн мөлжлөгийн хохирогчдын дунд насанд хүрээгүй хүмүүс байдаг байна. Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх иргэдийн ойлголт дутмагаас энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох эрсдэл иргэдийн дунд өндөр байдаг гэдгийг судалгааны оролцогчдын зүгээс онцолж байлаа. Мөн өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оноох ял өндөр харин бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөгийн зохион байгуулсан этгээдэд өгөх ял хөнгөн байдаг нь ял завших нөхцөлийг бий болгодог гэдгийг оролцогчдын зүгээс тусгайлан тайланд оруулж өгөхийг хүссэн юм. Хүн худалдаалах гэмт хэрдээр илэрч байгаа ч шүүхээр шийдвэрлэх явц удаан, прокурорын мэдлэг, туршлага дулимаг учир шүүхээр шийдвэрлэгдэх нь цөөн байна. Мөн өмгөөлөгчид хүүхэд хохирогч болсон кэйс дээр ажиллах сонирхол бага байдаг. Учир нь хүүхдийн өмнөөс эцэг эх, асран хамгаалагч нөгөө талаас мөнгө аваад тохирчихдог гэдгийг ярилцлагад оролцогчдын зүгээс хэд хэдэн удаа хэлж байсан.

229. Судалгааны оролцогч орон нутгаас хүүхдийн эсрэг хүн худалдаалах гэмт болон бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон хүүхдийн талаарх мэдээлэл олдоогүй бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдээлэл, мэдлэг багаас гадна ажиллах арга зүй байхгүй гэдгийг үйлчилгээ үзүүлэгч талууд хуваалцсан юм. Улсын хэмжээнд цөөн хэдэн төрийн бус байгууллага хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод хамгаалах байр, хууль эрх зүйн үйлчилгээ, мэргэжлийн чиг баримжаа олгох, нийгэм эргэн нэгтгэх үйлчилгээг үзүүлж байна. Тус байгууллагуудтай хийсэн ярилцлагаар мэргэжлийн түвшинд, цогц үйлчилгээ үзүүлж байгаа нь сайшаалтай байна. Хүүхдийн эсрэг хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн талаарх хүүхэд хамгааллын тогтолцооны үүрэг хүлээгч талууд төдийлөн ойлголтгүй байгаа тул энэ талаар сургах хэрэгцээ шаардлага байгаа гэдгийг мэргэжлийн ажилтнууд ярилцлагын үеэр дурдаж байсан.

230. **Бэлгийн мөлжлөг:** Хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдлэггүй, өрхийн эдийн засгийн дорой байдлаас болж илүү мөнгө олж сайхан амьдрах хүсэлдээ хөтлөгдөн иргэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болдог бөгөөд охид, эмэгтэйчүүдийн дунд өндөр цалин амласан ажилд хууртагдан бэлгийн мөлжлөгийн хохирогч болох нь цөөнгүй байна. Олон нийт, үүрэг хүлээгч талууд биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн талаар ойлголт дулимаг учир хохирогчийг сайн дураараа биеэ үнэлж, амар хялбар аргаар мөнгө олж байна хэмээн буруутгах хандлага түгээмэл байна. Мөн бага насандаа бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан охид хүн худалдаалах гэмт хэргийн тэр дундаа бэлгийн мөлжлөгийн хохирогч болох нь элбэг байдаг байна. Мөн түүнчлэн, гэр бүл цуцалт, хойд эцэг эхийн харилцаанаас болж хүүхэд насанд хүрч, биеэ даахаасаа өмнө гэрээсээ явдаг нь тэднийг энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдлэгтэй байх нь цагдаагийн байгууллагын хүмүүс. Гэвч биеэ үнэлээд байна гэж бодоод Зөрчлийн тухай хуулиар 100,000 төгрөгөөр торгоод, цаана юу байгааг нарийн судалдаггүй. Бэлгийн мөлжлөгийн хохирогчийн гарыг нь хүлээгүй ч сэтгэл зүйгээр нь хүлээд байгаа шүү дээ. Тийм юмыг бас манай төрийн албаныхан сайн ойлгох хэрэгтэй.

Ганцаарчилсан ярилцлагаас

231. 2021 онд ОУХБ-ын Шинжээчдийн хорооноос насанд хүрээгүй охидыг бэлгийн мөлжлөгийн зорилгоор саун, зочид буудал, массажны газар, караоке баранд худалдаж байгаа талаарх засгийн газрын тайлантай танилцсан бөгөөд эрүүгийн хуулийн 12.3-ыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч, арилжааны зорилгоор

бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн тоо, хэргийн тоо мөн ногдуулсан ял шийтгэлийн төрлөөр нь ангилан явуулахыг Засгийн газраас хүссэн байна.⁹³

232. **Хүүхдийн хөдөлмөр:** Монгол Улсад үндэсний хэмжээний хүүхдийн хөдөлмөрийн судалгаа гурван удаа хийгдсэн бөгөөд хамгийн сүүлийнх нь 2012 хийгдсэн байна. Үүнээс үзэхэд хүүхдийн хөдөлмөрийн өнөөгийн нөхцөлийг тодорхойлсон судалгаа, статистик мэдээлэл дутмаг, цаашлаад хүүхдийн хөдөлмөрийн талаар бодлогын түвшинд оновчтой үйл ажиллагаа явуулах боломжгүй байгааг илтгэнэ. Мөн орон нутгийн түвшинд хөдөлмөр эрхэлснээс болж хүүхэд эрүүл мэнд, амь насаараа хохироход үйлчилгээ үзүүлэгчид хэргийг хянан шийдвэрлэх чадавх сул байна.

233. Хүүхдийн хөдөлмөр нь эдийн засгийн нөхцөл байдал, өрхийн орлого, насанд хүрэгчдийн дундах ажилгүйдэл, боловсролын түвшнээс шууд хамааралтай бөгөөд судалгааны явцад хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн талаар асуухад оролцогч талуудын өгсөн мэдээлэл хурдан морь унаач хүүхдийн асуудлаар хязгаарлагдаж байлаа. Гэтэл хүүхдүүдийн дунд улирлын худалдаа, үйлчилгээний салбарт, машин угаалга, барилга дээр ажиллах нь түгээмэл байна. Мөн эцэг эх, асран халамжлагчийн зүгээс мөнгө олох зорилгоор бусадтай гэрээ хийж хүүхдээ хөдөлмөрлүүлэх тохиолдол гарч байна. Ажил олгогчдын хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэдтэй хөдөлмөрийн гэрээ хийдэггүй мөн цалингийн доод хэмжээнээс багаар тогтоодог байна. Нийгмийн дунд хүүхдийн хөдөлмөрийн талаар мэдлэг хангалтгүй учир хүүхэд хүнд хөдөлмөр эрхэлж байхыг мэдсэн ч мэдээлэхгүй байна.

Эх эцэг нь уяачтай ярьж, гэрээ байгуулаад хүүхдээ сургуулиас гарган хурдан морь унуулахаар явуулан араас нь дүүг нь явуулсан. Хамтарсан багаас хөөцөлдөж явж авчирсан. Одоо гэртээ амьдарч байгаа. Ийм зүйл давтагдаад байгаа айлыг Хамтарсан баг бүртгэл хийж, хянаж ажилладаг.

Бүлгийн ярилцлагаас

234. Сүүлийн жилүүдэд хүүхэд гэр бүлийн хамт өмнөд хөрш БНХАУ-ын хилийн аймгуудад мал маллах, хурдан морь унах, жуулчны баазад зөөгч, урлаг соёлын үзүүлбэр үзүүлэх зорилгоор хил дамнан хөдөлмөр эрхэлж байгаа нь харамсалтай. Мөн түүнчлэн циркийн үзүүлбэрээр олон хүүхэд гадаад улсад ажиллаж байгаа бөгөөд авч явж байгаа багш нь биеэ үнэлэхийг шаардсан, цалин хөлсийг нь өгөөгүй зэрэг асуудлаар хүүхдийн эрхийн байгууллагад гомдол ирж байсан байна. Судалгааны явцад гудамжинд машины үнэртүүлэгч зарж байгаа мөн гуйлга гуйж байгаа хүүхдүүд хөдөлмөрийн мөлжлөгөд өртөж байх магадлалтай гэдгийг оролцогч талуудаас онцолж байлаа. Мөн туслах малчны хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчтайгаа гар аргаар алт олборлож байгаа хүүхдүүдийн нөхцөл байдлыг судлах шаардлагатай байна. Эдгээр хүүхдүүдийн талаар мөн л нэгдсэн тоон мэдээлэл, аж байдлыг нь хянан шалгах механизм хүүхэд хамгааллын өнөөгийн тогтолцоонд үгүйлэгдсээр байна.

235. Монгол Улс ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн 130 болон 182 конвенцид нэгдэн орсон бөгөөд тус конвенцуудын хэрэгжилтийг гурван жил тутамд тайлагнадаг байна. 2021 онд ОУХБ-ын Шинжээчдийн хорооноос хурдан морь унаач хүүхэд гэмтэл бэртэл авч амь насаа алдаж байгаа санаа зовниж байгаагаа илэрхийлэн Монгол Улсын Засгийн газар хурдан морины уралдаан нь хүүхдүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд аюултай гэдгийг

⁹³ ОУХБ Шинжээчдийн хороо. 2021. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцийн хэрэгжилтийн зөвлөмж.

<https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:13100:0::NO::P13100 COMMENT ID:3998161>

санан, жилийн аль ч улиралд 18-аас доош насны хүүхдийг хурдан морь унаж уралдах, бэлтгэл, сунгаанд ажиллуулахгүй байхыг хуулиар баталгаажуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахад шаардлагатай арга хэмжээг яаралтай авахыг Хорооноос шаардсан байна.⁹⁴

236. Иймд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгахад нэн түрүүнд судалгаа, статистикийг тогтмол цуглуулж, бодлого төлөвлөлтөд ашиглаж оновчтой үйл ажиллагаа явуулах хэрэгтэй төдийгүй хүүхдийн хөдөлмөрийн талаар олон нийтийн хандлага, үүрэг хүлээгчдийн чадавхыг бэхжүүлэх шаардлагатай байна. Мөн хүүхэд хилийн гадна, гадаад улс оронд хөдөлмөр эрхлэх болсонтой холбоотойгоор төрийн болон ТББ бусад улс оронтой мэдээлэл солилцох, хамтран ажиллахад чадавх, нөөцийг бэхжүүлэх хэрэгтэй.

237. Энэ бүхнээс дүгнэхэд хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой тоо мэдээлэл тогтмол цуглуулах; эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийн хүүхэд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон тохиолдол авах арга хэмжээг боловсронгуй болгох, нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөлт хийж байх; Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцид нийцүүлэх; үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоог нэмэгдүүлэх; үүрэг хүлээгч талуудын тэр дундаа төрийн ажилтнуудын мэдлэг чадавхыг бэхжүүлэх замаар урьдчилан сэргийлэх, илрүүлэх, холбон зуучлах ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх; хүн худалдаалах гэмт хэргийн талаарх олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна.

⁹⁴ ОУХБ Шинжээчдийн хороо. 2021. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцийн хэрэгжилтийн зөвлөмж.

https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:13100:0::NO::P13100_COMMENT_ID:3998161

5. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ



5. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

5.1 СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн захиалгаар Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцооны өнөөгийн байдлын зураглалыг эрх зүйн орчин, үйлчилгээ, чадавх, хамтын ажиллагаа, хариуцлагатай байдал, хүүхдэд үзүүлэх үйлчилгээний механизм, хүүхдийн амьдрах ухаан, даван туулан чадвар, оролцоо гэсэн дэд сэдвийн хүрээнд Тогтвортой хөгжлийн санаачилга ТББ-ын судалгааны баг гүйцэтгэсэн болно.

Тус судалгааны дүгнэлт, зөвлөмж нь судлаачид, судалгааны баг, захиалагч байгууллагын байр суурь, үзэл бодлыг илэрхийлээгүй бөгөөд зөвхөн чанарын болон тоон судалгааны үр дүн суурилсан болно.

2016 оноос хойш бий болсон эрх зүйн орчин нь хүүхэд хамгааллын тогтолцооны олон харилцааг зохицуулсан шинэ нөхцөлийг бий болгож, хүүхдийн эрх ашгийг хамгаалах албан ёсны үүрэгтэй талуудын ойлголт, хамтын ажиллагааг бэхжүүлж эхэлсэн нь томоохон амжилт болжээ. Эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн хуульчилсан акт, стандартуудыг шинээр гаргаж, түүнийг алхам алхмаар сайжруулах ажил явагдаж байна. Гэсэн хэдий ч хүүхэд хамгааллын тогтолцоонд тулгарч буй бэрхшээлүүд олон байна. Үүнд:

- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг, хууль зөрчсөн хүүхдийн асуудал ХЗДХЯ-ны, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр, эрсдэлд нөхцөл, эмзэг байдлыг хамгаалах асуудал ХНХЯ-ны чиг үүрэгт хамаарч байна. ГХЗУСАЗЗ болон ХНХЯ-ны дэргэдэх хүүхдийн хөгжил, хамгааллын байнгын ажлын хэсгүүд салбар дундын уялдаа, хангах зохицуулалттай байна. Яамд тус тусын чиг үүргийн дагуу хэрэгжүүлж байгаа бодлого, зорилтуудыг хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13.1-д заасны дагуу нэгдмэл стратегиар чиглүүлэн ажиллахгүй байна.
- Хүүхэд, гэр бүлд үйлчлэхээр шинээр бий болгож буй механизм нь ажлын байр, хүний нөөцийг нэмэгдүүлэхгүй, одоо ажиллаж байгаа албан тушаалтны ажил үүрэг дээр нэмж хавсаргах хэлбэрээр шийдсэн. Ингэхдээ ажил, үүргийн хуваарьт нэмэгдсэн үүргийг тусгаж оруулаагүй, цалин урамшуулалгүй, бэлтгэх сургах тогтвортой системгүй байгаа нь хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд үр дүнтэй хөшүүрэг болж чадахгүй байна.
- Хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллага нь гэр бүл, залуучуудын асуудлыг нэмж хариуцах болсноор тус байгууллага хүүхэд, гэр бүлтэй холбоотой бүх асуудлыг хариуцах ёстой гэсэн хандлага бусад салбарын мэргэжилтнүүдэд түгээмэл байна.
- Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв бүх түвшинд хангалтгүй ялангуяа анхан шатанд тогтсон төсөв байхгүй байна. Мөн батлагдсан төсвийн зарцуулалт ил тод бус, үр дүнд суурилсан тайлан байхгүй байна.
- Шилэн данснаас өөр санхүү, төсвийн мэдээллийн эх үүсвэр байхгүй байна. Гэвч шилэн дансанд тавигдсан мэдээлэл хэт ерөнхий, хавсралт материалууд дутуу зэргээс үүдэн хүүхэд хамгааллын зардлын нарийвчилсан мэдээллийг шинжлэх боломжгүй байна.
- Хүүхэд хамгааллын санхүүжилт сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэж байгаа ч 2015 онд ХНХЯ болон НҮБХС-аас боловсруулсан Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал, төсвийн шинжилгээний зөвлөмжид тусгагдсан төсвийн хэмжээнээс бага хэвээр байна.

- Хүүхэд хамгааллын үйлчилгээн дэх төсвийн зардлын зориулалт тодорхой бус байна. Төсвийн болон төсвийн бус зарцуулалт орон нутагт харилцан адилгүй байна. Тухайлбал, Хамтарсан багийн зарцуулалт зарим аймагт хэт бага, зарим аймагт өндөр байна.
- Тухайн салбарт хүний нөөцийн чадавх бэхжүүлэх болон карьер хөгжлийн тогтолцоо тодорхой бус, улс төрийн намын нөлөөнөөс болж хүний нөөц тогтворгүй.
- Мэдээллийн удирдлагын систем байхгүйгээс үйлчилгээ авч байгаа хүүхдүүдийн түүх, нөхцөл байдал тулгамдсан асуудлын талаарх цаг үеийн мэдээллийг үйлчилгээ үзүүлэгч бүх талууд авдаггүй. Тиймээс үр дүнтэй үйлчилгээг хүүхдэд үзүүлж чаддаггүй.
- ТХБ-ны үйлчилгээний нарийвчилсан журам, стандарт байхгүйгээс үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй. Тиймээс хүүхэд бүрийн онцлог, хэрэгцээ таарсан үйлчилгээг үзүүлж чаддаггүй.
- Хүүхэд гэмт хэргийн хохирогч болоход хохирлоо бүрэн барагдуулж, сэтгэл санааны хохирлоо тооцуулж чаддаггүй үлддэг.
- Хүчирхийлэлд өртсөн болон хууль зөрчсөн өсвөр насны хүүхдийн гэр бүл, асран хамгаалагчдад эрсдэлт байдлыг арилгах үйлчилгээ байхгүйгээс хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх үед нөхцөл байдал хэвээр байгаа нь нөхөн сэргээх хариу үйлчилгээний үр дүнг сааруулж, хүүхдийг дахин хохирох болон, давхар эрсдэх нөлөөг нэмэгдүүлж байна.
- Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар тогтмол судалгаа шинжилгээ, мониторинг хийдэггүй.
- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 21,22 дугаар зүйл заасан үүргээ Хүүхдийн төлөө зөвлөлүүд, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, орон нутгийн ГБХЗХБ-ууд биелүүлдэггүй.
- Хүүхэд хамгааллын хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн сангуудад эрсдэлд нөхцөл дэх хүүхдийг бүрэн хамруулаагүй, хамруулсан хүүхэд бүрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг хянах, шинжлэх байдал хангалтгүй байна.
- Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, салбаруудаас цуглуулсан мэдээлэлд нэгдсэн дүн шинжилгээ хийж, бодлогод ашиглах байдал хангалттай биш.

Эдгээрээс улбаалан хүүхдийн эсрэг үл хайхрах хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, үе тэнгийн дээрэлхэлт, мөлжлөгийн шинж бүхий үйлдэл зэрэг хүүхэд хамгааллын зөрчлүүд тулгамдсан асуудал хэвээр байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээ тэгш хүртээмжгүйгээс хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хараа хяналтгүй хүүхэд, шилжин суурьшигч, хөдөлмөр эрхэлж байгаа болон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэд, хууль зөрчсөн хүүхэд хамгааллын үйлчилгээг авах боломж, мэдээлэл хязгаарлагдмал байна.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг хохирогч төвтэй, гэр бүлд чиглэсэн цогц байдлаар хандах хуулийн зохицуулалт сулаас хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг давтан авах мөн хүүхдийг асрамж халамжийн байгууллага, төвд шилжүүлж шийдэх хүсэл анхан шатны нэгжийн ажилтны хандлагад төдийгүй Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт хүртэл шингэн орсон байна.

Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөн, цахим технологи хөгжихийн хэрээр хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хөдөлмөр, бэлгийн мөлжлөгийн хэлбэрүүд өөрчлөгдөн таньж илрүүлэхэд бэрхшээлтэй болж шинэ хэлбэрүүд үүсчэх эрсдэл байна. Хүүхэд хамгааллын тогтолцооны үүрэг хүлээгчдийн хөрвөх чадвар сул цаг үе ялангуяа гамшиг, онцгой байдлын нөхцөл байдалд тохируулан өөрчлөхөд хугацаа алдах зэргээс хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон хариу үйлчилгээг оновчтой, чанар, хүртээмжтэй хүргэх нөхцөл хангалттай бүрдэхгүй байна.

Сүүлийн жилүүдэд төрийн, төрийн бус болон олон улсын байгууллагын зохион байгуулсан урьдчилсан сэргийлэх ажлын үр дүнд олон нийтийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг дээшилж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих, мэдээлэх, хариуцлага шаардах хандлага, дадал нэмэгдэж байна. Цаашид эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан хүмүүжлийн эерэг арга, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, амьдрах ухаан, зөөлөн чадвар, даван туулах чадварт сургах ажлыг тэгш хүртээмжтэй зохион байгуулах хэрэгцээ тулгарч байна. Хүүхэд хамгааллын тогтолцоонд хүүхдийн үзэл бодлыг сонсож, тэдний оролцоог нь бодитой хангах, хүсэл зоригт нийцсэн шийдвэр гаргах механизм байхгүй байна.

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын үед хүүхдийн эмзэг байдал нэмэгдэж ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийн нөхцөл дэх хүүхдийн тоо нэмэгдэх хандлагатай байна. Ковид-19 нөхцөл байдлаас шалтгаалсан нийгэм, эдийн засгийн бэрхшээлээс болж гэр бүлийн доторх маргаан зөрчил нэмэгдэх, эцэг эхийн хүүхдэд тавих хараа хяналт багасах, хүүхэд бэртэх, амь нас хохирох тохиолдол өдөр бүр гарч байгаа нь сэтгэл эмзэглүүлж байна. Ковид-19 цар тахал нь гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын тусламж, яаралтай үйлчилгээний бодлого, чадавх, хамтын ажиллагаа сул байгааг тодоор харууллаа. Нөхцөл байдлаас даруй сургамж авч тогтолцоогоо бэхжүүлэх нь ГБХЗХГ, ХНЯ, ХЗДХЯ-ны үүрэг юм.

Хүүхэд хамгаалал нь албан болон албан бусын нэгдэл төдийгүй олон талын хамтын ажиллагаа, нэгдмэл алсын хараа, зорилгод тулгуурладаг онцлог ухагдахуун бүхий шинэ салбар юм. Иймд хүүхэд хамгааллын тогтолцоонд оролцогч бүх талууд тогтолцооны өнөөгийн байдлыг хамтран шинжилж, дунд хугацааны зорилго, стратегийг ул суурьтайгаар тодорхойлон, нэгдмэл ойлголт, аргачлалаар алхам бүрийг хамтран, төлөвлөх хэрэгцээ байна.

Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрүүгийн хэрэг хянан шалгах ажиллагаа бүрд бүрэн хамгаалж чаддаггүй бөгөөд зарим процесст хүүхэд оролцох тохиолдолд хэрхэн эрхийг нь хамгаалах нь тодорхойгүй байна. Гэмт хэрэгт холбогдсон болон хохирогч хүүхдээс гэрчийн мэдүүлэг авах, бусад мөрдөн шалгах ажиллагааг явуулахад ижил хүйсийн хүн оролцуулдаггүй, оролцуулах боломж байдаггүй. Хохирогч, холбогдогч эмэгтэй болон эрэгтэй хүүхдээс /ялангуяа хүчингийн гэмт хэргийн үед/ мэдүүлэг авах ажиллагааг зайлшгүй ижил хүйсийн алба хаагчаар гүйцэтгүүлэх, энэ чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх зайлшгүй шаардлагатай байна. Тус салбарт эмэгтэй алба хаагч цөөн, ажилладаг эмэгтэй алба хаагчид нь даргын туслах, тоон мэдээлэл гаргах зэрэг тухайн алба нэгжийн бичиг хэргийн ажлыг хийдэг байна.

Хүүхэд холбогдсон эсвэл хохирогчоор оролцож байгаа хэргийг мөрдөн шалгадаг дагнасан ажилтан ажилладаггүй. Гэмт хэргийн талаар гомдол мэдээлэл хүлээн авах, шалгах ажиллагаанд сэжиглэгдэж байгаа хүн нь хүүхэд байх тохиолдолд хэрхэн шалгах талаар зохицуулалт байхгүй, “гэрч” гэж мэдүүлэг авдаг нь тухайн хэргийг мөрдөн шалгах ажиллагааны хамгийн чухал хэсэгт хүүхэд хамгаалал огт хэрэгжихгүй байна.

Эрүүгийн хэрэгт холбогдсон хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсны төлөөлөгч, оролцох боломжгүй бол сурган хүмүүжүүлэгч эсвэл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтан оролцохоор хуульчилсан боловч зарим ажиллагаанд зөвхөн “хууль ёсны төлөөлөгч” гэж зохицуулсан. Хохирогч хүүхдийн **“хууль ёсны төлөөлөгч”**-өөр зөвхөн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилох, өмгөөлөгчийг зайлшгүй байлцуулдаггүй.

Хохирогч хүүхдийг хамгаалах тогтолцоог зөвхөн ТХБ гэдгээр хязгаарлах хандлага түгээмэл байна. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дах хүүхдийн хууль ёсны эрх ашиг хэрхэн хөндөгдөж, хэрхэн шийдвэрлэгдсэн талаар мэдээлэл гардаггүй. Гэр бүл цуцлах хэрэгт хүүхдийн асрамжийг тогтоох зорилгоор Хүүхдийн санал асуух ажиллагаанд хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах талаар хуулиар нарийвчлан зохицуулаагүй.

Өсвөр насны этгээдтэй холбоотой гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд зөвхөн “хорих ял шийтгүүлсэн” этгээдтэй холбоотой хөнгөвчилсөн зохицуулалт үйлчилж байна.

5.2 САНАЛ ЗӨВЛӨМЖ

Хүүхэд хамгааллын тогтолцооны эрх зүйн орчинг бэхжүүлэх талаар

- Хүүхэд хамгааллын асуудлаар холбогдох хуулиудын шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлтөд хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх талаас нь хандаж, оролцогч талуудын хүний нөөц, чадавх, нөөцийн хуваарилалтыг тодорхой болгон харилцан уялдаатай хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхаарч ажиллах;
- Бүх хуулиудад хүүхдийн эрхийн зарчмаар үнэлгээ хийх ажлын үе шаттай эхлүүлэх;
- Гэр бүлтэй ажиллах эрх зүйн орчны шинэчлэлд нэн тэргүүнд гэр бүлийн асуудлаарх мэргэжилтнүүд, үйлчилгээ үзүүлэгч талуудыг чадавхжуулах, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлын арга зүйг нэвтрүүлэн хөгжүүлэх талаар анхаарах;
- Хүүхэд хамгааллын тогтолцооны бүх хүрээнд хүүхдийн оролцоог хангаж ажиллах дүрэм, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх арга зүйд оролцогч бүх талуудыг сургах;
- Гэр бүлийн харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгохдоо гэр бүлийн гишүүд болон донтох эмгэгт хамаарал бүхий этгээдэд үзүүлэх үйлчилгээний төрөл, нөхцөлийг нарийвчлан тодорхойлох;

Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлэх талаар

- Хүүхдэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийн механизмыг зөвхөн бүтэц, чиг үүргийн хувьд гэр бүл, залуучуудын хөгжлийн асуудлаар өргөжүүлсэн өнөөгийн бүтцийг шинэчлэн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага болгохоор хянаж үзэх. Ингэхдээ хуульд заасан үйлчилгээг ялангуяа хүүхэд, гэр бүлд үзүүлэгч талуудын оролцоо, үйл ажиллагааг зохицуулах, хянах эрх хэмжээг нэмэгдүүлэх;
- Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь богино, дунд хугацааны стратегийг хүүхдийн эрхийн тухайн нөхцөл байдалтай уялдуулан үр дүнтэй төлөвлөж, үйл ажиллагааны чиглэлийг эрэмбэлж ажиллах, хэрэгжилтэд өөрийн болон хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, үр дүнд суурилсан өөрчлөлтийг тусган хэрэгжүүлэх;
- Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төв, орон нутгийн байгууллагад удирдлага болон ажилтнууд нь хуульд заасан шалгуурын дагуу заавал мэргэжлийн байх, тэдний тогтвортой байдлыг хангах, ажлын байран дээр мэргэшүүлэн сургах. Хүүхэд хамгааллын ажилтнуудыг хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, хүүхдийн хөдөлмөр, гэрч хохирогч болон хууль зөрчсөн хүүхэдтэй ажиллах асуудлаар яаралтай мэргэшүүлэн, үйлчилгээ үзүүлэх эрхийг (лицензжүүлэх) олгох;
- Хүүхдийн эрхийн улсын байцаагчийг дагнасан байдлаар ажиллуулах, квот тогтоон орон тоог нэмэгдүүлэх. Тухайн байцаагч нь харьяа орон нутгийн гэр бүл, эцэг эх/асран хамгаалагч, өмчийн бүх хэлбэрийн байгууллагатай хамтран хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх ажлыг хэрэгжүүлэх;
- Хүн ам хэт төвлөрсөн нийслэлийн СХД, БЗД-ийн ГБХЗХГ-ын бүтцийг шинэчилж, хороо, хүүхэд, гэр бүлд ойртуулсан нөхцөлөөр салбар нэгжийг бий болгох мөн

үйлчилгээний хүртээмжийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх замаар нэмэгдүүлэх;

Хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг хангах талаар

- Хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлэх механизмыг хүүхдийн тоо, хүн ам зүйн ачааллыг харгалзан нийслэлийн хорооны Хамтарсан багт шинээр сэтгэл зүйч, нийгмийн ажилтныг орон тоогоор нэмж ажиллуулах;
- Орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл, Хамтарсан баг, хууль зүйн хорооны гишүүдийн ажил үүргийн хуваарьт тус нэгжид гүйцэтгэх үүргийн нарийвчлан тусгах, төлөөлж буй салбартаа хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын үйлчилгээг дэмжих, хамтын ажиллагааны гүүр болж ажиллах эрх зүйн орчныг бий болгох;
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгч Хамтарсан баг, хууль зүйн хороонд үйлчилгээг үр дүнтэй үзүүлэхэд шаардлагатай төсвийг хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын төсөвт суулгах, мөн үйлчлүүлэгчийн үнэлгээ, үйлчилгээний чанар үр дүнд суурилсан урамшууллыг улирлаар гишүүн бүрт олгох;
- Хүүхэд сургуулийн орчноос авах хүүхэд хамгааллын үйлчилгээг тодорхойлох, хүүхэд ээлтэй байдлаар хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох;
- Сургуулийн орчинд хариу үйлчилгээнд хамрагдсан хүүхдийг нөхөн сэргээх, нийгэмшүүлэхэд хүүхэд түүний ар гэртэй сургууль, багш, мэргэжилтнүүд хамтран ажиллах нөхцөлийг бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Нийслэлийн түвшинд хороо бусад нэн шаардлагатай орон нутагт хүүхэд хамгааллын тулгамдсан, онцлог асуудлаар тусгайлах мэргэжилтний зөвлөгөө, мэдээлэл, үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэх тогтолцоог бий болгох;
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд байгаа хүүхдийн гэр бүл, асран хамгаалагчдад эрсдэлийг арилгах зорилгоор гэр бүлд чиглэсэн цогц үйлчилгээг хүүхдийн үйлчилгээтэй зэрэгцүүлэн үзүүлэх. Эдгээр үйлчилгээнд нийгмийн халамж; хөдөлмөр эрхлэлт; ажлын байранд зуучлах; мэргэжил олгох; санхүүгийн тэтгэлэг; гэр бүлийн харилцаа; хүмүүжлийн эерэг арга; сэтгэл зүйн зөвлөгөө; донтох эмгэгийн нөхөн сэргээх болон эрүүл мэндийн бусад үйлчилгээг байгууллага, салбар бүр чиг үүргийн хүрээндээ харилцан уялдаатай, цогц төлөвлөж бүрэн хэрэгжүүлэх;
- Хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдүүдэд хүүхэд хамгаалал, нийгмийн болон бусад үйлчилгээг салбар дундын оролцогч талууд хамтран төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчныг нэн даруй бүрдүүлэх;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний явц, үр дүнг шинжлэх, мэдээллийг үүрэг хүлээгч, үйлчилгээ үзүүлэгч талуудад шуурхай хуваалцах, хариу арга хэмжээний уялдааг хангах мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх. Тус системийг бусад салбарын мэдээллийн сантай харилцан мэдээлэл солилцох механизм болгох;

Хүүхэд хамгааллын хамтын ажиллагааны талаар

- Хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэхэд оролцогч бүх талуудын үүрэг, ажил үйлчилгээний учрыг олоход хялбар, уялдаа холбоог бүрэн тодорхойлсон нийтлэг бодлогыг хамтран боловсруулж турших;

- Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих Ажлын хэсэг, Хүүхдийн төлөө зөвлөл зэрэгт иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг нэмэгдүүлэх замаар оролцоо, ил тод байдал, хариуцлага, хяналт, нөлөөллийг нэмэгдүүлэх;
- Магадлан итгэмжилсэн байгууллагуудаар хүүхэд хамгааллын мэргэшсэн хариу үйлчилгээ үзүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх;
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг олон нийтийн оролцоо, гэр бүл, мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагад суурилсан байдлаар хөгжүүлэх;
- Хүүхэд хамгааллын талаарх олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөхөд гол хэрэгсэл болж буй Байгууллагын хүүхэд хамгааллын загвар бодлого, Эцэг эхийн зөвлөлийн удирдамжийг иргэний нийгмийн байгууллага болон бусад талуудтай хамтран тууштай хэрэгжүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, үр дүнг үнэлэх;
- Иргэний нийгмийн байгууллагууд хариуцлагатайгаар хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх үүргээ биелүүлэх, хамтран ажиллах, төрийн байгууллага, албан тушаалтны хариуцлагыг шаардаж ажиллах;
- Олон улсын жишигт нийцсэн хүүхэд хамгааллын тогтолцоог хөгжүүлэх, тэр дундаа хүний нөөцийг бэхжүүлэх, мэргэжлийн арга зүйгээр дэмжих, сайн туршлагыг нутагшуулахад Олон улсын байгууллагууд хамтран ажиллах;

Хүүхэд хамгааллын нөөц, чадавхийг бэхжүүлэх талаар

- Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага салбарын хүний нөөцийн чадавхийг стандартчилагдсан хөтөлбөрөөр бэхжүүлэх, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх эрх олгох; тогтвортой ажиллуулах, карьер хөгжил, мэргэшсэн байдлыг үнэлэх систем бүхий хүний нөөцийн бодлого, төлөвлөлттэй болох;
- Хүүхэд хамгаалалд оролцогч салбарын ажилтан, мэргэжилтэн, албан хаагчид зориулсан хүүхэд хамгааллын үйлчилгээний онол, арга зүйн сургалтын хөтөлбөрийг боловсруулж төрийн байгууллага, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын баазыг (Удирдлагын академи, Боловсролын хүрээлэн гэх мэт) түшиглэн хэрэгжүүлэх. Иргэний нийгмийн байгууллагуудыг хамрагдах боломжоор хангах;
- Хүүхэд хамгааллын төсвийг олон нийтэд ил тод болгох. Ингэхдээ төсвийн төлөвлөлт эх үүсвэр тус бүрээр, зарцуулалтыг тайлагнах; төсвийн зарцуулалтын үр дүнд тогтмол шинжилгээ хийн хүүхэд хамгаалалд гарч буй үр дүн, амжилтуудын талаар хүртээмжтэйгээр мэдээлэх;
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний нэгж бүрийн зардлын тарифыг нарийвчлан судлах (тухайлбал сэтгэл засал); жишиг норматив гаргах улмаар Засгийн газрын тогтоолоор санхүүжилтийн журам гаргаж мөрдөх; санхүүжүүлэх үүрэг, чиглэл, ангиллыг тодорхой болгох. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 зүйлд заасан санхүүжилттэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан, зардлыг ангиллыг боловсрол, халамж, эрүүл мэндийн зардалтай давхцуулалгүй тогтоох, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийн зарцуулалтыг тодорхой болгох;
- Хүүхэд хамгааллын дунд хугацааны төлөвлөгөө, зардлын жишиг норм, норматив, тарифт үндэслэн санхүүгийн төлөвлөгөөг эх үүсвэр тус бүрээр гаргах;
- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлд санхүүжилтийн төлөвлөлт, төлөвлөлтийн үйл явц, зарцуулалтын зориулалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилт зэргийг тусгах. Тухайлбал хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нийт санхүүжилтийн тодорхой (1/2-ээс илүү) хувийг зарцуулах тухай холбогдох хуульд тусгах;

Гэрч, хохирогч, хууль зөрчсөн хүүхдийн эрхийн хангах талаар

- Хүүхэд холбогдсон болон хохирогч болсон эрүүгийн болон зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийг Улаанбаатар хотод бий болгох
- Эрүүгийн хэрэгт холбогдсон хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрд хүүхдийн эрхийг хамгаалах талаар зайлшгүй оруулах
- Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан /Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг/ үйлдсэн насанд хүрсэн этгээдэд тэнсэн харгалзах ял өгдөг атлаа энэ төрлийн хэрэгт холбогдсон хүүхдүүдэд бүгдэд нь хорих ял оногдуулах шийдвэр гаргаж байгааг өөрчлөх, хүүхдэд хорихоос өөр төрлийн хариуцлага оногдуулах эрх зүйн орчныг бий болгох
- ЦЕГ, УЕП болон ШЕЗ-ийн тоон мэдээллийг харьцуулж гаргадаг байх
- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхэд бие даан нэхэмжлэл гаргасан тохиолдолд бүртгэх боломжтой байх
- Гэр бүл цуцлах хэрэг маргааны үед хэдэн хүүхдийн хууль ёсны эрх ашиг хөндөгдөж, хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаар мэдээллийг шүүхийн программд тусгах /программд нь энэ төрлийн бүртгэлийг хийх цонх байхгүй/
- Хүүхдийн санал асуух ажиллагааг ИХШХШТХ-аар нарийвчлан зохицуулах,
- Гэр бүл цуцалснаас хойш хүүхдийн эрх хэрхэн хамгаалагдаж байгаад хяналт тавьдаг механизмыг бий болгох
- Гэмт хэргийн талаар гомдол мэдээлэл хүлээн авах, шалгах ажиллагаанд сэжиглэгдэж байгаа хүн нь хүүхэд байх тохиолдолд хэрхэн шалгах талаар зохицуулалтыг бий болгох
- Мөрдөн байцаалтын ажиллагаа эхлэхээс өмнө буюу сэжигтнээр тооцогдохоос өмнө хийгдэх хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаанд хүүхдийг хэрхэн оролцуулах, хувийн байдлыг тогтоох ажиллагааны явцад насанд хүрээгүй хүүхдийг хэрхэн хамгаалах талаар зохицуулалтыг бий болгох
- Хүүхдээс “гэрч” гэж мэдүүлэг авдаг байдлыг таслан зогсоох.
- Эрүүгийн хэрэгт холбогдсон хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх зарим ажиллагаанд зөвхөн “хууль ёсны төлөөлөгч”-өөр дамжуулан оролцохоор байгааг өөрчлөх, хүүхэдтэй ашиг сонирхлын зөрчилтэй, хүүхдийг хамгаалах боломжгүй хууль ёсны төлөөлөгчийн оронд хүүхдийн эрх ашгийг хамгаалах боломжтой бусад субъект оролцох бололцоог бий болгох
- Хохирогч, холбогдогч эмэгтэй болон эрэгтэй хүүхдээс /ялангуяа хүчингийн гэмт хэргийн үед/ мэдүүлэг авах ажиллагааг зайлшгүй ижил хүйсийн алба хаагчаар гүйцэтгүүлэх, энэ чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх
- Хохирогч хүүхдийн “хууль ёсны төлөөлөгч”-өөр зөвхөн эцэх эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилохоос гадна хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадах сурган хүмүүжүүлэгч эсвэл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын алба хаагчийг томилох боломжийг хуулиар бий болгох
- Хохирогч хүүхдийг зайлшгүй хууль зүйн туслалцаагаар хангаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгдөг байх талаар хуульд тусгайлан заах
- Хохирогч хүүхдийг хамгаалах тогтолцоог зөвхөн “түр хамгаалах байр” гэдгээр хязгаарлах бус хүүхдийн тав тухтай, айдасгүй байх бүхий л бололцоог хангаж, гэмт хэрэгт холбогдсон этгээдийг тусгаарлах арга хэмжээ авдаг байх эрх зүйн орчныг бий болгох
- Хорихоос бусад төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын тогтолцоог бий болгох. Тухайлбал, хорих ял оногдуулсан шүүхийн

шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны этгээдэд хэрхэн хяналт тавих, сургууль, боловсрол эзэмших эрхийг нь хэрхэн хангах, хүүхэд хамгааллын бусад байгууллагатай хэрхэн хамтран ажиллах талаар зохицуулаагүй байна.

6. ХАВСРАЛТ



6. ХАВСРАЛТ

6.1 ХАВСРАЛТ-1 ГБХЗХГ-ЫН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ

ЗГХА- ГБХЗХГ нь Хүүхэд хамгааллын тухай хуулиар Засгийн газар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн өмнө хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог удирдан зохион байгуулахдаа:

- жил бүр тайлагнах; хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, ажлыг нь дүгнэх;
- хүүхэд хамгааллын сургалтын хөтөлбөр батлан хэрэгжүүлэх,
- хүүхэд хамгааллын чиглэлээр эрдэм, судалгааны ажил явуулах;
- үйлчилгээний нэр төрөл, чанарыг дээшлүүлэх,
- үнэлгээнд үндэслэн жилийн ажлыг төлөвлөн зохион байгуулах;
- тогтолцоонд оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжих;
- эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх;
- төрийн байгууллага, хуулийн этгээд, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын ажилтан, алба хаагчид, үйлчилгээ үзүүлэгчдийг сургах;
- хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн иргэн, хуулийн этгээд, хууль зөрчигч хүүхэд, гэрч, хохирогч хүүхдийн талаар мэдээллийн сан бүрдүүлж ашиглах үүрэг хүлээдэг.

Харин орон нутаг буюу аймаг, нийслэл, дүүргийн ГБХЗХБ-ууд нь хүүхэд хамгааллын орон нутгийн тогтолцоог удирдан:

- Мэдээлэл судалгааг дүгнэн, цаашдын чиглэлийг тодорхойлох;
- төрийн байгууллага, хуулийн этгээдийн алба хаагчдыг сургах,
- Энэ хуулийн хэрэгжилтэд 3 жил тутамд хяналт үнэлгээ хийх;
- нийгмийн ажилтан, Хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаархи мэдээллийн сан бүрдүүлж, ашиглах,
- эрдсэлт нөхцөлд байгаа хүүхдийн халамж, хамгаалал үйлчилгээний талаар бүртгэл хөтөлж, ХНХЯ-д хүргүүлэх;
- эцэг, эх, асран хамгаалагчийн сайн дурын болон албадан сургалтыг зохих талтай хамтран зохион байгуулах;
- гэр бүлээсээ дайжсан, эсхүл гадуур байгаа хүүхдийг бүртгэж, гэр бүлд нэгтгэх ажлыг хамтран гүйцэтгэх үүрэгтэй.

ГБХТТХ –аар:

ГБХЗХ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар :

- ТХБ, сэтгэл зүйн зөвлөгөөний, халамжийн, хүүхэд хамгааллын үйлчилгээнүүдийн мэдээллийн сан бүрдүүлэх;
- асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээнд холбон зуучлах, хяналт тавих журмыг батлах, хэрэгжилтийг хянах;
- хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх тусгай утасны үйлчилгээг улсын хэмжээнд зохион байгуулах;
- хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний журмыг баталж, хянах үүрэгтэй.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн ихэнх хэлбэрийг Монгол Улсын Эрүүгийн болон зөрчлийн тухай хуулиар гэмт хэрэг, зөрчилд тооцох тул эдгээр байгууллагууд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай дагуу

- Чиг үүрэг, эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжийг олон нийтэд таниулах,
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бусад байгууллагад дэмжлэг үзүүлэх, харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах;
- Эрхлэх асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Эрхэлсэн асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгах тухай мэдэгдэл хүргүүлэх, биелэлтэд хяналт тавих үүрэгтэй.

6.2 ХАВСРАЛТ-2 ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ НАСНЫ ХЯЗГААР ГЭМТ ХЭРГИЙН ТӨРӨЛ, АНГИЛАЛ, ЯЛЫН ХЭМЖЭЭ, ХОХИРОЛ ШААРДСАН БАЙДЛЫН ХАРЬЦУУЛАЛТ

Эрүүгийн хариуцлага хүлээх насны хязгаарыг гэмт хэргийн төрөл, ангилал, ялын хэмжээ, хохирол шаардсан байдал зэргээр харьцуулахад					
№	Насны хязгаар	Гэмт хэргийн төрөл	Хохирол шаардсан эсэх	Ялын төрөл, хэмжээ	Гэмт хэргийн ангилал
1	14-16 нас	10.1- Хүнийн алах	Тийм	8-15 жил хүртэл хорих ял	Хүнд
				12-2 жил хүртэл хорих ял	Хүнд
2		11.1-Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	Тийм	10.000-40.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,эсхүл 2-8 жил хүртэл хорих	Хүнд
				5-12 жил хүртэл хорих ял	Хүнд
3		12.1- Хүчиндэх	Тийм	1-5 жил хүртэл хорих ял	Хөнгөн
				5-12 жил хүртэл хорих ял	Хүнд
				8-15 жил хүртэл хорих ял	
				12-20 жил хүртэл хорих ял	
4		17.1-Хулгайлах	Тийм	240-720 цаг хүртэл нийтэд тустай ажил хийлгэх,	Хөнгөн
				6 сараас 5 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах	
				6 сараас 5 жил хүртэл хорих ял	
				2-8 жил хүртэл хорих ял	Хүнд
				5-12 жил хүртэл хорих ял	
5		17.2-Дээрэмдэх	Тийм	6 сараас 5 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах	Хөнгөн
				6 сараас 5 жил хүртэл хорих ял	
			Үгүй	2-8 жил хүртэл хорих ял	Хүнд
			Тийм	5-12 жил хүртэл хорих ял	
6		17.8-Эд хөрөнгө устгах, гэмтээх	Тийм /бага хэмжээ/	450-5.400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох	Хөнгөн
				240-720 цаг хүртэл нийтэд тустай ажил хийлгэх,	
				1 сараас 1 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах,	
			Тийм	1350-10.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох	Хөнгөн
				6 сараас 2 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах,	
				6 сараас 2 жил хүртэл хорих ял	
			Тийм/Үгүй	10.000-40.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,	Хүнд
				2-8 жил хүртэл хорих ял	
7		20.7-Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	Үгүй	1-5 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах	Хөнгөн
				1-5 жил хүртэл хорих ял	
			Үгүй	2-8 жил хүртэл хорих ял	Хүнд
			Үгүй	5-12 жил хүртэл хорих ял	

			Үгүй	12-20 жил хүртэл хорих ял	
8	14-16 нас	20.16-Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	Тийм	1-5 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах	Хөнгөн
				1-5 жил хүртэл хорих ял	
			Тийм	2-8 жил хүртэл хорих ял	Хүнд
9		26.1-Цахим мэдээлэлд хууль бусаар халдах	Үгүй	2.700-10.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,	Хөнгөн
				6 сараас-2 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах	
				6 сараас 2 жил хүртэл хорих ял	
			Тийм	5.400-27.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,	Хөнгөн
				1-5 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах,	
				1-5 жил хүртэл хорих ял	
			Үгүй	10.000-40.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,	Хүнд
				2-8 жил хүртэл хорих ял	
			Үгүй	5-12 жил хүртэл хорих ял	
10		26.2-Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ,техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах	Үгүй	5.400-27.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,	Хөнгөн
				1-5 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах	
				1-5 жил хүртэл хорих ял	
11		26.3-Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах	Үгүй	5.400-27.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,	Хөнгөн
				1-5 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах	
				1-5 жил хүртэл хорих ял	
12		29.8-Террор үйлдэх	Тийм	12-20 жил хүртэл хорих ял	Хүнд

6.3 ХАВСРАЛТ-3 ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ ГЭМТ ХЭРГИЙН МӨРДӨН ШАЛГАХ, ШҮҮХЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГАНЫ ЯВЦ

Нэгдүгээр үе шат буюу Гомдол мэдээллийг шалгах шат:	a. ЭХХШТХ-ийн 30 дугаар бүлэг нь бүхэлдээ “Хэрэг бүртгэлт”-ийн ажиллагааны талаар байгаа бөгөөд гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл хүлээн авч шалгах ажиллагааг юуны түрүүнд хийдэг. b. Гэмт хэргийн талаар гомдол мэдээллийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор мөрдөн шалгах ажиллагаа хийдэг бөгөөд энэ үе шатанд өсвөр насны гэмт хэрэгт холбогдсон байж болзошгүй этгээдээс гэрчийн мэдүүлэг болон бусад төрлийн ажиллагаа хийдэг. c. Ярилцлагад оролцсон мөрдөн байцаагч, прокурорын ажилтнуудын мэдээллээр прокурорын нэгдсэн мэдээлэлд бүртгэгдэж, өсвөр насны хүүхэд гэмт хэрэгт холбогдсон талаар мэдээллийг эрх бүхий этгээдүүд солилцох хүртэл тодорхой хэмжээний мөрдөн байцаалтын ажиллагаа хийгдэж, хүүхдийн эрх зөрчигдөж болзошгүй тохиолдол гардаг талаар дурдсан. d. Гомдол ирсний дараа хийх мөрдөн шалгах ажиллагаанд: 1. үзлэг хийх; 2. шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах; 3. хохирогч, гэрчээс мэдүүлэг авах; 4. хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах; 5. эд хөрөнгийг битүүмжлэх. 6. шинжээч томилох гэсэн ажиллагаа хийдэг байна. e. Энэ хэсэгт заасны дагуу гэрчийн мэдүүлэг авахад ЭХХШТХ-ийн 25.3 дугаар зүйлийн 2, 3-д заасны дагуу “Арван найман насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахад түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгана”, “Арван найман насанд хүрээгүй хүний эрх ашиг зөрчигдөх бодит үндэслэл байвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүнийг оролцуулахгүй байж болох ба өмгөөлөгчийг оролцуулна” гэж зохицуулсан. f. Өөрөөр хэлбэл хэрэгт холбогдсон байж болзошгүй хүүхэд өмгөөлөгч, хууль зүйн туслалцаагаар хангагдаагүй байхдаа гэрчийн мэдүүлэг өгөх шаардлага үүсдэг байна. g. Мөн энэ үе шатанд үзлэг хийх, хурууны хээ, ул мөрний хэв авах зэрэг ажиллагааны явцад насанд хүрээгүй хэрэгт холбогдсон этгээдийн эрхийг хэрхэн хангах талаар хуулиар нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. h. Мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа дууссаны дараа хэрэг бүртгэлийн хэрэг нээх эсвэл хаах талаар прокурорт саналаа хүргүүлнэ. i. Мөрдөгч хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн бол прокурорт даруй мэдэгдэн, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, тогтоолыг 72 цагийн дотор прокурорт танилцуулна.
--	--

Хоёрдугаар үе шат буюу Хэрэг бүртгэлийн ажиллагаа:	a. Хэрэг бүртгэлийн үндсэн хугацаа нь хэрэг бүртгэлийн хэрэг нээснээс хойш 1 сар байна. b. Хэрэг бүртгэлийн явцад гэмт хэрэг үйлдэгдээгүй, эсхүл тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчлийн шинжтэй аль нь болохыг энэ үе шатанд тогтооно. c. Мөрдөгч хэрэг бүртгэлтийг дуусгаж, дараах саналын аль нэгийг гаргаж хэргийн хамт ажлын 3 өдрийн дотор прокурорт хүргүүлнэ: 1. хэрэг бүртгэлийн хэргийг хаах. 2. эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах. d. Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоол үйлдэж, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ. e. Энэ үед хийгдэх ажиллагаа нь дээр /5 дугаар/ хэсэгт заасан ажиллагаа хийгдэх бөгөөд эдгээр ажиллагааны явцад хийгдэх аливаа ажиллагаанд өсвөр насны хүүхдийг хэрхэн оролцуулах нь тодорхойгүй байна.
Гуравдугаар үе шат буюу Мөрдөн байцаалтын ажиллагаа:	a. Яллагдагчаар татах тогтоол үйлдсэнээс хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл хэргийн талаар нотлогдвол зохих байдлыг тогтоох зорилгоор явуулж байгаа хуульд заасан ажиллагааг мөрдөн байцаалт гэнэ. b. Баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ. c. Өсвөр насны яллагдагчийг хууль ёсны төлөөлөгч⁹⁵ өөр дамжуулан дуудан ирүүлнэ. d. ЭХХШТХ-д заасны дагуу өсвөр насны хүний хууль ёсны төлөөлөгч энэ үеэс албан ёсоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжтой болно. e. Энэ үе шатанд сэжигтний хувийн байдлыг тогтоох, мэдүүлэг авах ажиллагаа хийхээс гадна шаардлагатай тохиолдолд баривчлах ажиллагаа явуулдаг. f. Өсвөр насны яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэг хаалттай явагдах ба өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна. Хувийн байдлыг тогтоох: g. ЭХХШТХ-ийн 31.3 дугаар зүйлийн 4-д заасны дагуу сэжигтний хувийн байдлыг тогтооход өсвөр насны сэжигтнийг хэрхэн оролцуулах нь тодорхойгүй байна. h. Тухайлбал тус хэсэгт заасны дагуу хувийн байдлын талаар нэмэлт мэдээлэл авах, биед үзлэх хийх, биологийн дээж авах зэрэг хүүхдийн бие, сэтгэл санаанд шууд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй ажиллагаанд өсвөр насны сэжигтэн, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчийг хэрхэн оролцуулахыг тодорхой зохицуулаагүй байна.

⁹⁵ 9.5 дугаар зүйл. Мөрдөгч, прокурор дараахь хүнийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтооно:

1.1.өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг;

2.Энэ зүйлийн 1.1-д заасны дагуу арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно.

	i. Харин тус хуулийн 18.3 дугаар зүйлд өсвөр насны сэжигтний хувийн байдлыг тогтоох дараах ажиллагааг хийнэ: 1. төрсөн он, сар, өдөр, нас; 2. амьдралын нөхцөл байдал ба хүмүүжилтэй холбоотой мэдээлэл; 3. гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл; 4. гэмт хэрэг хамтран үйлдэгч байсан эсэх; 5. сэтгэцийн өвчинтэй холбогдолгүй боловч ухаан санаа нь гүйцэд хөгжөөгүйн улмаас өөрийнхөө үйлдлийн холбогдлыг бүрэн ойлгож байгаа эсэхэд эргэлзээ төрвөл шинжээч томилж, дүгнэлт гаргуулах. Мэдүүлэг авах: j. Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг заавал оролцуулна. k. Шаардлагатай гэж үзвэл сурган хүмүүжүүлэгч, эсхүл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг байлцуулж болдог. l. Хуулийн энэ хэсэгт заасан “шаардлагатай” гэснийг ялгаатай байдлаар хэрэглэдэг нь ярилцлагын явцад ажиглагдсан. m. Тухайлбал эцэг эх нь оролцох бололцоогүй бол багшийг оролцуулах, заримдаа багш нь ирэх боломжгүй гэвэл оролцуулахгүй байх, эсвэл сургууль, багшид хүүхэд өөрөө мэдэгдмээргүй байвал оролцуулахгүй гэх зэргээр харилцан адилгүй, оролцогч, мөрдөгчдийн өөрсдийн үзэмжээр хэрэглэж байна. n. Мөн эрүүгийн хэрэг үүсгэсэн, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад өсвөр насны сэжигтний эрхийг хэрхэн хангасан, сурган хүмүүжүүлэгч болон төрийн захиргааны ажилтан хэрхэн оролцсон талаар мэдээллийн сан үүсдэггүй байна. o. Хууль ёсны төлөөлөгчийг өсвөр насны сэжигтний хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй гэж мөрдөгч үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахгүй. p. Өсвөр насны сэжигтэн, түүний хууль ёсны төлөөлөгч өмгөөлөгч сонгоогүй бол томилогдсон өмгөөлөгчийг оролцуулна. q. Монголын хуульчдын холбоо, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон Хууль зүйн туслалцааны төвийн Улсын өмгөөлөгч нар хүүхэд холбогдсон хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлж томилогдон ажиллаж байна. r. Нэгэнт сэжигтнээр тооцож мэдүүлэг өгч байгаа үед өмгөөлөгчийг оролцуулах эрхийг хангаж байгаа боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцож байгаа өмгөөлөгчдийн ур чадвар, мэдлэг дутагддаг талаар ярилцлагын явцад өмгөөлөгч нар хэлж байлаа. s. Арван найман насанд хүрээгүй хүнээс авах мэдүүлгийг 2 цагийн хугацаагаар тасралтгүй явуулж болох ба түүнээс илүү хугацаагаар явуулах бол 30 минутын завсарлага авна. Нэг удаагийн мэдүүлэг авах нийт хугацаа 4 цагаас илүүгүй байна. Баривчлах:
--	--

	t. Яллагдагчаар татагдсан тогтоол гарснаас хойш сэжигтнийг дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, оргон зайлсан, гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэл байгаа зэрэг 5 үндэслэлээр⁹⁶ сэжигтнийг баривчилдаг. Энэ үндэслэл дотор өсвөр насны хүнд хамааралгүй байх үндэслэлийг тодорхойлоогүй бөгөөд яг л насанд хүрэгчтэй адил нөхцөл тавьсан байгааг цаашид анхаарах хэрэгтэй. u. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрлөөр болон шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчилдаг бөгөөд өсвөр насны сэжигтнийг зайлшгүй баривчлах шалтгаан үндэслэлийг тусгайлан зохицуулах, шүүхээс баривчлах шийдвэр гаргахдаа хүүхдийн хувийн байдлыг нь хэрхэн харгалзан үзэж шийдвэрлэх тухай зохицуулалтгүй байна. v. Өсвөр насны сэжигтнийг баривчилсан, цагдан хорьсон тухай түүний гэр бүлийн гишүүн, хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид нь 6 цагийн дотор мэдэгдэнэ. /насанд хүрэгчтэй яг адил хугацаа/ w. Баривчлагдсан өсвөр насны сэжигтнийг баривчлагдсан арван найман насанд хүрсэн хүн, цагдан хоригдсон арван найман насанд хүрсэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс тусад нь байлгана. x. Баривчлагдсан өсвөр насны сэжигтнийг суллахдаа түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчийн аль нэгэнд хүлээлгэн өгнө.
Дөрөвдүгээр үе шат буюу Прокурорын хяналт:	a. Мөрдөн байцаалт явуулж дууссан хэргийн материалыг прокурор 14 хоногийн дотор хянаж хэргийг шүүхэд шилжүүлэх эсхүл хэрэгсэхгүй болгох эсэх талаар шийдвэр гаргана. b. Прокурор хэргийг шүүхэд шилжүүлэх үндэслэлтэй гэж үзвэл яллах дүгнэлт үйлдэн харьяалах шүүхэд хүргүүлнэ. Энэ ажиллагаанд өсвөр насны сэжигтнийг заавал өмгөөлөгчийнх нь хамт оролцуулна. c. Энэ үе шатанд анхаарал татсан нэг зүйл нь хэргийг хэрэгсэхгүй болгох нэг үндэслэл нь “гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон боловч ял оногдуулах насанд хүрээгүй” байх юм. d. Дээр дурдсан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх гурван үе шатанд хэрэгт холбогдсон өсвөр насны этгээдийн нас нь хүрж байгаа эсэхийг тогтоох ажиллагаа хийхэд нас хүрэхгүй нь илэрхий байхад прокурорын хяналт хүртэл хүүхдийг эрүүгийн хэрэгт холбож шалгах шаардлагагүй юм.
Тав болон зургаадугаар үе шат буюу Анхан, Давж заалдах болон Хяналтын шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх.	a. Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол бүхэлд нь эсвэл зарим хэсгийг хаалттай явуулна. b. Өсвөр насны шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч шүүх хуралдаанд нотлох баримт шинжлэн судлахад оролцох, шүүх хуралдаанд оролцогчийг татгалзан гаргах эрхтэй. c. Шүүх хуралдааны бусад үе шатад зөвхөн байлцах эрхтэй. d. Шүүх хуралдаанд хууль ёсны төлөөлөгч оролцох нь өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй гэж үзвэл түүнийг шүүх хуралдаанд оролцуулахгүй байх, эсхүл шүүх хуралдааны зарим хэсэгт оролцохыг хязгаарлаж болно.

⁹⁶ ЭХХШТХ-ийн 31.4 дүгээр зүйлийн 31.4.1

	e. Ийнхүү хязгаарласан эсвэл оролцуулаагүй тохиолдолд сурган хүмүүжүүлэгч эсвэл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг байлцуулж болохоор хуулийн 18.1-д зохицуулсан боловч 18.10-д “шүүх хуралдаанд оролцуулах” хэсэгт тусгайлан заагаагүй тул хүүхдийг зөвхөн өмгөөлөгчийнх нь хамт оролцуулах тохиолдолд цөөнгүй гардаг талаар шүүхийн ажилтнууд онцолсныг дурдах нь зүйтэй. f. Өсвөр насны шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгчийг оролцуулах шаардлагатай гэж шүүх үзээгүй бол түүний ирээгүй нь уг хэргийг хянан хэлэлцэх ажиллагааг хойшлуулах шалтгаан болохгүй гэсэн үндэслэл нь мөн хүүхэд шүүх хуралдаанд дангаараа оролцож нөхцөлийг бий болгож байна. g. Шүүх хуралдааны явцад өсвөр насны шүүгдэгчид сөргөөр нөлөөлж болох байдал тогтоогдвол талуудын хүсэлтээр шүүх хуралдаан даргалагч түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргаж болно гэсэн зохицуулалтыг ямар тохиолдолд хэрэгжүүлэх нь тодорхойгүйн улмаас шүүхийн үзэмжээр шийдвэрлэх тохиолдол цөөнгүй байна.
Ял оногдуулах:	a. Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд Эрүүгийн хуулийн наймдугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. b. Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна. c. Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно. d. Хорих ялын доод хэмжээг таван жил, түүнээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар хэрэглэж болохгүй. e. Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүн шүүхийн шийтгэх тогтоол гарах үед арван найман насанд хүрсэн бол шүүхийн тогтоол биелүүлэх хугацааг хойшлуулахгүй. f. Шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлд заасан журмаар тусгай ангид заасан хорих ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгана. g. Шүүх анх удаа Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж болно. h. Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

	i. Хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг ТЭНСЭЖ нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно.
--	---

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА!

